

Лиахона



**Бусдыг Христэд
ИТГЭХ ИТГЭЛТЭЙ
БОЛОХОД ТУСЛАХ
НЬ, 12-р хуудас**

**Ариун ойн цоорхойгоос
олж авсан 4 сургамж,
24-р хуудас**

**Христийн мэндэлсний
баярын бодит байдлыг
таньж мэдэх нь, 36-р хуудас**
**Өсвөр үеийнхний суралцах
материал: Цоо шинэхэн
хөрвөгч байх нь ямар
байдаг вэ?, 50-р хуудас**



“Талархал нь бидний эргэн тойронд болж буй ямар ч зүйлийг ялан дийлдэг. Энэ нь харамсал, урам хугаралт болон цөхрөлийг давж гардаг. Энэ нь зуны урин дулаанд ургах байгаа мэт өвлийн хахир хүйтэнд ч тун үзэсгэлэнтэй дэлгэрдэг.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Ямар ч нөхцөл байдалд талархалтай байх нь,” *Лиэхона*, 2014 оны 5-р сар, 92.



12

ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Дэлхийг Христийн хайраар дүүргэ

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Энх амгалангийн Ханхүү

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

12 Бусдыг Христэд итгэх итгэлтэй болоход туслах нь
Ахлагч Л.Том Пэрри

Та нар одоо өөрсдийн итгэлийг хүчирхэгжүүлж, бусдыг Аврагчид итгэх итгэлийн бат бөх сууринд эргэн ирэхэд нь тэдэнд тусалж чадна.

18 Газар бүрийн анхдагчид: Швед дэх Сүмийн өсөлт, цагаачлал ба хүч чадал

Инжер Хогланд

Их Эзэн саад бэрхшээлүүдийг үл харгалзан үзэсгэлэнтэй сайхан энэ оронд Өөрийн ажлыг яаравчлуулж байна.

24 Ариун ойн цоорхойгоос олж авсан сургамж

Ахлагч Марлин К.Жэнсэн

Бид мод хэрхэн ургаагүйг ажигласнаар өөрсдийгөө мөнхийн үнэнүүдэд хэрхэн бат бөх суурилуулах талаар суралцаж чадна.

30 Алдагдсан 500 жил: Малахигаас Иохан баптистыг хүртэл

С.Кэнт Браун, Ричард Нийцл
Хозапил нар

Хуучин ба Шинэ Гэрээний хоорондох үед юу болсон бэ?

36 Христийн мэндэлсний баярын бодит байдлыг таньж мэдэх нь

Бишоп Гари И.Стивэнсон

Бетлехемд мэндэлсэн бяцхан хүү бол жинхэнэ Гэтэлгэгч гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой.

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Гэрэл зураг чимэглэлийг Маттью Рэйер, Дотор талын хавтсанд: Гэрэл зургийг copyright Johnér/offset.com.

АЛБАД

8 Бид юунд итгэдэг вэ?: Аравны нэг нь Бурханы хаант улсыг байгуулахад тусалдаг

10 Эргэцүүлэл: Христийн мэндэлсний баярын гайхамшиг
Линдси Алдэр

11 Хуучин Гэрээний бошиглогчид: Малахи

40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой

80 Биднийг дахин уулзтал: Тэр амьдыг би мэднэ
Ахлагч Мэлвин Ж.Баллард
Есүс бол бидний амилсан Их Эзэн бөгөөд бид бүхнийг Түүнд ирэхэд урьдаг.



44 Бүх хэцүү асуултын хариулт

Р.Вал Жонсон

Хэрэв та эргэлзэж эхэлбэл доорх 5 зарчмыг санаарай.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой.

Санамж: Амьтад бидэнд дуулгавартай байдлын талаар хэрхэн зааж чадах вэ?

48 Аврагч ба ариун ёслол

Дэвид Л.Бэк

Аврагч ариун ёслолыг танилцуулж байхдаа “Намайг дурсаж үүнийг үйлд” гэв.

50 Сүмд нэгдэх нь хэцүү байж болно: Цоо шинэхэн хөрвөгч байх нь ямар байдаг вэ?

Жошуа Ж.Перки

Сүмд дасан зохицоход нь шинэ гишүүдэд хэрхэн тусалж чадах талаар суралц.

54 Асуулт, хариултууд

Сүмийн жишгүүдийг дагаснаас болж сургууль дээрээ шоолуулах үедээ би юу хийх хэрэгтэй вэ?

56 Номлолын талбараас: Ямар ч тэнгэр элч хэрэггүй байв

Жэниан Жэнсэн Нийлсэн

57 Зурагт хуудас: Өрөө гарга

58 “Би хаана байна вэ?”

Сүнслэг бэлэг, авьяас чадваруудаа хэрхэн нээн илрүүлж, хөгжүүлэх вэ?

Ахлагч Мэрвин Б.Арнолд

62 Хоёр дахь ирэлтэд хэрхэн бэлтгэх вэ

Ахлагч Даллин Х.Өүкс

Та маргааш Их Эзэнтэй уулзана гэдгээ мэдсэн бол юу хийх байсан вэ?

63 Христийн мэндэлсний баяраар өгөх миний бэлэг

Дастин Ворд

Би 8 настайдаа баптисм хүртсэн боловч ямар нэгэн зүйл амьдралыг минь үүрд өөрчлөх хүртэл ч сүмд огт явдаггүй байв.

64 Урагш тэмүүлэхэд бэлэн

Ричард М.Ромни,

Микий Шимомиа

12 настай 7 хүүхэд Хүүхдийн хэсгээс Залуу эрэгтэйчүүдийн эсвэл Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт дэвшин ороход ямар байсан тухайгаа хуваалцаж байна.



67 Онцгой гэрч: Есүс үнэхээр үхээд, амилсан уу?

Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

68 Хүүхдийн хэсгийг гэртээ авчрах нь: Бид өөрсдийн Аврагч Есүс Христийг дурсан санаж, бишрэн шүтдэг

Эрин Сандэрсон, Жин Бингам нар

70 Яанси

Ахлагч Брэнт Х.Нийлсон

Манай морь дуулгавартай байсансан бол жаргалтай амьдрах байсан.

71 Бидний хуудас

72 Дэлхий даяар найзуудтай болох нь: Би Шведийн Минна байна

Эми Жэйн Лэвитт

74 Христийн мэндэлсний анхны баяр

Жэн Вилкс

Энэ тоглолтыг жүжигчлэн тоглосноор Есүсийн төрөлтийг сана.

76 Доторхыг нь хар даа!

София С.

77 Хуучин Гэрээний судрын онцлох сэдэв: Давид болон Голиат

78 Бага насны хүүхдүүдэд зориулав: Христийн мэндэлсний баярын уур амьсгалыг өдөр бүр мэдрэх нь

Кэйт Стронгин

2014 ОНЫ АРВАНХОЁРДУГААР 15 NO. 6 ЛИАХОНА 10992 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Бойд К.Пакэр,
Л.Том Пэрри, Рассэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,
М.Рассэл Баллард, Ричард Г.Скотт, Робэрт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

Эрхлэгч: Крэйг А.Кардон

Зөвлөхүүд: Мэрвин Б.Арнолд, Кристоффэл Гуолдэн,
Ларри Р.Лоурэнс, Жэймс Б.Мартино, Иосеф В.Ситати

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсэнт А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Лиза С.Лопэз

Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон,
Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр,
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Минди Аннэ
Лийвигт, Майкл Р.Моррис, Салли Жонсон Оджерк,
Жошуа Ж.Пэркий, Жан Пинборору, Ричард М.Ромни,
Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй
П.Андрус, Мэндэл М.Бэнгли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,
Нэйт Гайнс, Коллиин Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан
Лодфрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брэд Тиэри,
П.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Кэвин К.Банкс, Конни Бөүторп Бриж, Жүүли
Бүрдэтт, Браян У.Гиги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,
Гэйл Тэйт Раффэрти

Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэдвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт
liahona.lds.org pyu; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Ли́ахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”
буюу “залагч”) албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагало, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2014 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Ли́ахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

December 2014 Vol. 15 No. 6. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required
for change of address. Include address label from a recent issue;
old and new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглах өгүүлэл, үйл ажиллагаанууд багтсан.
Дор хоёр жишээ өгөв.



**“Сүмд нэгдэх нь хэцүү байж болно:
Цоо шинэхэн хөрвөгч байх нь ямар
байдаг вэ?”, 50-р хуудас:** Энэ өгүүлэлд
гарч буй гишүүдийн хуваалцсан хөрвөл-
тийн түүхүүдийн тухай гэр бүлийнхэн-
тэйгээ ярилцах талаар бодож үз. Мөн
та (энэ өгүүлэлд дурдагдсан) хөрвөгчдөд
тохиолддог 10 сорилт бэрхшээлийн жаг-
саалтыг уншиж болно. Тойрог эсвэл сал-
барынхаа шинэ гишүүдийг эсвэл Сүмдээ
эргэн ирж эхэлж байгаа гишүүдийг гэр
бүлийнхэнтэйгээ хамт олж тогтоо. Дараа
нь эдгээр гишүүнтэй нөхөрлөж; тэднийг
нийгэм, соёлдоо дасан зохицож; сүнслэ-
гээр өсөж хөгжих хүч чадалтай болохоор
хичээх үед нь тэднийг дэмжих төлөвлө-
гөө гаргах талаар хамтран ажилла.

68-р хуудсан дахь **“Бид өөрсдийн
Аврагч Есүс Христийг дурсан санаж,**

бишрэн шүтдэг” мөн 74-р хуудсан дахь
“Христийн мэндэлсний анхны баяр”
зэрэг Христийн мэндэлсний баярын
сэдэвтэй үйл ажиллагааны санаануудаас
нэгийг сонгож, Аврагчийн төрөлтийг
тэмдэглэ. Жишээ нь, та 69-р хуудсан
дээрх хайрцгуудыг хайчилж, гэр бүлээ-
рээ Христийн мэндэлсний энэ удаагийн
баяраар болон бүтэн жилийн турш
Аврагчид хайраа хэрхэн үзүүлэх тухай
шийдэж болно. Мөн Есүсийн төрөлтийн
үйл явдлыг жүжигчлэн тоглоход нь гэр
бүлдээ туслахын тулд та 74-р хууд-
сан дээрх хадмал тайлбарыг ашиглах
талаар бодож үзэж болох юм. Эдгээр
үйл ажиллагааны аль аль нь Христийн
мэндэлсний баяраар Аврагч дээр оюун
бодлоо төвлөрүүлж сурахад хүүхдүүдэд
тань туслах болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Ли́ахона болон сүмийн бусад материалыг languages.lds.org хаягаар орж, олон хэлээр
үзэх боломжтой.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Амар амгалан, 7
Амилалт, 67
Анхдагчид, 18
Аравны нэг, 8
Ариун ёслол, 48
Бэрхшээл, 24, 54
Гэр бүл, 10, 40, 42
Гэрчлэл, 44
Дуулгавартай байдал,
30, 54, 70
Есүс Христ, 4, 7, 12, 36,
48, 57, 67, 68, 74, 80

Итгэл, 12, 24, 44, 80
Номлогчийн ажил, 12,
18, 50, 56, 76
Нөхөрлөл, 50
Судрууд, 30
Сэргээлт, 24
Сүнслэг бэлэгнүүд, 58
Талархал, 10
Урвалт, 30
Үйлчлэл, 4, 10, 12, 41,
43, 56, 78
Үхэл, 40

Хайр, 4, 40, 50
Хоёр дахь ирэлт, 62
Хөрвөлт, 42, 50, 63
Христийн мэндэлсний
баяр, 4, 10, 36, 40, 42,
43, 57, 63, 74, 76, 78
Хуучин Гэрээ, 11, 30
Швед, 18, 72
Эргэлзээ, 44



Ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх

ДЭЛХИЙГ ХРИСТИЙН ХАЙРААР ДҮҮРГЭ

Бид Христийн мэндэлсний баярын талаар бодоходоо ихэвчлэн бэлэг өгч, авах тухай боддог. Бэлэгнүүд нь эрхэм нандин уламжлалын нэг хэсэг байж болох ч, тэдгээр нь энэхүү баярын энгийн хүндэтгэлтэй байдлыг бууруулж, Аврагчийн төрөлтийг утга учиртай тэмдэглэхээс бидний анхаарлыг сарниулдаг.

Христийн мэндэлсний хамгийн даруухан баяр хамгийн дурсгалтай байж чаддагийг би хувийн туршлагаасаа мэднэ. Хүүхэд байхдаа авсан бэлэгнүүдээ өнөөгийн жишигтэй харьцуулахад мэдээж даруухан байсан. Би заримдаа нөхсөн цамц, бээлий эсвэл оймс бэлгэнд авдаг байлаа. Ах маань өөрийнхөө сийлсэн модон хутгыг надад бэлэглэсэн Христийн мэндэлсний нэгэн онцгой баярыг би сайн санадаг.

Христийн мэндэлсний баярыг утга учиртай болгоход үнэтэй бэлэг шаардлагагүй. 1987–1992 онд Далын гишүүнээр үйлчилж байсан ахлагч Глэн А.Раддын ярьсан нэгэн түүхийг би санаж байна. Олон жилийн өмнө, Христийн мэндэлсний баярын өмнөх өдөр тэрээр бишопуудын агуулахдаа зохицуулалт хийж байхдаа хотоо саяхан нүүж ирсэн, тусламж хэрэгтэй байгаа нэгэн гэр бүлийн талаар шашны нэг удирдагчаас олж мэджээ. Тэрээр тэдний жижигхэн сууцанд зочилж очоод, арав хүртэлх насны дөрвөн хүүхэдтэй ганц бие залуухан эхийг олж харжээ.

Гэр бүлийнх нь хэрэгцээ маш их байсан учраас Христийн мэндэлсний баяраар эх нь хүүхдүүдээ амттан, бэлэг тэр байтугай гацуур ч худалдан авч чадаагүй байв. Радд ах тэдний гэр бүлтэй ярилцаад, 3 бяцхан охин нь хүүхэлдэйд эсвэл чихмэл амьтанд дуртайг олж мэджээ. Тэрээр мөн 6 настай хүүтээс юу хүсэж байгааг нь асуухад өлссөн бяцхан хүү “Би нэг аяга овъёосны будаа идмээр байна” гэж хариулсан аж.

Радд ах бяцхан хүүд овъёос бас чадвал өөр ямар нэгэн зүйл авчирна гэж амласан байна. Дараа нь тэр бишопуудын агуулах руу явж, тэр гэр бүлийн яаралтай хэрэгцээг хангахын тулд хоол хүнс, бусад хэрэгцээт зүйлийг цуглуулав.

Яг тэр өглөө нэгэн өгөөмөр хожмын үеийн гэгээнтэн “тусламж хэрэгтэй хэн нэгэнд” өгөөрэй гэж түүнд 50 доллар өгчээ. Радд ах хандивын мөнгийг авч, тусламж хэрэгтэй хүүхдүүдэд тоглоом сонгож авахаар 3 хүүхдээ хувцаслаад, Христийн мэндэлсний баярын дэлгүүр рүү явав.

Раддын гэр бүлийнхэн машин дээрээ хоол хүнс, хувцас, бэлэг, Христийн мэндэлсний баярын гацуур болон чимэглэлүүд ачсаныхаа дараа нөгөө гэр бүл дээр очихоор явав. Тэнд очоод тэд эх, хүүхдүүдэд модоо байрлуулахад нь тусалжээ. Дараа нь тэд Христийн мэндэлсний баярын гацуур доор бэлэгнүүдээ байрлуулж, бяцхан хүүд том уутанд савласан овъёосны будаа бэлэглэв.

Эх нь үйлж, хүүхдүүд нь баярлалдаж, тэд бүгдээрээ Христийн мэндэлсний баярын дуу дуулжээ. Тэр орой Раддын гэр бүлийнхэн оройн хоолоо идэхээр цуглахдаа өөр нэгэн гэр бүлд Христийн мэндэлсний баярын хэсэгхэн ч болов баяр баяслыг авчирч, бяцхан хүүд нэг аяга овъёосны будаатай болоход нь тусалж чадсандаа талархсан байна.¹

Христ ба өгөхийн Сүнс

Хүүгийнхээ төрөлтийг хүндэтгэхийн тулд Тэнгэрлэг Эцэгийн сонгосон энгийн атлаа хүндэтгэлтэй арга замын талаар тунгаан бодно уу. Тэрхүү ариун шөнө тэнгэр элчүүд баячуудад биш, харин хоньчдод үзэгдсэн юм. Христ хүү харшид биш, харин малын тэвшинд



санаагаараа өвдөж, шаналж буй хүмүүст хайр болон эдгэрлийг авчирдаг. Мөн Тэрээр сэтгэл нь гэм нүгэлдээ шаналж буй хүмүүст найдвар, өршөөл, гэтэлгэлийг санал болгодог билээ.

Аврагч өнөөдөр бидний дунд байсан бол бид Түүний хүлцэнгүй, санаагаар унасан, дарууссан, сэтгэлийн дарамтад орсон, сүнсээр ядуу хүмүүст үргэлж үйлчилж байгааг нь олж харах байсан. Бид Христийн мэндэлсний энэ удаагийн баяраар мөн байнга бусдыг Түүнтэй адил хайрлаж, Түүнд бэлэг барих болтугай. Бид Түүний төрөлт, бэлэгнүүдийн болон амьдралын даруухан сүр жавхланг санах болтугай. Мөн бид нинжин сэтгэл, энэрэл, өрөвч энэрэнгүй байдлын энгийн үйлдлүүдээр дамжуулан Түүний хайрын гэрэл ба эдгээгч хүчээр дэлхийг дүүргэх болтугай. ■

ЭШЛЭЛ

1. ГЛЭН А.ПАДД, *Pure Religion: The Story of Church Welfare since 1930* (1995), 352–53; мөн ГЛЭН А.ПАДД, “A Bowl of Oatmeal,” *Church News*, 2006 оны 12-р сарын 2, 16-р хуудсыг үзнэ үү.

мэндэлсэн. Түүнийг торгонд биш, харин даавуунд өлгийдсөн юм.

Христийн мэндэлсний анхны тэрхүү баярын энгийн байдал нь Аврагчийн амьдрал ямар байхыг утган хэлсэн билээ. Тэр дэлхийг бүтээж; сүр жавхлан, алдар суугийн дунд алхаж; Эцэгийн баруун гар талд заларч байсан ч сул дорой хүүхэд болон дэлхийд ирсэн юм. Түүний амьдрал даруухан язгууртны үлгэр жишээ байсан бөгөөд Тэрээр ядуу зүүдүү, өвчин эмгэгтэй, сэтгэл санаагаар унасан, хүнд дарамт үүрсэн хүмүүсийн дунд амьдарч байв.

Тэрээр хаан байсан боловч хүмүүсээс магтаал, эд баялгийг эрэлхийлээгүй юм. Түүний амьдрал, үг болон өдөр тутмын үйл хэрэг нь энгийн атлаа төгс сүр жавхлангийн гайхаалтай үлгэр жишээ болдог байв.

Хэрхэн өгөхийг төгс мэддэг байсан, өгөх загварыг бидэнд бий

болгож өгсөн Есүс бол Христ. Тэрээр зүрх сэтгэлдээ ганцаардаж, гашуудан, хүнд дарамт үүрсэн хүмүүст энэрэл, тайтгарлыг авчирдаг. Тэрээр бие махбод, оюун

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Угдорф бидэнд Аврагчийн өгөх загварыг дагах хэрэгтэй гэж заасан. Айлчилж очдог хүмүүсээрээ Аврагчийн тэдэнд өгсөн бэлгийг ээлжлэн нэрлүүлж, мөн тэрхүү бэлгээ бусдад үйлчлэхдээ хэрхэн ашиглаж болохыг яриулах талаар бодож үзээрэй. Жишээ нь, хэрэв нэг гишүүн хөгжмийн авьяасаар адислагдсан бол тэр хүн зарим хөрш рүүгээ очиж, магтуу дуулал дуулж болно. Та айлчилж очдог хүмүүстээ аль бэлгээ хэнтэй, хэрхэн хуваалцах талаар сүнсний удирдамж хүсэж, өвдөг сөгдөн хамт залбирахыг санал болгож болно. Хүлээн авсан сүнслэг удирдамжийнхаа дагуу үйлдэнэ үү.

Өсвөр үеийнхэн болон хүүхдүүдэд уг захиасыг хүргэх санааг 6-р хуудаснаас үзнэ үү.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Бусдын туршлагаас суралц

Ерөнхийлөгч Угдорф “Христийн мэндэлсний хамгийн даруухан баяр хамгаас илүү дурсгалтай байж чаддагийг” заахдаа хувийн туршлагаасаа хуваалцсан юм. Бид өмнөх үеийнхнээсээ маш их зүйлийг сурч чадна. Олон хүн дайн тулаан, ажилгүйдэл, өвчин зовлон дунд эсвэл өөр бусад хүнд нөхцөлд амьдарч байсан. Тойрог эсвэл салбарынхаа

ахмад настай гишүүдээс хамгийн их утга учиртай Христийн мэндэлсний баярынхаа талаар хуваалцахыг хүс. Та тэдний түүхүүдийг бичиж авч болно. Христийн мэндэлсний энэ удаагийн баяраар бусдад чин сэтгэлээсээ үйлчилж, Аврагчийг санахад илүү их анхаарал хандуулснаар тэдний үлгэр жишээнээс суралцахыг хичээ.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Есүс Христийн бэлэгнүүд

Зарим хүн гацуур модыг Есүс Христийн төрөлтийг тэмдэглэхдээ ашигладаг. Заримдаа хүмүүс бусдад зориулсан бэлэгнүүдээ модон доороо байрлуулдаг. Аврагч танд ямар бэлэгнүүд өгсөн бэ? Доорх судруудыг бүгдийг уншиж, бэлэгнүүдийг будна уу. Чи бусдад туслах арга замуудыг олсноор Есүст хариу бэлэг өгч чадна.



Энэ материалыг залбирч судлан, юу хуваалцахаа мэдэхээр эрэлхийл. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн өсгөж, айлчлагч багшийн ажлаар дамжуулан өөрийн тань харж хандан, анхаарал тавьдаг хүмүүсийн амьдралыг хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг www.reliefsociety.lds.org вэбсайтаас үзнэ үү.

Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Энх амгалангийн Ханхүү

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

“Аврагч бол жинхэнэ энх амгалангийн эх сурвалж юм” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Квинтин А.Күк хэлжээ. “Амьдралд сорилт бэрхшээлүүд тохиолдож болох ч Аврагчийн Цагаатгал болон Түүний ач ивээлийн ачаар зөв шударга амьдарч байгаа хүмүүс хувийн амар амгалангаар шагнагдах болно.”¹ Есүс Христ бол Энх амгалангийн Ханхүү гэдгийг ойлгох нь дотоод амар амгаланг олж, Түүнд итгэх итгэлээ нэмэгдүүлэхэд бидэнд тусалж чадна.

“Миний дотор та нарыг амар амгалан байг гэж Би та нарт эдгээр зүйлсийг хэллээ. Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан” (Иохан 16:33) гэж Есүс Христ хэлжээ. Энэ үнэний талаар гэрчилж байхдаа Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий



ерөнхийлөгчийн зөвлөлийн 2-р зөвлөх Линда С.Рийвс “Их Эзэн надад нигүүлсэнгүй хандсаар ирсэн бөгөөд ачаануудыг минь хөнгөн болгож тусалсан. Тэр надад агуу их амар амгаланг мэдрэхэд тусалсан”² гэжээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт: “Амар амгалан байж чадах хамгийн тохиромжтой газар бол. . . . Их Эзэн Есүс Христийг гол цөмөө болгохын тулд бидний чадах бүхнээ хийсэн гэр орон маань юм”³ хэмээн заажээ.

Нэмэлт судрууд

Исаиа 9:6; Лук 2:14; Иохан 14:27;
1 Нифай 13:37; Сургаал ба Гэрээ 59:23

Эшлэлүүд

1. Квинтин А.Күк, “Хувь хүний амар амгалан бол зөв шударга байдлын шагнал мөн” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 37.
2. Линда С.Рийвс, “Гэрээний адислалуудаа өөрийн болго,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 138.
3. Ричард Г.Скотт, “Гэр орон дахь амар амгалангийн төлөө,” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 33.



Итгэл, гэр бүл, халамж

Судруудаас

Исаиа Энх амгалангийн Ханхүү, Есүс Христийн төрөлтийн талаар бошигловсон (Исаиа 9:6-г үзнэ үү). Америк тивд лемен үндэстэн Самуел таван жилийн дараа тохиох Христийн төрөлтийн тэмдгүүдийг хэлсэн юм (Хиламан 14:3, 5-ыг үзнэ үү). Бошигловсон өдөр ойртох үед үл итгэгчид эдгээр тэмдэг өгөгдөхгүй бол Христэд итгэдэг бүх итгэгчийг алахаар заналхийлж байв. Бошиглогч Нифай “тэрхүү өдрийн туршид Их Эзэнд хүчтэйгээр залбиран гуйв; мөн болгоогтун, Их Эзэний дуу хоолой түүнд ирж, хэлсэн нь: . . . маргааш бибээр дэлхийд ирэх болно” (3 Нифай 1:12-13) гэжээ. Тэмдгүүд үзэгдэж, Христийн төрөлтөөр “уг нутагт хүмүүс дахин тийн амар амгалан байх болов” (23-р шүлэг).

Бетлехэмд Мариа “ууган хүүгээ төрүүлж, Түүнийг даавуунд ороож Түүнийг тэжээлийн тэвшин дотор тавив” (Лук 2:7).

Үүнийг эргэцүүлэн бод

Аврагч таны амьдралд ямар арга замаар амар амгаланг авчирдаг вэ?

АРАВНЫ НЭГ НЬ БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХАД ТУСАЛДАГ

Бид Их Эзэний хаант улсыг байгуулахад туслахын тулд орлогынхоо аравны нэгийг Түүнд өгдөг гэдэгт итгэдэг. Аравны нэгийн хууль нь илүү агуу сүнслэг адислалуудыг авахын тулд зарим материалаг зүйлээ золиослохыг биднээс шаарддаг.

Сайн мэдээ дэлхий дээр анх заагдаж эхэлснээс хойш аравны нэгийн зарчим хэрэгжиж байгаа билээ. Жишээ нь, Абрахам дээд тахилч Мелкизедект аравны нэгээ төлдөг байв (Эхлэл 14:18–20-ийг үзнэ үү). Их Эзэн аравны нэгийн талаар хүмүүстээ заахыг Мосед зарлиглав (Левит 27:30–34-ийг үзнэ үү). Хожим нь Аврагч нифайчууд дээр айлчилж очих үедээ аравны нэгийн хуулийг тэдэнд өгсөн байдаг (3 Нифай 24-ийг үзнэ үү). Мөн өнөө үед Тэрээр

энэхүү зарлигийг бошиглогч Иосеф Смитээр дамжуулан дахин сэргээсэн билээ (С ба Г 119-ийг үзнэ үү).

Бид энэхүү зарлигийг биелүүлэхийн тулд орон нутгийн удирдагчдаараа дамжуулан орлогынхоо аравны нэгийг Их Эзэнд өгдөг. Уг сан нь Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн чуулга болон Тэргүүлэх бишопын зөвлөлөөс бүрдсэн, энэхүү ариун нандин санг хэрхэн ашиглахыг шийддэг зөвлөл болох Сүмийн удирдах газар руу шилжин очдог (С ба Г 120-ийг үзнэ үү).

Аравны нэг нь ариун сүм болон цуглааны байруудыг барьж, засварлах, институт, семинарыг дэмжих; сүмийн гишүүдийг бараа материалуудаар хангах; номлогчийн, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн

ажлыг дэмжих боломжийг Сүмд олгодог.

“Бурхан баяртайгаар өгөгчийг хайрладаг учраас” аравны нэгээ хүсэлтэйгээр төлөхөд бид итгэдэг (2 Коринт 9:7). Аравны нэгээ төлөх нь Бурханы хаант улсыг дэлхий дээр байгуулахад тусалж, мөн байгаа бүх зүйлээр маань биднийг адисалж байгаад талархлаа илэрхийлэх нэг арга зам юм. Гэсэн хэдий ч, аравны нэгээ төлөх нь бидний амьдралд илүү их адислал авчирдаг. Малахи: “Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна” хэмээн заажээ (Малахи 3:10). Бага ч бай, аравны нэгээ шударгаар төлдөг бүх хүнд сүнслэг болон материалаг адислалууд ирэх боломжтой юм. ■

Дэлгэрэнгүй судлахыг хүсвэл Эхлэл 28:20–22; Малахи 3:8–11 ба Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалууд: Лорэнзо Снөү (2012) 12-р бүлгийг үзнэ үү.

АРАВНЫ НЭГ ТӨЛСНӨӨР ИРЭХ АДИСЛАЛУУД



“Аравны нэг нь бидний итгэлийг хөгжүүлж бас сорьдог зүйл юм. Бид өөртөө хэрэгтэй эсвэл өөртөө байлгахыг хүсдэг зүйлээ Их


Эзэнд золиосолсноор Түүнд найдаж сурдаг. Түүнд итгэх бидний итгэл ариун сүмийн гэрээнүүдээ дагаж, ариун сүмийн мөнхийн адислалуудыг хүлээн авах боломжийг бидэнд олгодог. . . .

Мөн аравны нэг нь бидэнд энэ дэлхийн зүйлүүдэд татагддаг хүсэл эрмэлзлээ хянаж сурахыг заадаг. Аравны нэгээ төлөх нь найз нөхөдтэйгээ харьцах харилцаандаа үнэнч шударга байхад биднийг урамшуулан дэмждэг. Бид Их Эзэний адислалууд өөрсдийн шаргуу хичээл зүтгэлийн үр дүнд өгөгдсөн зүйлүүд нь бидний хэрэгцээнд хангалттай гэдэгт итгэж сурдаг. . . .

“Их Эзэн аравны нэгийн хуулийн дагуу итгэлтэй, шударга амьдардаг

хүмүүст элбэг дэлбэг адислалуудыг амладаг. Аравны нэг материаллаг байдаг шиг эдгээр адислалын зарим нь материаллаг байдаг. Гэвч баптисм болон ариун ёслолын биет ёслолуудтай адил аравны нэгийг төлөх зарлиг нь материаллаг золиослолыг шаарддаг бөгөөд эцэстээ агуу сүнслэг адислалуудыг авчирдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс, “Аравны нэг: Мөнхийн адислалуудыг авах итгэлийн сорилт,” *Лиахона*, 2002 оны 11-р сар, 27.



Аравны нэг болон бусад хандив нь бишопын эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээр дамжин Их Эзэнд өгөгддөг.




Аравны нэг нь ариун сүм ба цуглааны байруудыг барих болон тэдгээрийн засварын зардалд зарцуулагддаг.



Аравны нэгийн сангууд нь тойрог, салбаруудаас энэхүү ариун нандин санг хэрхэн ашиглахыг шийддэг Тэргүүн Зөвлөлөөс бүрдсэн зөвлөл болох Сүмийн удирдах газар руу шилжин очдог.



Аравны нэг нь судар болон хичээлийн материалуудыг орчуулах, хэвлэхэд зарцуулагддаг.



Аравны нэг нь Сүмийн сургууль, шашны институт, семинарт хамрагддаг залуу гишүүдийн боловсролын төлбөрт зориулагддаг.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ГАЙХАМШИГ

Линдси Алдэр

Түүний зүрх цохилсон хэвээр байв. Зүрхний шигдээсийн өмнөх үе шиг сайн биш ч цохилсоор байв.



Өнөө орой зүрх сэтгэлд минь дулаахан сайхан мэдрэмж төрж байна. Эмтэрч, шархалж, урагдсан ч гайхалтай дулаахан тийм л мэдрэмж. Би гүн гүнзгий, эргэн тойрон дахь зүйлүүддээ талархах талархлыг мэдэрсэн учраас зүрх сэтгэлдээ зайчлах шинэ орон зайг надад бий болгосон юм шиг л санагдаж байна. Мөн бүрэн дүүрэн бөгөөд нэн хувийн шинж чанартайн улмаас хацрыг минь даган урсах нулимсыг ч зогсоож чадахааргүй тийм их хүчтэй талархлыг би мэдэрч байна. Нөхөр минь амьсгалж байна. Би түүний

гүнзгий бөгөөд зөөлөн амьсгалахыг сонсож байна.

Би хэдхэн цагийн өмнө хэвлий дэх үрээ ч умартан, нөхрийнхөө эмнэлгийн ор руу гүйж очин, цээжин хэсэгт нь байрлуулсан утаснуудыг зайчилж байгаад, цээжин дээр нь толгойгоо тавьсан юм. Түүний зүрхний цохилтыг сонссон минь миний хувьд хэзээ ч мартагдахааргүй тод томруун дурсамж болон үлдсэн билээ.

Түүний зүрх цохилсон хэвээр байв. Зүрхний шигдээсийн өмнөх үе шиг сайн биш ч цохилсоор байлаа.

Өрөөнд багцлан өлгөсөн Христийн мэндэлсний баярын дулаан

гэрлүүд нь надад амар амгалан байхад хэд хэдэн арга замаар нөлөөлсөн юм. Энэхүү бүлээн дулаан гэрэл нь ая тухтай орчныг бүрдүүлсэн ч, Брайныг эрчимт эмчилгээний хэсгээс ирэхэд үнэнч найзууд нь түүний өрөөг чимэглэхээр Христийн мэндэлсний баярын өмнөх оройн төлөвлөгөөгөө өөрчлөхөд ч бэлэн байсан гэдгийг мэдэх нь л жинхэнэ амар амгалан байв. Цонхон дээр байрлах 3 фут (1 м) өндөр гацуур мод тэдний хайрын бэлэг тэмдэг болон харагдаж байна.

Би найзууддаа хэрхэн талархаж чадахсан билээ? Тэд надад ямар их хэрэгтэйгээ бас би тэдэнд хэчнээн их талархаж байгааг тэд мэдэж байгаа болов уу? Намайг нөхрөөсөө өөр зүйл бодож ч чадахгүй байгаа энэ үед тэд хүүхдүүдийг маань хайрлан халамжилж, гэрийг минь цэвэрлэн, хөргөгчийг минь хоолоор дүүргэж, угаалга хийн, Христийн мэндэлсний баярын бэлэг боож; тэврэлт, оройн хоол, бэлгийн карт, мөнгө, утасны дуудлага, текст, э-мэйл, мессежүүдээр мөн шанцай шиг үнэртэй хэдэн уут нарсны боргоцой, хайрцаг дүүрэн чимэглэлээр дамжуулан надад хайрыг авчирч байлаа. Тэд надтай хамт уйлж, залбирч, мацаг барьж байсан. Тэд энэ бүхнийг хийснээрээ надад өгч чадах хамгийн үнэ цэнэтэй бэлэг болох цаг заваа зориулсан юм. Би тэдэнд хэчнээн их хайртай гээч!

Тэднийг гэсэн төгсгөлгүй мэт санагдах талархлаар зүрх сэтгэл минь дүүргэгдсэн учраас би өнөө орой сайхан унтах байх даа гэж бодож байна.

Гэвч би нөхрөө амьд сэрүүн байж амьсгалж буйд, зүрх нь цусаа шахан ажиллаж буйн төлөө Их Эзэнд хамгийн их талархаж байна. Нөхөр минь амьд байгаа нь миний хувьд Христийн мэндэлсний баярын гайхамшиг юм. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Хойд Каролинад амьдардаг.

МАЛАХИ

"[Есүс] Малахид Эцэгийн өгсөн, тэрбээр өөрөө тэдэнд хэлэх үгсийг бичихийг тэдэнд зарлиглав" (3 Нифай 24:1).

Миний нэр "миний тэнгэр элч" гэсэн утгатай бөгөөд би энэхүү үүргийнхээ дагуу "Их Эзэний үгийг израильчуудад"¹ хүргэсэн. Христийн төрөлтөөс 450 орчим жилийн өмнө буюу миний амьдарч байсан өдрүүдэд² олон иудей хүн сэтгэлээр унаж, зөв шударга амьдрахаа больсон юм.³ Их Эзэн миний заасан зүйлсээр дамжуулан тэднийг зэмлэсэн.

Леви овгийн иудей тахилчид нь ерөнхийдөө ёслолуудыг гүйцэтгэхээр онцгойлон адислагддаг байсан ч левичүүд миний амьдарч байсан цаг үед ялзран доройтсон юм. Тэд талархалгүй байж, Бурханыг хүндлэхээс татгалзан, бузартсан талх болон өө сэвтэй малыг тахил болгон өргөсөн.⁴ Тэд Левитэй хийсэн Бурханы санваарын гэрээнүүдийг зөрчсөн юм.

Зөвхөн тахилчид төдийгүй хүмүүс бас ялзран доройтож байв. Тэд гэрээнээс гадуур гэрлэж, авааль эхнэрээс салж, аравны нэг болон өргөлүүд өргөхөөс татгалздаг байлаа.⁵

Их Эзэн эдгээр муу зүйлийг эсэргүүцэж байсан ч, хүмүүсээ хайрладаг байсан учраас

"Над руу буцан ирэгтүн, Би ч та нар руу буцан ирэх болно"⁶ хэмээн тэднийг уучлахад бэлэн байв. Их Эзэнд эргэн ирэх нэг арга зам нь "бүхий л аравны нэгээ агуулахад авчрах"⁷ юм.

Хүмүүс "Бурханд үйлчлэх нь ашиггүй юм: . . . ёс бусыг үйлддэг тэдгээр нь [хөгжиж цэцэглэдэг],"⁸ гэж гомдоллож байсан ч би "ЭЗЭНЭЭС эмээдэг болон Түүний нэрийг үнэлдэг" хүмүүсийн төлөө "дурсгалын ном" Түүний өмнө бичигдсэн билээ"⁹ гэж заадаг байсан.

Би мөн Их Эзэний Хоёр дахь ирэлтээр ёс бусчууд "тохуурагдах" хэдий ч Түүний нэрээс эмээдэг хүмүүст "зөв шударгын нар мандах

бөгөөд түүний жигүүрт эдгэрэлт бий"¹⁰ хэмээн бошиглосон билээ.

Хоёр дахь ирэлтээс өмнө "эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу нь, хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд уруу нь эргүүлэх"¹¹ санваарын түлхүүрүүдийг сэргээхээр бошиглогч Елиа ирнэ хэмээн би бошиглосон.

Их Эзэн миний заасан зүйлсээр дамжуулан Өөрийн хүмүүсийг санаж, итгэлтэй хүүхдүүдээ өгсөн амлалтуудаа биелүүлдгийг бид хардаг. Тэр биднийг эдгээр амлалтад итгэлтэй байж, наманчлалаар дамжуулан Түүнд эргэн ирэхийг хүсдэг.¹² ■

ЭШЛЭЛҮҮД

1. Малахи 1:1
2. Bible Dictionary, 728-р хуудас, "Malachi"-г үзнэ үү.
3. Хуучин Гэрээний семинарын суралцагчийн гарын авлага (2002), 193-ыг үзнэ үү.
4. Малахи 1:2, 6–14-ийг үзнэ үү; мөн *Old Testament Instructor's Guide, Religion 301–2* (1994), 109–110-ыг үзнэ үү.
5. Малахи 2:11, 14–16; 3:8-ыг үзнэ үү.
6. Малахи 3:7.
7. Малахи 3:10; мөн Лигранд Ричардс, "The Second Coming of Christ," *Ensign*, 1978 оны 5-р сар, 75-р хуудсыг үзнэ үү.
8. Малахи 3:14–15.
9. Малахи 3:16.
10. Малахи 4:1–2.
11. Малахи 4:6; мөн Сургаал ба Гэрээ 110-ыг үзнэ үү.
12. *Old Testament Teacher Resource Manual* (2003), 215 –ыг үзнэ үү.





Ахлагч
Л.Том Пэрри
Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

БУСДЫГ ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛТЭИ БОЛОХОД ТУСЛАХ НЬ

Би оюун санааны амар амгалан, бодит аз жаргалд зайлшигүй шаардлагатай Христэд итгэх итгэлд болон хүчирхэг шашины үндэс сууринд эргэн ирэхэд нь Бурханы хүүхдүүдэд туслахад та бүхнийг уриалж байна.

“Ромын пап лам XVI Бенедикт Европ, Австрали болон Нэгдсэн Улс дахь Христийн сүмүүдийн доройтолд харамсан гашуудахдаа: ‘Бурхан, тэр бүү хэл Христ хэрэгтэй гэсэн баталгаа байхгүй болжээ’ гээд, ‘уламжлалт сүмүүд гэж нэрлэгддэг сүмүүд мөхөж байна’ гэж хэлсэн байна.”¹

Бид уламжлалт сүсэг бишрэлээс холдон хөндийрчээ. Олон хүн өөрсдийгөө сүсэгтэй гэхээсээ илүүтэй, сүнслэг гэж хэлдэг болж. Хэрэв сургаал тэдний амьдралын хэв маягт нийцвэл тэд үүнийг хүлээн авч, үүнийг өөрсдийн итгэл үнэмшлийн хэсэг болгон хөгжүүлдэг. Хэрэв энэ нь нийцэхгүй бол хүн өөрийн итгэл үнэмшлийг хөгжүүлдэг. Итгэл ба сүнслэг байдлыг одоо хэрэглээний бүтээгдэхүүн мэтээр үзэж байна. Материализм буюу материаллаг үзэл давамгайлж, Бурханыг орлох боллоо.

Бид хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд хүн төрөлхтний итгэлийг устгах зорилготой эдгээр аюултай хандлагын эсрэг үзэл бодлоо илэрхийлдэг байх ёстой. Мормоны Ном бидэнд Бурханд итгэх итгэлээ удаан үргэлжилдэггүй зүйлсээр солих вий хэмээн дахин дахин сэрэмжлүүлдэг. Мормон олон нифай үндэстэн итгэлээсээ туугдаж байгаа цаг үеийг дүрслэн хэлэхдээ “Харин өөрсдийн агуу баялгуудын улмаас сэтгэлдээ хөөрсний учир тэд бардам болжээ; тиймийн тул өөрсдийн нүдэнд тэд баян болж, мөн Бурханы өмнө зөв шударгаар алхуулах тэдний бошиглогчдын үгсэд анхаарал тавихгүй байлаа” (Алма 45:24) гэжээ.

**Бүхий л үеийн
түүхэнд хам-
гийн сайн би-
чигдсэн баримт
бол дэлхий
дээрх Их Эзэн
Есүс Христийн
төрөлт болон
зорилгын тухай
шашир юм.**





Энэхүү золиослол нь дэлхий дээр санваарын эрх мэдлээр гүйцэтгэгдэж, дэлхийн нүглүүдийн төлөө амиа өгөх Хүний Хүүгийн золиослолыг төлөөлөх сайн мэдээний ёслол болон тогтсон юм.

Та нийгэмд Христэд итгэх итгэл доройтож байгааг харах үед таны итгэл илүү бат бөх, илүү аюулгүй болох ёстой. Хиламан: “Мөн эдүгээ, хөвгүүд минь, санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун; иймээс чөтгөр хүчит салхиа, тийм ээ, хуй салхин дахь дайралтаа илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит шуурга та нар дээр нүдэхэд, энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халаглалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон, бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр

баривал унах аргагүй суурь болох хадны учир болой” (Хиламан 5:12) хэмээн тунхагласан билээ.

Нифай бидэнд:

“Мөн бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд . . . [мөн] Христэд байх тэрхүү амьдралыг харууддаж болохын тулд . . . ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглоуудынхаа дагуу бичдэг болой” гэж сануулдаг.

“. . . Өөрөөр хэлбэл зөв зам гэдэг нь Христэд итгэх юм” (2 Нифай 25:26–28).

Ийм шаардлагыг хангах үндэс суурь бидэнд бий юу?

Христийн золиослолын бэлгэдлүүд

Бүхий л үеийн түүхэнд хамгийн сайн бичигдсэн баримт бол дэлхий дээрх Их Эзэн Есүс Христийн төрөлт болон зорилгын тухай шастир юм. Түүний зорилго бидний анхны эцэг эхийн өдрүүдээс эхлэн бошиглогдсон билээ. Бид Мосегийн номноос:

“Мөн Адам түүний эхнэр Ева Их Эзэний нэрийг дуудав, мөн тэдэнд хандан өгүүлэх Их Эзэний дуу хоолойг Еденийн Цэцэрлэг уруу хөтлөх замаас тэд сонсов, мөн тэд түүнийг харсангүй, учир нь тэд түүний оршихуйгаас таслагдсан байлаа.

“Мөн тэд өөрсдийн Бурхан Их Эзэнийг шүтэх ёстой, мөн мал сүргийнхээ ууган төлүүдийг Их Эзэнд барих өргөлийн тулд өргөж байх ёстой хэмээх зарлигуудыг тэрбээр тэдэнд өгчээ. Мөн Адам Их Эзэний зарлигуудад дуулгавартай байв.

“Мөн олон өдрийн дараа Их Эзэний тэнгэр элч Адам дээр хүрч ирэн хэлэв: Чи яагаад Их Эзэнд тахил өргөх болов? Мөн Адам түүнд хэлэв: Их Эзэн зарлигласнаас өөрийг би мэдэх нь үгүй.

“Мөн тэгээд тэрхүү тэнгэр элч ярьж, хэлэв: Энэ зүйл бол ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн болох Эцэгийн Төрсөн Ганцын золиослолтой төстэй бөлгөө.

“Иймийн тул, чи өөрийн хийх бүхнийг чи Хүүгийн нэрээр хийх ёстой, мөн чи наманчилж, үүрд мөнхөд Хүүгийн нэрээр Бурханыг дуудах ёстой” (Мосе 5:1, 4–8) гэж уншдаг.

Энэхүү золиослол нь дэлхий дээр санваарын эрх мэдлээр гүйцэтгэгдэж, дэлхийн нүглүүдийн төлөө амиа өгөх Хүний Хүүгийн золиослолыг төлөөлөх сайн мэдээний ёслол болон тогтсон юм.

Ёслолын хэв маяг нь цаг хугацааны голчид ирэх Их Эзэний золиослолын онцгой шинж тэмдгийг тодорхой үзүүлдэг билээ. Жишээ нь, хожим нь Дээгүүр өнгөрөх баярын өргөл нь гэм зэмгүй бөгөөд өө сэвгүй ууган эр хургыг өргөл болгон сонгохыг шаарддаг болсон. Цусыг нь юүлэн, нэг ч ясыг гэмтээхгүй байхыг анхаарах зан үйл нь Аврагчийн үхлийг бүхий л бэлгэдлээр төлөөлдөг байна.

Адамын үеэс Аврагчийн үе хүртэл тахил өргөх ёслол үргэлжилсэн нь гайхалтай санагддаг. Израилийн хүүхдүүд олон үеийн турш урвалтад орж байсан ч Төрсөн Ганц Хүү хүн төрөлхтний нүглүүдийг цагаатгаж, мөн Түүний цагаатгагч цус мөнх амьдралыг боломжтой болгоно гэсэн итгэл найдвар олон хүний зүрх сэтгэлд хоногшин үлджээ.

Тахил өргөх ёслол нь ерөнхийдөө Аврагчийн Цагаатгалын дараа төгсгөл болсон билээ. Тэрбээр дэлхий дээр байж, дэлхий дээрх тохинуулаа гүйцэлдүүлснийг сануулахын тулд ариун ёслолыг дагалдагчдадаа зориулж, шинээр тогтоосон билээ. Бид Лукийн номонд:

“Тэр талх авч, талархал өргөөд тэдэнд хуваан өгөхдөө энэ бол та нарын төлөө өгөх миний бие мөн. Намайг дурсаж үүнийг үйлд гэж айлдав.

Тийн идэцгээсний дараа Тэр мөн аяга авч, Энэ нь та нарын төлөө асгарах Миний цусаар тогтоох шинэ гэрээ юм” (Лук 22:19–20) гэж уншдаг.

Энэ сануулга урвалтын харанхуй үед ч, мөн олон зууны турш олон хэлбэр, олон арга замаар хийгдэж, сайн мэдээ болон санваарын хүч сэргээгдэж авралын ариун ёслолуудыг гүйцэтгэгдэх хүртэл байсаар ирсэн нь намайг гайхшируулдаг билээ.

Бид тэмдэглэгдэн үлдсэн түүхийн бүх үеийн турш Аврагчийнхаа зорилгын тухай байнгын сануулгуудыг олдог. Тэр дэлхийд Бурханы болон хүмүүний гэсэн давхар харьяалалтай нэгэн болж ирсэн юм. Энэ нь Түүнд Цагаатгалаар дамжуулан бүх зүйлийн төлөө агуу өргөмжлөх золиослол хийх боломжийг бидэнд олгосон билээ. Дэлхийн эрин үеүдийн турш Түүний илчилсэн авралын сургаалуудыг судалж, тэдгээрийн дагуу амьдрахаас илүү Есүс бол Христ, дэлхийн Аврагч гэсэн ямар ч хүчирхэг нотолгоо байж чадахгүй биз ээ. Биднийг дэлхий дээр түр хугацаагаар амьдрах үед Тэрбээр удирдан чиглүүлэх сайн мэдээгээ бидэнд өгсөн билээ.

Сайн мэдээ бол шийдэл юм

Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) хэлэхдээ: “Дэлхийд тулгарч байгаа асуудлуудыг Есүс Христийн сайн мэдээ шийдвэрлэх болно гэдгийг харуулах хариуцлагыг үүнийг тунхагладаг хүмүүс хүлээдэг. . . . *Есүс Христийн сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байснаар дэлхийн бүх асуудлыг шийдвэрлэж болно* . . . гэдэгт би итгэдэг.

Дэлхийн тулгамдсан асуудлуудын шийдэл нь Есүс Христийн Сүмд байдаг. Өргөн цар хүрээтэй арга хэмжээг зөвхөн хувь хүмүүсийн хэрэгцээг хангахын төлөө бус харин тодорхой нэг улс үндэстэн эсвэл хэсэг бүлэг улс орны хэрэгцээг хангахын тулд хэрэгжүүлэх хэрэгтэй. Бид өөрсдийгөө агуу мэргэн ухаантай хэмээн дөвийлгөн боддог байж магадгүй, гэвч тийм биш гэдгийг би батлан хэлж чадна. Энэ бол зүгээр л дэлхийн асуудлуудыг шийдвэрлэхэд Бурханы

төлөвлөгөөг хэрхэн хэрэглэх тухай асуудал юм. Сүмийн түүхэнд урьд нь тохиолдож байгаагүй, дэлхийн түүхийн энэхүү бүтээлч эрин үед санваар атгагч та бүхэнд агуу их үүрэг хариуцлага оногдоод байна. Би үүнийг давтан хэлье. Бид үнэнийг баримталдаг хэмээн баталдаг бол хожмын үеийн гэгээнтэн бүр үүнийхээ дагуу амьдрах үүрэгтэй бөгөөд дэлхийн хүмүүс бидний дуудлагын хариуд жимсийг амтлахаар ирэн, уг жимс эрүүл бөгөөд эрхэм сайхан болохыг мэдэх болно” гэжээ.²

Бид Их Эзэн болон Аврагчийн сайн мэдээ дэлхийд сэргээгдсэн тухай агуу захиасыг дэлхийд хүргэж байна. Түүний Сүм ариун санваарын хүчээр болон алдар суутайгаар дэлхийд дахин байгуулагдсан юм.

Түүний сургаал, ёслол, зарчмууд болон эрх мэдэл нь тэнгэрт байдгийн адилаар дэлхий дээр Түүний төлөөлөгчдөд Түүний нэрээр үйлдэх хүч болон өгөгдсөн юм. Энэ Сүм бол Аврагчийн Сүм. Тэрбээр Өөрийн сүмийн ажил хэргийг Өөрийнхөө сонгосон бошиглогчдоор дамжуулан удирддаг. Бошиглогчид бусдад сайн мэдээг зааж, Есүс Христ бол бидний Аврагч, Гэтэлгэгч гэдгийг гэрчилдэг. Өнөө үе буюу энэ эрин зуун нь цаг хугацааны эхэн үеийн бошиглогчдын зөгнөн хэлсэнчлэн, цаг хугацааны бүрэн байдлын эрин үе юм. Энэ бол Их Эзэний бошиглогчдоор яригдаж мөн ариун судруудад бичигдсэн бүх зүйл биелэгдэх цаг үе билээ. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол шинэ сүм биш бөгөөд энэ үед болон энэ эринд дэлхийд сэргээгдсэн Сүм юм.

Та нар бол өнөө үед зориулан Их Эзэний хадгалсан тэр үеийнхэн юм. Та нар хүмүүст дэлхийн замуудаа орхин, Түүнийг дагаж, Түүний сайн мэдээгээр амьдарснаар бидэнд амлагдсан адислалуудыг хүртэж мөн дэлхийн арга замуудаа орхиход нь хүмүүст туслах Түүний төлөөлөгч байхаар, Их Эзэнтэй хийсэн гэрээ болон амлалттайгаар баптисмын уснаас гарч ирсэн хүмүүс билээ. Та нар Их Эзэний хүүхдүүдэд Христэд итгэх итгэлдээ буцан ирж, Түүнд итгэх итгэлээ хөгжүүлж, мөн Түүний замуудад эргэн ирэхэд тусалж чадна.

Та нар юу хийж чадах вэ

Та нар “Би юу хийж чадах вэ?” гэж өөрөөсөө асууж болно. Хэдэн сарын өмнө манай гадасны ерөнхийлөгч ариун ёслолын цуглаан дээр үг хэлэхдээ бусдыг Христэд итгэх итгэлд нь буцаан авчрахын тулд бидний хийж чадах 4 зүйлийг санал болгосон юм:

1. Өдөр бүр залбир

Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Миний дуу хоолойг сонсож байгаа болон том, жижиг ямар ч саад бэрхшээл, хэцүү хүнд зүйлтэй тулгарсан хүмүүст хандан залбирал нь сүнслэг хүчийг бий болгодог гэдгийг хэлж байна. . . . Залбирал нь биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах арга хэрэгсэл юм. Залбирлаар дамжуулан Түүнтэй ярь. Тэгээд хариултыг сонс. Гайхамшгууд залбирлаар дамжин ирдэг. Оргилуун хүсэл эрмэлзлээр залбирахаа санагтун”³ гэжээ.

Та өөрөө өдөр бүр залбирч мөн бусдыг өвдөг сөгдөж, Бурханд хандан залбирахад нь урамшуулан дэмжсэнээр Христэд итгэх итгэлдээ эргэж ирэхэд нь тэдэнд тусал.

2. Судруудыг өдөр бүр судал

Мормоны Номын гэрчлэлүүдээс илүү хүчтэй Есүс Христийг гэрчлэх гэрчлэл байдаг гэж үү? Энэ номын 239 бүлгээс 233-т нь Аврагчийн тухай өгүүлдэг.⁴ Энэ бол гайхамшигтай биш гэж үү?

Өдөр бүр судраас судлахад анхаар. Дараа нь та бусдыг өдөр бүр судраас судлахад урамшуулан дэмжсэнээр Христэд итгэх итгэлдээ эргэж ирэхэд нь тэдэнд тусал.

3. Ариун сүмд орохуйц зохистой бай

Та нарын зарим нь ариун сүмд орсон, зарим нь ороогүй байгаа. Ариун сүмийн эрхийн бичиг авахын тулд юу шаардлагатайг ойлгох нь чухал юм. Бид Израилийн шүүгчийн өмнө очиж, ариун сүмийн эрхийн бичигтэй байхуйц зохистой гэдгээ түүнд нотлон харуулж, дараа нь уг эрхийн бичигтэй байхад шаардагддаг жишгүүдийн дагуу амьдардаг байх үйл явцыг тодорхой ойлгодог.

Та нарын зөв шударга үлгэр жишээ ариун сүмийн адислалуудыг хүлээн авахуйц зохистой амьдарч буйг харуулахуйц амьдар.

4. Өдөр бүр үйлчлэл хий

Хаан Бенжамин дараах үгсийг санагтун: “Мөн болгоогтун, би та нарт эдгээр зүйлийг та нар мэргэн ухааныг сурч болохын тулд хэллээ; та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” (Мозая 2:17). Бусдын төлөө үйлчилсэн үйлчлэлээр маань дамжуулан Их Эзэн бидний залбирлуудад шууд хариулдаг.

Христийнхтэй адил, үйлчлэлийн үлгэр жишээ болж, хүмүүсийг бусдадаа үйлчлэхэд урамшуулан дэмжсэнээр Христэд итгэх итгэлдээ эргэн ирэхэд нь тэдэнд тусал.



Үүрэг хариуцлагын мэдрэмжээ шинэ түвшинд гаргагтун

Би Бурхан амьд гэдгийг мэднэ. Бид бүгд Түүний хүүхдүүд бөгөөд Тэр биднийг хайрладаг гэдгийг би мэднэ. Тэрээр Өөрийн Хүүтээ бүх хүн төрөлхтний төлөө цагаатгагч золиослол болгон дэлхий рүү илгээснийг би мэднэ. Түүний сайн мэдээг бүрэн дүүрэн хүлээн авч, Түүнийг дагадаг хүмүүс нь Бурханы бүх бэлгээс хамгийн агуу нь болох мөнх амийг хүлээн авах болно гэдгийг би мэднэ. Аврагч бошиглогч Иосеф Смитийн номлолоор дамжуулан дэлхий дээрх сайн мэдээний сэргээлтийг удирдсаныг би мэднэ. Бид Есүс Христийг болон Түүний хуулиудыг дагаж, зарлигуудыг нь сахиснаараа мөнх бус амьдралынхаа турш үргэлжлэх цорын ганц баяр баясгалан, аз жаргалыг хүлээн авах болно гэдгийг би мэднэ.

Би та бүхнээс үүрэг хариуцлагын мэдрэмжээ шинэ түвшинд гаргагтун хэмээн уриалж байна. Би энэхүү мөнх бус

сорилтын өдрүүдэд оюун санааны амар амгаланд болон бодит аз жаргалд зайлшгүй шаардлагатай Христэд итгэх итгэлд мөн хүчирхэг шашны үндэс сууринд эргэн ирэхэд нь Бурханы хүүхдүүдэд туслагтун хэмээн та бүхэнд уриалж байна.

Бурхан та нарыг эр зориг, шийдвэр төгс байдал, урам зоригоор болон бидний Их Эзэний сайн мэдээгээр дамжуулан итгэлээ дахин сэргээх хүслээр адислах болтугай. ■

2011 оны 3-р сарын 6-ны Сүмийн Боловсролын Системийн галын дэргэдэх цугларалт дээр хандаж хэлсэн "Бид хамгийн агуу үеийнхэн байсан" үгнээс хэсэгчлэн авав. Бүрэн эхээр үзэх бол cesdevotionals.lds.org хаягаар орж үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. Пап лам XVI Бенедикт, Ноуэл Нокс, "Religion Takes a Back Seat in Western Europe," *USA Today*, 2005 оны 8-р сарын 10; usatoday.com/news/world/2005-08-10-europe-religion-cover_x.htm.
2. Дэвид О.Маккэй, *Gospel Ideals* (1953), 5; эх текст дээр онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
3. Томас С.Монсон, "Чадахынхаа хэрээр сайн бай," *Лиахона*, 2009 оны 5-р сар, 78.
4. Робэрт Ж.Матай, *The Book of Mormon: The Keystone Scripture*, Паул Р.Чийсмэн ба бусад (1988), 33.

Мормоны Номын гэрчлэлүүдээс илүү хүчтэй Есүс Христийг гэрчлэх гэрчлэл байдаг гэж үү? Энэ номын 239 бүлгээс 233-т нь Аврагчийн тухай өгүүлдэг.



ШВЕД ДЭХ

СҮМИЙН ӨСӨЛТ, ЦАГААЧЛАЛ БА ХҮЧ ЧАДАЛ

Швед дэх Сүм нь итгэлтэй гишүүдийн цагаачлал, мэдээллийн хэрэгслийн таагүй мэдэгдлүүд өсөн нэмэгдэж буй дэлхийн хавчлагыг даван туулсан хэдий ч сонгогдсон энэ оронд Их Эзэн Өөрийн ажлыг яаравчлуулж байна.

Ингэр Хогланд

1849 онд ерөнхийлөгч Бригам Янг сайн мэдээ номлох цөөн тооны эрэгтэйг дэлхийн өөр өөр хэсэгт дууджээ. АНУ-ын Массачусеттэд байхдаа Сүмд нэгдэн орсон, Солт Лэйк Валли руу аялдаг байсан Шведийн далайчин асан Жон Форсгрэн ерөнхийлөгч Янгаас өөрийг нь Швед рүү номлогчоор илгээхийг хүсжээ. Тэрээр үйлчлэхээр дуудагдаж, 1850 оны 6-р сард Шведэд иржээ.

Ахлагч Форсгрэн эхлээд Гавлид амьдардаг дүү нар дээрээ айлчлан очжээ. Түүний дүү Петр өвчтэй байсан бөгөөд эмч нар түүнийг эдгэрэх боломжгүй гэж хэлсэн байв. Ахлагч Форсгрэн дүү нартаа номлолынхоо зорилгыг тайлбарлаад, дараа нь Петрийг тосолж, адислахад тэрээр бүрэн эдгэрэв. 1850 оны 7-р сарын 19-нд ахлагч Форсгрэн Шведийн хамгийн анхны хөрвөгч болсон дүүдээ баптисм хүртээсэн ажээ.

Ахлагч Форсгрэний дүү Эрикад, түүнийг болон Петрийг сайн мэдээг хүлээн авахад нь бэлдсэн нэгэн сонирхолтой зүйл тохиолдсон байв. Ахыгаа ирэхээс хэдэн сарын өмнө тэрээр уламжлал ёсоор сүмийн цуглаан дээр сууж байв. Дуулал дуулж байх үеэр түүний өмнө зогсож байсан нэг хүн “Долоодугаар сарын 5-нд нэг эрэгтэй хүн та нар дээр гурван номтой ирэх ба эдгээр

номонд бичигдсэн зүйлүүдэд итгэх тэдгээр бүгд аврагдах болно” гэж хэлэхийг тэр харжээ. Ах нь Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээг авчрахад тэрээр ямар ч эргэлзээгүй итгэсэн байна.¹

Харамсалтай нь, ердөө гуравхан сарын дараа ахлагч Форсгрэн нутгаа орхиж явах хэрэгтэй болов. Хэдхэн жилийн дотор Швед рүү өөр номлогчдыг илгээсэн байна. Тэд Скани мужийн Сконабак хотод сайн мэдээ хүлээн авахад бэлтгэгдсэн хүмүүсийг олжээ. Маш олон хүн хөрвөгдсөн учраас тэнд 1853 онд 36 гишүүнтэй анхны салбар зохион байгуулагдсан юм. Скани дахь анхны удирдагчдын нэг нь Ланд хотын салбарын ерөнхийлөгчөөр дуудагдсан Карл Капсон байв. Хавчлага мөрдлөгөөс зугтахын тулд шөнийн цагаар Карлийн саравчинд болсон Сүмийн хамгийн анхны чуулганд 100 орчим гишүүн оролцсон байна.²

Итгэлтэй эмэгтэйчүүд

Сайн мэдээг хүлээн авсан эмэгтэйчүүд нь Швед дэх хүч чадлын тулгуурууд болсон юм. Нэг жишээ бол Вингакерт сайн мэдээг хүлээн авсан хамгийн анхны хүн нь Бритта Олсдоттэр Пэрссон юм. 1877 онд гэр бүлээ дэмжиж туслахын тулд тэрээр нэхсэн зүйлүүдээ




1950-иад оны үеэр Вастэрас хотын гишүүд энд уулзжээ.

1850 он: Анхны номлогч Жонн Форсгрэн Шведэд ирэв; анхны хөрвөгчид, Петр Форсгрэн, ▶ Эрика Форсгрэн нар баптисм хүртэв



1853 он: Анхны салбар, Сконабак салбар 36 гишүүнтэй байгуулагдсан

1854 он: Стокгольм салбар байгуулагдсан



▶ 1878 он: Мормоны Ном швед хэл дээр орчуулагдаж, хэвлэгдэв

▶ 1904 он: Хаяг нь мэдэгдэж байгаагаар Свартэнсгатан 3 гэх Сүмийн анхны барилгыг худалдаж авав (1946 онд энд үзүүлснээр)

худалдахаар Стокгольм руу аялдаг байв. Тэнд байхдаа тэр номлогчидтой уулзаж, тэдний зааж байгаа зүйлүүд үнэн болохыг ойлгоод, 50 настайдаа баптисм хүртжээ.

Түүний хөрвөлт болон Их Эзэний ажлыг хөхиүлэн дэмжсэн зоригтой хөдөлмөр нь эцэстээ илүү олон баптисм хүртээх боломжийг олгосон бөгөөд Вингакерт нэг салбар байгуулагдсан ажээ. Түүний үр удам одоо ч Сүмд идэвхтэй байдаг. Пэрссон эгчийн гуч охин Лайла Крилборн “Хүүхдүүдийнхээ болон ач зээ нарынхаа үе удамд тохиолдсон зүйлүүдийг харах нь гайхамшигтай юм. Одоо манай гэр бүлүүдэд хэд хэдэн санваартан болон номлогчид байгаа” гэж хэлжээ.

Өөр нэгэн анхдагч эмэгтэй бол Аппсалагийн Ловиса Мантэр байв. Тэр 1886 онд гишүүн болсон ба 91 настайдаа өөд болох хүртлээ итгэлтэй хэвээр байсан юм. Ням гаргуудад тэрээр цуглааны байранд очин, гэрэл асааж, бусад гишүүнийг ирэхийг хүлээдэг байв. Ихэнхдээ хэн ч ирдэггүй байлаа. 11 цаг болоход тэр өөртөө “Бурхан хүлээж болохгүй шүү дээ” гэж хэлдэг байв. Тэр дуу дуулж, залбиран, жаахан үг хэлээд, дараа нь өөр нэг дуу дуулж, залбирснаар хаадаг байв.

Хавчлага дарамтыг даван туулсан нь

Олон арван жилийн турш Сүмийн гишүүд хахир хатуу хавчлага дарамтан дор байв. Шведийн уугуул иргэн Майкл Жонсоноос гадна олон номлогч шоронд хоригдож байв. Түүнийг 1852 онд баривчилж, Мамо хүртэл 480 бээр (770 км) газар гинжлэн авчирсан байна. Тэнд тэр цайзын шоронд шидэгдэж, өлсгөлөн болон гачигдлаас болж эцэж туйлдсан байв. Ахлагч Жонсонг боловсролтой, ухаантай хүн гэдгийг олж мэдсэн нэгэн прист түүн дээр ирсэн байна. Тэр прист түүнийг Лютеран сүмд нэгдэж, “Мормоны үзлийг” үгүйсгэх юм бол түүнд туслахад бэлэн байгаагаа хэлж, бүр цаашдын боловсролд нь тусална гэж амлажээ. Ахлагч Жонсон өөрийн шашныг үгүйсгээгүй учраас тэр нутгаас хөөгдөн гарсан билээ.⁴

Өөр нэгэн итгэлтэй номлогч бол 1857 онд Ванэрсборгийн ойролцоо төрсөн Карл А.Карлкүист байсан юм. 17 настай байхад нь түүнд сайн мэдээг номлох хүчтэй мэдрэмж төрсөн бөгөөд тэр Жонкопингийн ойролцоо Сүмийн товхимлуудыг тараах ажилд дуудагдсан байна. Тэрээр маш ядуу байсан учраас салбарынх нь гишүүд

болох 7 бэлэвсэн эхнэр хүүхдүүдийнхээ хамт түүнд нэг костюм мөн гутал олж өгчээ. Өвөл болоход Карлд өөрийн гэсэн пальто байгаагүй ч гишүүд өөрсдийнхйгөө хэрэглээгүй үед өдөр бүр нэгийг цөөн цагаар зээлж өмсөхийг түүнд зөвшөөрдөг байв.⁵

Карл хожим нь Юта руу цагаачлан, Шведийн цагаач Хулда Остэргрэнтэй гэрлэжээ. Тэрээр Скандинавын номлолын ерөнхийлөгчийг оролцуулаад номлолын ажлаар дахин хоёр удаа Шведэд эргэн ирсэн байна. Тэрээр Солт Лэйк хотод амьдарч байсан ба Швед дэх Мормоны эсрэг үзэлтнүүдийн үзэл суртлыг хөхиүлэн дэмжиж, хөлс авдаг байсан Рэвэрэнд И.Аслев хэмээх пасторын манай Сүмийн талаарх буруу ташаа мэдэгдлүүдийг засаж залруулахад сүүлчийн номлолынхоо ихэнх хэсгийг

удирдагчид тэндхийн Сүмийг хүчирхэгжүүлэхийн тулд энэ цагаачлалыг урамшуулан дэмжсэн байна. Тэр цагаачлалын үр дүн одоо харагддаг бөгөөд ютачуудын бараг тэн хагас нь скандинав өвөг дээдэстэй байдаг.

Гэсэн хэдий ч, 1910 онд ерөнхийлөгч Жозеф Ф.Смит Стокгольмд айлчлан очиж, гишүүдийг үлдэж, Шведэд Сүмээ байгуулахад урамшуулан дэмжжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дараах Сүм

Дэлхийн хоёрдугаар дайн эхлэхэд бүх америк номлогч гэртээ харихаар болов. Дараа нь орон нутгийн швед эрэгтэйчүүдээс номлогчоор үйлчлэхийг хүсжээ. 1931 онд Сүмийн гишүүн болсон С.Фриз Жоханссон номлолын шинэ ерөнхийлөгчөөр дуудагдав. Дайн



► 1905 он:
Шведийн
номлол
зохион бай-
гуулагдав



1914 он: Шве-
дийн парламен-
тын гишүүд
эх орноосоо
“мормон төлөө-
лөгчдийг” хөөн
гаргах саналын
эсрэг санал өгөв

1926 он: Сүм
гишүүдийнхээ
оршуулгыг
гүйцэтгэх эрх
зүйн зөвшөөрөл
авав

1952 он: Шинэ хууль
нь төр засагтай хол-
боогүй эсвэл засгийн
газраар ивээн тэт-
гэгддэггүй бүх сүмд эрх
чөлөө олгов; Сүм гишүү-
дийнхээ гэрлэх ёслолыг
гүйцэтгэх хууль зүйн
зөвшөөрөл авчээ

зарцуулжээ. Жишээ нь, 1912 онд Аслев *Svenska Dagbladet* сонинд нэгэн нийтлэл бичсэн бөгөөд тэрээр үүндээ Карлкүист ахыг олон эхнэртэй гэж худал ташаа мэдэгдэл хийжээ.⁶ Карл үүнтэй холбоотойгоор зарим зүйлийг хийсэн ба тухайлбал, V Густав хаантай хүртэл уулзаж мөн олон нийтийн хурал цуглаанууд дээр Аслевийн мэдэгдлүүдийг няцааж байв.⁷


Аслевийн мэдэгдлүүдтэй тэмцэхэд туслахын тулд орон нутгийн гишүүн Эйнар Жоханссон Сүмийн өмнөөс үг хэлэхийг санал болгосон байна. Аслев өмнө нь бас Сүмийн номлолын алба нь “цагаан арьстан боолын худалдаа” гэсэн гүтгэлгийн чанартай мэдэгдэл хийж байсан учир тэрээр хуулийн дагуу заргын үйл явцыг эхлүүлжээ.⁸ Жоханссон ах Стокгольмд салбарын ерөнхийлөгч байснаас гадна Шведийн төлөө үйлчилдэг чухал, нөлөө бүхий удирдагч болсон байна.⁹

Энэ цаг үед мөрдлөг хавчлага байсан хэдий ч олон хүн сайн мэдээнд хөрвөгдөж байв. Тухай үеийн байдлаар 640 хүн баптисм хүртэж, гишүүнээр батлуулсан хамгийн амжилттай жил нь 1862 он байв. Гэвч хөрвөгчдийн ихэнх нь удалгүй Юта руу нүүжээ. Тэр үед

эхлэхээс нэг жилийн өмнө тэрээр хүнсний дэлгүүрээ зарж; эхнэр, 3 хүүхдийнхээ хамт номлогч болсон байна. Дайн дуусахад ерөнхийлөгч Жоханссон болон долоон швед номлогч дайны улмаас зогсчихсон байсан Финляндын номлолын ажлыг дахин нээхээр дуудагдсан юм.

1946 онд америк номлогчид Шведэд эргэн ирээд, номлолын ажлынхаа нэг хэсэг болгон англи хэлний хичээл заадаг байсан ба олон суралцагч Сүмийн гишүүн болов. Олон швед гишүүн Юта руу цагаачилсан учраас сүмийн өсөлт удаан үргэлжлээгүй байна. 1948–1950 оны хооронд урьдын дайснуудаасаа айх айдас, номлолын ерөнхийлөгчийн уриалга болон ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах боломж нь 250 идэвхтэй гишүүнийг Шведийг орхиход хүргэсэн юм.

Ийм нэгэн гэр бүл бол 1915 онд Сүмийн гишүүд болсон Оскар Андэрсэн, Албертина Андерсон нарын гэр бүл байв. Дэлхийн хоёрдугаар дайны дараа Оскар, Албертина нар сүмийн гишүүдтэй гэрлэсэн 7 хүүхдийнхээ хамт байгаа бүхнээ зарж, “Сион руу аялах” маш хүнд шийдвэр гаргасан байна. 1949-1950 оны хооронд Андерсоны гэр бүлийн 29 гишүүн Шведийг орхив. Оскар,



ШВЕД ДЭХ СҮМ

Номлол: 1
Гадас: 4
Дүүрэг: 1
Тойрог: 24
Салбар: 16
Гишүүн: 9463

Албертина нар гэр орон, 3 хүүхэд, 4 ач зээгээ орхиж яваад тэдэнтэйгээ дахин уулзаагүй ажээ. Тэд өөрсдийнх нь ойлгодоггүй хэлээр ярьдаг хүмүүсийн дунд цөлд болон хотод ирэв. Гэвч эдгээр итгэлтэй гишүүний хувьд ариун сүмтэй ойр байх нь өөр ямар ч зүйлээс илүү чухал байсан билээ.

Андерсоны гэр бүлийн гишүүд Африк дахь нэг Бүсийн ерөнхийлөгч болон Шведийн ариун сүмийн ерөнхийлөгч гэх мэт дэлхийн бүх хэсэгт номлогчоор болон Сүмийн удирдагчдаар үйлчилсэн ажээ.

Гэсэн ч Сүмийн бусад гишүүн Шведэд үлдэхээр шийдэж, Сүмийн удирдагчид

Бид бүгд цагаан алчуураар даллаж, 'Хосанна! гэж уухайлан хашгирч байсныг би хамгийн их санадаг" гэжээ.


Ариун сүмийн газрыг сонгох явцад Их Эзэний тусламж ирдэг. Стокгольмын ойр орчимд байрладаг хэд хэдэн хотын захиргаатай хэлэлцсэний дараа тохиромжтой хоёр газрыг олжээ. Орон нутгийн Сүмийн удирдагчдын хороо тэдний нэгийг санал болгосон ч Сүмийн ерөнхийлөгч нөгөө газар нь илүү тохиромжтой гэж шийджээ. Хожим бусад газар нь ариун сүмд тохиромжгүй гэдэг нь илэрхий болсон үед энэ шийдвэр илчлэлтээр ирсэн нь нотлогдсон юм.

1953 он: Анхны гишүүн хос Бэнгт-Арнэ Манхаммар, Көрстин Ског нарыг номлолын ерөнхийлөгч Кларэнс Ф.Жоннсон гэрлүүлэв



◀ 1955 он: Швед гишүүдийн анхны бүлэг Швейцарийн Берн рүү ариун сүм рүү аялав

1965 он: Стокгольмын Губбангэнд Сүмийн барьсан анхны цуглааны байр онцгойлон адислагдав.



болцгоосон байна. Ийм хүн бол 1949 онд баптисм хүртсэн залуухан эцэг Бо Вэннэрланд юм. Тэрээр номлолын ерөнхийлөгч, бүсийн төлөөлөгч болон ариун сүмийн ерөнхийлөгчөөр үйлчлэн, Шведийн томоохон удирдагч болсон.

Швед дэх ариун сүмийн адислалууд

1955 онд Швейцарьт ариун сүм онцгойлон адислагдахад олноороо цагаачлах явдал ерөнхийдөө зогссон юм. 30 жилийн турш шведүүд галт тэрэг, автобус, машинаар; заримдаа агаараар жилд хэд хэдэн удаа, хэдэн өдрийн турш аялдаг байв.

1985 онд Стокгольмд ариун сүм баригдаж, онцгойлон адислагдах үед гишүүд хэмжээлшгүй их баяр баясгаланг мэдэрсэн байна. Вастэрханиж тойргийн гишүүн Бэрит Вэннэрхолм онцгойлон адислалтын талаар дүрслэн хэлэхдээ "их удаан хүсэн хүлээсэн, гайхамшигтай туршлага болсон.



1982 онд Мормон Табернеклийн найрал дуучид Стокгольмын концертын танхимд тоглолтоо хийв.

Сүм Шведийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан хүмүүсийн анхаарлыг нааштай болгохоор хичээж байтал 1984 онд нэг удаа ийм зүйл тохиолдсон юм. Хэрригийн гэр бүлийн хөвгүүд Европт зохиогддог хамгийн том дууны тэмцээнд ялагч болов. Телевиз, сонин хэвлэлээр тэдний талаар гарсан нь Сүмийг олон нийтэд сайнаар таниулсан ба тэр үед олон залуу хүн Сүмд нэгдэн орсон байна.

1980-аад оны сүүлээр хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслээр байнга гарч, олон нийтэд сайн танигдсан өөр нэгэн гишүүн бол Швед улсад элчин сайдаар ажилаж байсан 35 настай, Нэгдсэн Улсын иргэн Грегори Нэвэлл байсан юм. Тэрээр эхнэрийнхээ хамт 2011 онд Шведэд эргэн ирж, 2014 оны 7-р сар хүртэл

хамтарсан чуулганууд хөрш зэргэлдээ орнуудын залуучуудын анхаарлыг татаж, шинэ гэр бүлүүдийг бий болгоход хувь нэмэр оруулж байна. Засгийн газрын өгөөмрөөр олгож буй хүүхдийн тэтгэмж болон шинэ эцэг эхчүүдэд цалинтай чөлөө авах боломжийг олгож байгаа зэрэг нь хосуудыг өнөр өтгөн гэр бүлтэй болох боломжоор хангаж буй хэрэг юм.

Өнөө үед идэвхтэй залуу гишүүдийн ихэнх нь дэлхий даяар номлолд үйлчилж байна. Оросын Екатеринабургийн анхны номлогч, буцаж ирсэн номлогч Дэвид Халлдэн өнөөдөр 6 хүүхэдтэй, гайхамшигтай гэр бүлтэй болжээ. Тэрээр гэр бүлд нь сайн мэдээ хэрхэн тусалдаг талаар хэлэхдээ: “Хүүхдүүдийг төөрөлдүүлж чадах маш олон дуу хоолой байна. Сайн мэдээ тэднийг

1975 он: Тэр үед ахлагч байсан Томас С.Монсон Стокгольмд анхны гадас зохион байгуулав



◀ 1985 он: Стокгольмын ариун сүмийг ерөнхийлөгч Гордон Б.Хинкли онцгойлон адислав

1991 он: Оросын анхны гишүүд Стокгольмын ариун сүмд ирэв; Орос болон Балтийн орнууд ариун сүмийн дүүрэгт харьяалагддаг болов



◀ 1995 он: Карл XVI Густав хаан болон Сильвия хатан хааныг ерөнхийлөгч Томас С.Монсон Стокгольмын ариун сүмийн газар дээр урив

Шведийн Стокгольм номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн байна.

Ерөнхийлөгч Нэвэлл тоо нь 84–205 хүртэл өсөн нэмэгдсэн номлогчдыг тэргүүлсэн юм. Шведэд байр хомс, үнэтэй учраас “шинээр ирж буй номлогчдодоо зориулан 56 байр нэмж олох боломжтой байсан нь гайхамшиг байсан” гэж тэрээр дүрслэн хэлжээ.

Бодит өсөлт

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Швед улс шашингүй үзэл нь өсөн нэмэгдэж байгаа орон болсон. Гэвч тэнд Бурханыг эрэлхийлж буй олон цагаач байдаг. 6 швед хүн тутмын нэг нь гадаад орнуудад төрсөн байдаг. Шведэд Сүмд орсон хүмүүсийн дийлэнх нь цагаачид юм. Ерөнхийлөгч Нэвэлл зарим шинэ хөрвөгчийн талаар хэлэхдээ: “Швед дэх Сүмд 28 өөр улс орны ах, эгч нар хөрвөгдөж байна. Их Эзэн тэднийг төрөлх нутгаас нь тарааж, Израилийг цуглуулж байгааг би харж байна. Өнөө үед энэ сонгогдсон нутагт ажлыг үнэхээр яаравчлуулж байна” гэжээ.

Сүм гишүүдийн дунд өсөж байна. Олон гадасны

хүчирхэгжүүлж, тэдний итгэлийг олж авахад бидэнд тусалдаг” гэжээ.

Шашингүй нийгэм болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх зарим таагүй зүйл дунд байдаг боловч олон итгэлтэй гишүүн болон хүчтэй удирдагчид Шведэд амьдарч байна. Гишүүд Сүмийн сургаал болон үйл ажилагаанууд гэр бүл, хувь хүмүүст тусалж байгааг талархалтай байдаг ба тэд илүү олон хүн Есүс Христийн болон Түүний Цагаатгалын баяртай захиасыг хүлээн аваасай гэж чин сэтгэлээсээ хүсэн хүлээдэг. ■

Энэ өгүүллийн зохиогч Шведэд амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Box Elder Lore of the Nineteenth Century (1951), 58-ыг үзнэ үү.
2. Андрыо Жэнсон, History of the Scandinavian Mission (1979), 81-ийг үзнэ үү.
3. Ингэр Хогланд болон Каж-Аажэ Жоханссон, Steg i tro (2000), 122-ыг үзнэ үү.
4. Жэнсон, History of the Scandinavian Mission, 53-ыг үзнэ үү.
5. Мөртли Макдоналд, No Regrets: The Life of Carl A. Carlquist (1985), 19–21-ийг үзнэ үү.
6. Макдоналд, No Regrets, 219-ийг үзнэ үү.
7. Жэнсон, History of the Scandinavian Mission, 331-ийг үзнэ үү.
8. Макдоналд, No Regrets, 239-ийг үзнэ үү.
9. Макдоналд, No Regrets, 219-ийг үзнэ үү.



Ахлагч
Марлин К.Жэнсэн

1989-2012 он хүртэл
Далын гишүүнээр
үйлчилжээ

Ариун ОЙН ЦООРХОЙ

-ООС ОЛЖ АВСАН
СУРГАМЖ

1993 онд Далд дуудагдсанаасаа хойш 4 жилийн дараа би гэр бүлийнхэнтэйгээ хамт Нью-Йоркийн Рочэстэр номлолд дуудагдсан юм. Энэ номлол нь Палмира тосгоныг (1920-иод оны ихэнх жилүүдэд Иосеф Смит болон түүний гэр бүл энд амьдарч байсан) болон Фейеттийг (1830 оны 4-р сард Сүм зохион байгуулагдсан газар) хамардаг.

Энэ газрыг дүрсэлбэл, модоор бүрхэгдсэн толгод; тунгалаг нуурууд болон горхиудтай, сайхан сэтгэлтэй, сонирхол татам хүмүүс бүхий үзэсгэлэнтэй нутаг билээ. Энэ нь бас тэнд болсон үйл явдлаар ариун болсон газар юм.

Палмирагийн ойролцоо Иосеф Смит, Люси Мак Смит нарын гэрээс баруун тийш барагцаагаар милийг дөрөв хуваасны нэгтэй тэнцэх зайд байрладаг өндөр сүрлэг эвэр модод, царс, агч болон бусад олон модтой нэгэн ойн цоорхойд 14 настай Иосеф Смит үзэгдэлд Бурхан, Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг харсан билээ. Шашны талаарх үнэнийг мэдэх гэсэн Иосефийн залбирлын хариуд ирсэн энэхүү тэнгэрлэг илэрхийлэлт нь сүүлчийн энэхүү эрин үед сайн мэдээний сэргээлтийг эхлүүлсэн билээ. Мөн энэ нь тэрхүү ойн цоорхойг Ариун ойн цоорхой нэрээр, бидний хүндэтгэлтэй ханддаг газар Сүмийн түүхэн дэх хүндлэл бишрэлийн газар болгосон юм.

Би гэр бүлийнхэнтэйгээ энэ ойн цоорхойг хайрлаж, ариун нандин байдлыг нь мэдэрч эхэлсэн юм. Бид үе үе тэнд очдог байв. Бид сар бүр шинээр ирж буй болон номлолоо дуусгаад буцаж байгаа номлогчдыг аваад тэнд очдог байлаа.

Би Ариун ойн цоорхойд хүндэтгэл бишрэлтэй алхахдаа эсвэл тэнд байрлуулсан сандал дээр суугаад бодох зуур мод, мөчир, үндэс, үр, жимс, ой модыг багтаасан судрын уран төсөөлөл их байдаг талаар үе

*Би та бүхнийг
оюун ухаан,
зүрх сэтгэлээрээ
үргэлж Ариун
ойн цоорхойд
зогсож, Бур-
ханы тэнд ил-
чилж эхэлсэн
үнэнүүдэд үнэн-
чээр амьдрахад
урилалж байна.*



үе тунгаан боддог байлаа. Гярхай хэн нэгэн тэндхийн үзэсгэлэнт байгалаас зарим чухал сургамжийг ч олж авч чадна. Би та бүхэнтэй эдгээр сургамжаас дөрөвхнийг товчхон хуваалцъя.¹

1. Мод үргэлж гэрэл дагаж ургадаг

Ариун ойн цоорхойд модод ойн захаар болон доторх жимийн олныг нь даган ургаж буй моддын сүүдэрлэх навчсаас зугтаж гадагшаа ургадаг бөгөөд дараа нь нарны гэрлийг өөртөө хамгийн ихээр хүлээн авахын тулд дээш тэмүүлдэг. Модны тахиралдсан их бие нь бараг өөгүй шулуун ургасан ойролцоох модныхоос маш өөр байдаг. Бүх амьд организмтай адил тэсэж үлдэн, өсч хөгжихийн тулд модонд гэрэл хэрэгтэй. Тэд гэрлийн эрчим хүчийг химийн эрчим хүч болгон хувиргадаг фотосинтезэд орохоор аль болох их нарны гэрэл шимэн авахын тулд чадах бүхнээ хийдэг.

Гэрэл нь байгал дахь байдлаасаа илүүгээр сүнслэг байдлын хувьд бүр илүү чухал нөлөөлөгч болдог. Учир нь гэрэл бол Бурханы охид, хөвгүүдийн хувьд өөрсдийн сүнслэг байдлын өсөлт ба бүрэн чадавхыг ойлгоход чухал юм.

Харанхуй нь гэрлийн эсрэг тал бөгөөд биднийг Бурханаас тусгаарлаж, бидэнд зориулсан Түүний тэнгэрлэг төлөвлөгөөг зогсоохыг эрэлхийлэгч дэлхий дээрх хүчнүүдийг төлөөлдөг. Хилэнцэт хүчнүүд нь хамгийн муу нөлөөгөө харанхуй болсны дараа эсвэл харанхуй газруудад үзүүлдэг. Ариун явдлын хууль ба мэргэн ухааны үгийг зөрчих, хулгай хийх болон Тэнгэрлэг Эцэгийн хориглосон бусад зүйл нь ихэвчлэн харанхуйд болдог. Бид гэгээн цагаан өдрөөр буруу зүйл хийхээр сонгосон ч харанхуйн мэдрэмжүүдийг мэдрэхгүй байж чаддаггүй.

Аз болоход, Христийн Сүнс нь “дэлхийд ирдэг хүн болгонд гэрлийг өгдөг; мөн Сүнс нь дэлхий даяар Сүнсний дуу хоолойг анхаардаг хүн болгоныг гэгээрүүлдэг бөлгөө.

“Мөн Сүнсний дуу хоолойг анхаардаг хүн болгон Бурханд, бүр Эцэгт ирдэг болой” (С ба Г 84:46–47).

Судрын энэ хэсэг нь хэрэв бид үүнийг боож хясахгүй л бол гэрэлд алхах, ингэснээр Бурхан болон Түүний Хүү дээр очоод, Тэдэнтэй илүү адил болох мөн Бурханы хүүхдүүдэд дээш хүрэх боломж ба Бурханаас заяагдсан сүнслэг зөн совин бүтдэд байгааг тун гайхамшигтай дүрслэн хэлсэн байна. Христ Өөрийнхөө талаар “Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно” (Иохан 8:12) гэж хэлжээ.

Би та нарыг бүх хэлбэрийн хорон муу дотор байдаг нүглийн харанхуйгаас зайлсхийж, амьдралаа Аврагч, Есүс Христийн Сүнсээр, үнэн болон гэрлээр дүүргэхэд уриалж байна. Та нар зөв шударга найз нөхдийг эрэлхийлж, сүнслэг дуу хөгжим сонсон, сүнслэг уран зураг үзсэнээр; мэргэн ухааны үгсийг шилдэг номнуудаас эрэлхийлж (ялангуяа судруудаас), чин сэтгэлээсээ залбиран, байгалийн нам гүм газар байснаар; ашиг тустай үйл ажиллагаа, ярилцагуудыг хийж, Христ дээр болон хайр, үйлчлэлийн талаар Түүний заасан сургаалууд дээр амьдралаа төвлөрүүлснээр үүнийг хийж чадна.



2. Бүтээлтийн зорилгоо биелүүлэхийн тулд модонд эсрэг тал шаардлагатай байдаг

Хүмүүс Ариун ойн цоорхойг арчлан хамгаалахдаа олон жилийн турш ой модны менежментийн талаарх олон янзын онолыг ашигласаар иржээ. Нэг удаа олны мэддэг *сийрүүлэх* туршилт хийхээр хэсэг газар сонгон авав. Ойн мэргэжилтнүүдийн тооцоолсноор, туршилтын хэсэг дэх хамгийн том, хамгийн эрүүл моддыг хамгийн тохиромжтой гэж үзжээ. Дараа нь тэд үр жимс муутай, нам дор байгаа моддыг тайрч, авч хаяв. Тэдний таамагласнаар ус, нарны гэрэл, хөрсний тэжээл зэргийг хуваалцаж байсан ихэнх хэсгийг *чөлөөлснөөр* сонгогдсон модод илүү онцгой, ер бусын арга замаар ургаж, өсөх байв.

Хэдэн жилийн дараа энэ зүйл эсрэгээрээ болж байгаа нь тодорхой болов. Өрсөлдөөнгүй шахам болсон учраас сонгогдсон модод залхуу, сул дорой болжээ. Модод гэрэл өөд тэмүүлэн дээш ургахын оронд



Ариун ойн цоорхой дахь зарим мод сөрөг тал нь бидний ашиг тусын төлөө өгөгддөг бөгөөд туйлын хүнд нөхцөл байдалд ч олж авах зүйл бидэнд их байдгийг харуулж байна.



өндрөөшөө өсөх нь удаашран навчсаар хучигдсаар эцэстээ ямар ч хэрэгцээгүй болдог доод мөчрүүд нь их ургаж, илүү бүдүүрч байв. Ургаж, үр жимсээ өгөхийн тулд тэмцэж, ялсан моддыг хэмжээ эсвэл хүч чадлаар нь туршилтын хэсэгт байсан эдгээр модны алинтай ч харьцуулах аргагүй байв.

“Бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй” (2 Нифай 2:11) гэдэг нь Мормоны Номын гол зарчмуудын нэг юм. Сөрөг талууд бүхий дэлхий нь сонгох эрх зохих ёсоор хэрэгжиж болохын тулд сайн, муу хоёрын хооронд сонголт хийх боломжийг олгодог. Гэсэн хэдий ч, сүнслэг өсөлтийг тохиолгон авчрахын тулд сөрөг тал байх ёстой нь үүнтэй адил чухал ач холбогдолтой зарчим юм. Энэ зарчмыг ойлгож, хүлээн авах нь амьдралдаа аз жаргалтай байх шийдвэрлэгч хүчин зүйл билээ. Мөн энэ нь шаардлагатай хувийн өсөлт хөгжлийг олж авахад чухал байдаг.

Эрт орой хэзээ нэгэн цагт бид бүгд сөрөг тал ба саад бэрхшээлтэй тулгарах болно. Эдгээрийн зарим нь унасан дэлхийд мөнх бус амьдарч байгаагийн үр дүнд жам ёсоор ирдэг. Үүнд байгалийн гамшиг, өвчин зовлон, уруу таталт, ганцаардал эсвэл бие махбодын юм уу оюун санааны согог орж болно. Заримдаа сөрөг тал болон сорилт бэрхшээл нь бидний буруу сонголтуудын улмаас ирдэг. Эвдэрсэн бүхнийг Цагаатгалаар эвлэрэх арга замаар хангасан Аврагчдаа бид хэчнээн их талархах ёстой билээ?

Либертийн шоронд Иосеф Смитийг дарамт шахалтыг тэсвэрлэх аргагүй болох тэр үед түүнд хандсан: “Эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно гэдгийг чи мэдэгтүн, хүү минь” (С ба Г 122:7) гэсэн Их Эзэний үгсээс би агуу их тайвшралыг олж авдаг.

Ариун ойн цоорхой дахь зарим мод сөрөг тал нь бидний ашиг тусын төлөө өгөгддөг бөгөөд туйлын хүнд нөхцөл байдалд ч олж авах зүйл бидэнд их байдгийг харуулж байна. Эдгээр мод нь тэнхэрч,

сэргэхийн тулд олон хэлбэрийн сөрөг байдал эсвэл саад бэрхшээл аянга цахилгаан, гэнэтийн хүчтэй салхи, хунгарласан цас юм уу мөс, хайхрамжгүй хүмүүсийн халдлага ба буруу үйлдэл тэрчлэн заримдаа зэргэлдээх модны түрэмгийлэл зэргийг даван туулах шаардлагатай байлаа. Эдгээр тааламжгүй нөхцөл байдлын нөлөөгөөр ойн цоорхойн хамгийн бат бөх бөгөөд харахад хүртэл сонирхол татам модод ургадаг байна.

3. Мод тусдаа байхдаа биш, харин ойд байхдаа л хамгийн сайн ургадаг

Байгал дээр цор ганцаар ургаж буй модыг харах нь ер бусын зүйл юм. Мод ихэвчлэн төгөл хэлбэрээр ургаж, цаг хугацаа өнгөрөн одох тусам төгөл нь ой мод ч болж болно. Гэсэн ч Ариун ойн цоорхой нь хэсэгхэн модноос ч хамаагүй том зүйл. Энэ нь олон зүйлийн ургамал, амьтнаас бүрдсэн маш нарийн зохицолдсон экологийн систем юм.

Тэндхийн бүх төрлийн зэрлэг цэцэгс, бут, сөөг, мод, мөөг, хөвд, шувууд, мэрэгч, туулай, буга болон бусад бүтээлийн хооронд нэгэн тодорхой уялдаа холбоо байдаг. Эдгээр төрөл зүйл нь хоол хүнс, оромж, амьдралаа бүтээн байгуулах арга ухаан, амьдралынхаа замналыг туулах нийгмийн орчин зэрэгт бие биедээ харилцан үйлчилж, түшиглэж байдаг.

Бидний амьдралын төлөөх Бурханы төлөвлөгөө нь бидэнд зориулсан ижил төстэй уялдаа холбоог агуулдаг. Бид авралынхаа төлөө тус тусдаа биш, харин хамтдаа ажиллах ёстой. Сүм даяанчийн байр биш, харин цуглааны байрууд барьдаг.





Сэргээлтийн эхнээс, баптисмын гэрээ-нүүдээ хүндэтгэн, эв нэгдэлтэй амьдарч, харилцан бие биенээ дэмжиж сурах хо-роонд цуглаарах зарлигийг бидэнд өгсөн билээ (Мозая 18:8–10-ыг үзнэ үү). Бур-ханы хүүхдүүдийн хувьд, бид ганцаар ургадаг мод шиг тус тусдаа өсөж хөгжиж чадахгүй. Эрүүл модонд экологийн систем хэрэгтэй байдаг шиг эрүүл хүнд хүмүүс хэрэгтэй.

Аз болоход, бид бүгдэд бусадтай ха-рилцах, нөхөрлөх, үнэнч шударга найз нөхөдтэй байх хүсэл байдаг. Бурханы мөнхийн гэр бүлийн гишүүдийн хувьд бид бүгд ойр дотно, удаан үргэлжлэх харилцааг өгч чадах сэтгэл хангалуун бөгөөд аюулгүй байдлыг хүсэн хүлээ-дэг. Олон нийтийн сүлжээ сайтууд нь биднийг хоорондоо харилцах нэг арга замаар хангадаг нь эргэлзээгүй боловч тэдгээр нь жинхэнээсээ, удаан үргэлжлэх харилцаа тогтоохын тулд зайлшгүй байх ёстой үнэнч шударга, илэн далангүй, нүүр нүүрээ харсан харилцан яриаг орлож чадахгүй.

Бусадтай сайн харилцаж сурах анхны бөгөөд шилдэг газар бол гэр орон гэдэг нь тодорхой. Бид бусадтай удаан хуга-цаанд үргэлжлэн харилцахад чухал болох үйлчлэл, аминч бус үзэл, уучлал ба тэвчээ-рийн талаарх хичээлүүдийг гэр орондоо суралцдаг.

Аз болоход илчлэлтээр өгөгдсөн Сү-мийн зохион байгуулалт нь биднийг ний-гэмшин хөгжих орчноор хангадаг. Сүмийн дуудлага, хурал цуглаан, анги, чуулга, зөв-лөлийн хурал, үйл ажиллагаанууд болон бусад уялдаа холбоо бүхий олон төрлийн боломжоор дамжуулан тэнгэрт орших нийгмийн дэг журамд өөрсдийгөө бэлт-гэхэд бидэнд туслах зан чанар, нийгмийн чадваруудаа бид хөгжүүлдэг.

Энэхүү дээд дэг журмын талаар ярьж байхдаа бошиглогч Иосеф Смит “Энд бидний дунд байгаа тэрхүү харилцаа тэнд бидний дунд байх болно, гагцхүү энэ нь эдүгээ бидний эдэлдэггүй тийм алдар суу болох мөнхийн алдар суугаар

хоёр дахин ихсэх болно” (С ба Г 130:2) хэмээн хэлжээ.

4. Мод нь өмнөх үеийн моддын бий болгосон шим тэжээлээс хүч чадал олж авдаг

Ариун ойн цоорхойг харж хандах үүрэг хүлээсэн хүмүүс нь ойн цоорхойг сайтар арчлан тордох хэрэгтэй гэсэн шийдвэр гаргаж байсан тийм үе байлаа. Тэгээд уна-сан мод, мөчир; явган бут сөөг, хожуул; хатсан навчсаас ойн цоорхойг цэвэрлэх төслүүдийг зо-хион байгуулжээ. Үүнийг хийсний дараа удалгүй ойн цоорхойн амьдрах эрч хүч нь буурч эхлэв. Модны өсөлт удаашран, цөө-хөн шинэ мод нахиалж, зэрлэг цэцэгс болон ур-гамлуудын зарим зүйл нь харагда-хаа больж, шу-вууд болон бусад зэрлэг амьтны тоо толгой багасав.

Хожим нь ойн цоорхойг аль болох байгалийнх нь байдалд үлдээх хэрэгтэй гэсэн зөвлөмж гарсны дагуу хөрсийг ялзруулж, баяжуулахын тулд унасан мод, мөчрүүдийг газарт нь үлдээжээ. Навчсыг бас байсан газруудад нь үлдээв. Ойн цоорхойг аль болох бага эвдэж, хөрсийг нягтруулахгүйн тулд тэмдэглэсэн явган замуудаар л явахыг зочдоос хүссэн юм. Хэдхэн жилийн дотор уг ойн цоорхой сэргэж, гайхамшигтай арга замаар өөрий-гөө шинэчилж эхэлсэн байна. Өнөөдөр энэ цоорхой нь өтгөн сахлаг өвс ургамал, зэрлэг амьтдаар дүүрч, бараг өө сэвгүй цэцэглэн хөгжиж байна.

Энэ туршлагаас сурч болох сургамж нь миний хувьд үнэ цэнэтэй билээ. Надад долоон жилийн турш Сүмийн түүхч болон

*Гярхай нэгэн
нь тэндхийн
үзэсгэлэнт бай-
галиас зарим чу-
хал сургамжийг
сурч авч чадна.*

бичээчээр үйлчлэх онцгой боломж тохиосон юм. Бүртгэл хөтөлж, цуглуулж, хадгалан, түүхээ хуваалцах нь Есүс Христийн Сүмд яагаад ийм чухал байдаг вэ? Түүхийнхээ талаар мэдлэгтэй байж, өнгөрсөн үеийнхнээсээ хүч чадал олж авах нь бидэнд яагаад чухал байдаг вэ? (С ба Г 21:1; 69:3, 8-ыг үзнэ үү.)

Би өнгөрсөн үеийн үндэс суурьгүйгээр одоо үедээ бүрэн амьдарч, ирээдүйн хувь заяагаа төлөвлөх боломжгүй гэдгийг та нарт хэлмээр байна. Одоо болон ирээдүйтэй холбоотой өнгөрсөн үеийн хамаарлыг ойлгох нь Их Эзэнээс Иосеф



Смитэд илчилсэн үнэний талаарх тодорхойлолтод илүү бүрэн дүүрэн талархалтай байхад бидэнд тусалдаг: “Үнэн бол байгаа юмсын, байсан зүйлүүдийн, мөн ирэх зүйлүүдийн тухай мэдлэг юм” (С ба Г 93:24).

Хадгалагдан ирсэн бичээсүүдийн ачаар өнгөрсний талаар болон судрууд ба амьд бошиглогчдын сургаалуудын ачаар ирээдүйн талаар мэдлэгтэй байх нь бидэнд сонгох эрхээ ухаалаг ашиглах боломжийг олгодог билээ.

Бид Сүмийн түүхтэй, ялангуяа үүсгэн байгуулагдаж байсан түүхтэй танилцах нь чухал юм. Эдгээр түүх нь Иосеф Смитийн Анхны үзэгдэл, Мормоны Номын ирэлт, Иохан Баптист, Петр, Иаков, Иохан, Елиа болон Елиасын тэнгэр элчийн айлчлалтууд, Сэргээлтийн бусад үндэс суурь болсон суурь үнэнүүдийг багтаасан байдаг.

Харамсалтай нь, мэдээллээр бялхсан, техник технологийн энэхүү эрин үед зарим мэдээлэл нь Сүмийн түүхэн дэх үйл явдлуудад болон хүмүүст шүүмжлэлтэй хандаж байгаагаас зарим хожмын үеийн гэгээнтний итгэл нь гуйвж, удаан хугацаанд итгэж байсан зүйлдээ эргэлзэж эхэлдэг. Эргэлзэж байгаа эдгээр хүнд хэлэхэд, хэрэв тэд сайн мэдээний зарчмуудыг дагаж, Сүмийн түүхийг залбирч судалснаар хэсэгхэн эсвэл бүрэн бус мэдлэгээс илүүтэй бүх талын мэдлэг олж авахаар хангалттай судлах юм бол Ариун Сүнс тэдний оюунд амар амгаланг ярьж, Сүмийн түүхэн дэх чухал үйл явдлуудад итгэх итгэлийг нь батлах болно хэмээх хайр, ойлголт, баталгааг би тэдэнд өгч байна. Ийм арга замаар тэд сэргээгдсэн Сүмийн түүхийн талаарх итгэл үнэмшлээрээ баттай болж чадна.

Дүгнэлт

Би Палмирагийн ойролцоо номлолд үйлчилж байхдаа заримдаа ганцаараа Ариун ойн цоорхойд очиж, Анхны үзэгдэл болох үед ойн цоорхойд ургаж байсан гурван амьд модны нэг өөрийнхөө дуртай “гэрчлэгч модны” дэргэд бишрэл хүндэтгэлтэй зогсдог байв. Хэрэв энэ мод ярьж чаддаг байсансан бол 1820 оны хаврын тэр өдөр юу харснаа надад хэлэх байсан байх даа гэж төсөөлөн боддог байлаа. Гэвч аль хэдийн мэддэг болсон зүйлээ модноос сонсох нь надад тийм ч шаардлагатай зүйл байсангүй.

Өсвөр насанд минь эхэлж, одоо хүртэл үргэлжилж байгаа сүнслэг туршлага болон, мэдрэмжүүдийнхээ ачаар би Бурхан, бидний Эцэг амьд гэдгийг мэддэг болсон. Би бас Түүний Хүү, Есүс Христ бол бүх хүн төрөлхтний Аврагч, Цагаатгагч гэдгийг мэднэ. Эдгээр алдар суут хоёр хүн Иосеф Смит дээр хүрч ирснийг би мэднэ.

Энэхүү алдар суут үнэнүүд нь Ариун ойн цоорхойд эхэлсэн юм. Би та бүхнийг оюун ухаан, зүрх сэтгэлээрээ үргэлж Ариун ойн цоорхойд зогсож, Бурханы тэнд илчилж эхэлсэн үнэнүүдэд үнэнчээр амьдрахад уриалж байна. ■

2012 оны 5-р сарын 6-нд АНУ-ын Калифорнид болсон СБС-ийн онцгой цугларалт дээр хэлсэн үгээс хэсэгчлэн авав. Бүрэн эхээр үзэх бол cesdevotionals.lds.org хаягаар орно уу.

Эшлэл

1. Ойн цоорхойн талаар хуваалцсан санаануудаас минь заримыг надтай хуваалцсан, Палмирад амьдардаг, Сүмийн ойн мэргэжилтэн, байгаль судлаач Роберт Парроттод би таархал илэрхийлж байна.

АЛДАГДСАН 500 ЖИЛ: МАЛАХИГААС ИОХАН БАПТИСТЫГ ХҮРТЭЛ

Хуучин Гэрээнээс Шинэ Гэрээ хүртэлх 500 жил нь Есүс Христийн ирэлтээс өмнөх эртний Палестин дахь нөхцөл байдлын талаар бидэнд зааж, Аврагчийг дагах амлалтаа шинэчлэхэд бидэнд тусалдаг.



С.Кэнт Браун

Эртний судар судлаач, профессор болон **Ричард Нийцл Хозапил** Бригам Янгийн Их Сургуулийн Сүмийн түүх ба сургаал судлаач, профессор

Бошиглогч Малахиг МЭӨ 450 оны үед нас барахад жинхэнэ бошиглогчийн дуу хоолой 500–гаад жилийн турш дахин сонсогдсонгүй. Бид энэ эрин үеийг гэрээнүүд хоорондын үе Хуучин ба Шинэ Гэрээнүүдийн хоорондох завсар үе гэдгээр нь мэддэг. Бошиглогчгүйгээр тэр

нутаг дахь хүмүүс судруудыг орчуулж, хүмүүсийг удирдах эрхийг өөрсдөдөө олгосон хэсэг, бүлгүүдэд хуваагдаж эхлэв. Иеховагийн талаарх үнэн бодит ойлголт эдгээр бүлгийн дунд багасчээ. Бурхан шинэ бошиглогч Иохан Баптистыг шинэ эрин үеийг эхлүүлэхээр илгээхэд эргэлзээ дагуулсан урт удаан цаг хугацаа төгсгөл болов. Гэвч Иохан Баптист байсан ч, Аврагч хүмүүст сургаалаа зааж байсан ч олон хүн гэрээнүүдийн хоорондох үед хөгжиж, эрчимжсэн уламжлал, итгэл үнэмшлээ ялан дийлж чадахгүй байв. Бид энэхүү 500

МЭӨ539 он



ГРЕКЧҮҮД МЭӨ332 он

жилийг болон үүнээс болж үүссэн эргэлзээ төөрөгдлийг ойлгосноор Аврагчийн тохинууллын талаар илүү ихийг ойлгож, Түүнийг дагах амлалтуудаа шинэчилж чадна.

Дүрвэлт ба боолчлол: Дуулгаваргүй байдлын төлөөс

Исаиа, Иеремиа зэрэг бошиглогчид Иерусалимын иргэдэд, хэрэв тэд Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ зөрчсөөр байвал хот болон ариун сүмүүд нь устгагдах болно хэмээн сэрэмжлүүлжээ. МЭӨ 600 оны үед Вавилон Иудейн тосгон, суурин, хотуудыг болон шашныг нь устгаж, эзлэн түрэмгийлж эхлэхэд энэ бошиглол биелэгдсэн билээ.

Эцэст нь Иерусалим МЭӨ 587 онд унасан бөгөөд дүрвэсэн иудейчүүд устгагдсан эх орноосоо хөөгдөн гарав (Дуулал 137:1-ийг үзнэ үү). Иерусалимд болон үүний ойролцоо үлдсэн самаричуудаас бүрдсэн цөөн хүн сүүлд нь өөр үндэстний хүмүүстэй гэрлэв (Иеремиа 40:7, 11–12-ыг үзнэ үү). Дараа нь дүрвэгчид Палестинд эргэн ирж эхэлсэн ба гэр орон болон шашнаа дахин барьж төвхнүүлсэн юм (Езра 3-ыг үзнэ үү). Иерусалимд ариун сүм сүүлд буюу МЭӨ 515 онд дахин баригдаж, дахиад иудейчүүдийн хүндэтгэл бишрэлийн төв болов.

Бошиглогч Исаиа, Иеремиа нар иудейчүүдэд тэднийг харийнхан захирах болно гэдгийг сэрэмжлүүлж байв. Тэр бүс нутаг олон өөр үндэстний олон хаанаар эзлэн түрэмгийлэгдэх үед тэдний бошиглолууд биеллээ олсон билээ. Эдгээр нь Вавилоны хаан Небухаднезар, Персийн их Кореш, Персийн хаан Дари, Грекийн их Александр байв. Александрыг нас барахад түүний газар нутгийг жанжнууд нь хувааж авчээ. Птолемай I Палестиныг хяналтандаа авав.

Иудейчүүд ариун сүмээ дахин барихад нь туслах гэсэн самаричуудын саналаас татгалзсан учраас самаричууд дөрөвдүгээр зууны сүүлээр Иерусалимын хойд хэсэгт, ойролцоогоор 64 км-ийн зайд орших Геризим уулан дээр өөр нэгэн ариун сүм барьжээ. Ийнхүү Геризим уулан дээрх шинэ ариун сүм ба Иерусалимын ариун сүм хоёр нь санваарынхаа эрх мэдлээр өрсөлдөж байсны улмаас Иеховаг хүндлэх хүндэтгэл болон итгэл үнэмшил нь хуваагдан задарсан юм (Иохан 4:20-ыг үзнэ үү).

Гэтэл шашны энэхүү сэргэлт хөдөлгөөн удаан үргэлжилсэнгүй. Бошиглогч Амосын бошиглосноор, Малахийн дараа Их Эзэн “талхаар өлсөх, усаар цангах бус харин Эзэний үгийг сонсохын төлөө өлсгөлөн” (Амос 8:11) илгээв. Хүмүүс бошиглогчийн эрх мэдэл бүхий сургаал, тайлбаргүйгээр хуулийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээснээр энэхүү чухал өөрчлөлт нь томоохон үр дүнг бий болгосон билээ.

Урвалтын нөхцөлүүд

Энэхүү урвалтын үр дүнд хүмүүс улс төр, шашин, нийгмийн олон төрлийн хүсэл сонирхлоороо хуваагдав. Тэд Мессиагийн талаарх өөрсдийн итгэл үнэмшил, соёл ёс заншлаараа ялгарч байв. Шашны бүлгүүд нь



СЕЛҮСИДЧҮҮД МЭӨ198 он

БОСЛОГО МЭӨ 164 он

ТУСГААР ТОГТНОСОН ИУДЕЙ ҮНДЭСТЭН МЭӨ142 он



Мосегийн хуулийг ойлгосон үедээ үүний дагуу амьдрахаар хичээж байсан ч бүлэг бүр судруудыг өөр өөр өнцгөөс орчуулан, тайлбарлаж байсан учир иудейчүүдийн нийгэм илүү олон хэсэг болон хуваагдаж байлаа. Үүний үр дүнд Аврагчийн талаарх жинхэнэ ойлголт эргэлзээтэй болж эхлэв.

Бошиглогчдын дуу хоолой намжсан учраас тахилчид болон ариун сүмийн ажилтнууд нь левичүүд ба иудейчүүдийн дунд чухал байр суурь эзэлж, өөрсдөдөө судар хөрвүүлэх эрх мэдэл олгож байжээ. Гэсэн ч, тэр үед ахлах тахилчийн албыг худалдаж, худалдан авдаг болтол авилгач шинжтэй болсон байлаа.

Иудейчүүд тахилчдыг болон левичүүдийг хуулийг зөв заах үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй байна гэж үзэж байв (Дэд хууль 33:10-ыг үзнэ үү), тиймээс хуулийг заах зорилгоор нэгэн шинэ бүлэг байгуулагдсан байна. Суралцаж мөн хуулийг дуулгавартай дагахад хүмүүсээ яаравчлуулсан Езрагийн жишээг тэд даган дуурайв хэмээн тэмдэглэгдэн үлдсэн байна (Езра 7:25; Нехемиа 8:1–8-ыг үзнэ үү).

Их Александр хаан энэ бүс нутгийг МЭӨ 332 онд эзлэн авчээ. Түүнийг нас барахад жанжнууд нь хаант улсыг нь хуваан авчээ. Энэ үед грекээр ярьдаг, Селүсидчүүдийн эзэн хаад Палестиныг

Селүсид эзэн хаадын нэг Антиокус IV Эпифанис Палестиныг захирав. Антиокус заримдаа иудейчүүдийг олноор нь хөнөөж, иудейчүүдийн шашны зан үйлийг хориглон, ариун сүмийг гутаан доромжилж, иудейчүүдийн нийгмийг Грекийн ёс заншил руу хүчээр уусган өөрчилж байв. Грекчүүдийг эсэргүүцэгч иудейчүүдийн удирдагч Иуда Маккабиус бослогыг удирдаж, ариун сүмийг дахин онцгойлон адисалсан байна. Хүмүүс Хануккаг анх удаа тэмдэглэв.



эрхшээлдээ оруулжээ. МЭӨ 167 онд Селүсидчүүдийн удирдагчид хөвч хөндөхийг хориглож, тахилын ширээн дээр гахай өргөн, мөн ариун сүмийг гутаан доромжилж, иудейчүүдийн шашныг хориглов. Маккабийн эсвэл Хасмонийнс нэрээрээ танигдсан нэгэн гэр бүлээр удирдуулсан олон иудей хүн эсэргүүцэл үзүүлж байжээ. Маккабийн дайн хэмээн нэрлэгдсэн энэхүү бослого нь эцэстээ иудейчүүдэд эрх чөлөөг авчирч, Иерусалимын уналтаас хойш анх удаа Иудей хэмээн нэгэн үндэстэнг бий болгосон байна. Энэ үед “сүсэгтнүүд” хэмээх нэртэй өөр нэгэн шашны бүлэг байгуулагджээ. Тэд Мосегийн хуулиас ойлгосон хэсгүүдээ нэг бүрчлэн дагаж, Бурханд үнэнчээ харуулдаг байв.

Гэрээнүүд хоорондын үед ч бас судруудыг орчуулах онцгой эрхийг өөрсдөдөө олгосон өөр өөр шашны бүлэг шинээр гарч ирж байв. Фарисайчууд бол Маккабийн дайны дараахан удалгүй гарч ирсэн бие даасан нэгэн шашны бүлэг байжээ. Тэд судруудад биш, харин аман уламжлалд үндэслэн бий болсон хоолны хуулинд болон зан үйлийн цэвэр ариун бөгөөд онцгой байдалд чанд анхаарал хандуулж, танилцуулснаар иудейчүүдийн нийгэмд маш нэр нөлөөтэй болсон байна. Тэд гэр орондоо ариун сүмд амьдарч байгаа мэт байхыг хичээдэг байв.

РОМЧУУД МЭӨ63 он

Нөгөө талаас, гарал үүсэл нь мэдэгдэхгүй үлдсэн садукайчууд бусад бошиглогчийн бичээсүүдийг үл тоомсорлон, аман уламжлалуудыг эсэргүүцэж, Мосегийн таван номыг ягштал баримталдаг байв. Энэ бүлэглэл нь Иерусалимын нийгмийн нөлөө бүхий хүмүүсээс бүрддэг байжээ. Есүсийг төрөх үеэр тэд ариун сүмийг хяналтандаа авч байгаа тухай зарлаж, хүчээ авсан юм.

Шашны эдгээр бүх бүлэглэл нь сүсэг бишрэлтэй амьдралд чухал гэж итгэдэг байсан ёс заншил, сургаалуудаа хадгалж үлдсэн байна. Гэвч тэдэнд жинхэнэ бошиглогчийн удирдамж дутагдсан учраас тэд өөр өөрсдийнхөө ойлголттой үлджээ.

Шинэ эрин үеийг хүлээсэн нь

Шашны итгэл үнэмшлээс үл хамааран зөв шударга эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэрээнүүд хоорондын үед ч Мессиагийн ирэлтийг тэсэн ядан хүлээсээр байв. Яруу найрагчид дуулал дуулж, олон нийт Өөрийн хүмүүсийг аврахаар ирэх Давидын хаан Түүний ирэлтийн талаар залбирч, ярилцаж, мөрөөдөж байв.

Мессиаг хүлээж байсан өөр нэгэн бүлэглэл бол Маккабийн зөрчилдөөний үед байгуулагдсан Эссэнэс бүлэглэл байв. Эссэнэс бүлэглэл нь Иерусалим дахь ариун сүмийн тахилчид авилгад идэгдсэн

Иерусалим хотыг хэсэгхэн хугацаанд тусгаар тогтносны дараа Помпей хаан түүнийг эзлэн авснаар хот Ромын ноёрхолд оржээ. Ромчууд Есавын удмын хүн болох Херодыг иудейчүүдийн хаан болгов. Тэрээр Иерусалимыг дахин босгож, ариун сүмийн хэсгийг өргөжүүлсэн юм. Цезарь Август Ром дахь бүгд найрамдахчуудын ноёрхлыг зогсоон, Юлий Цезарийн дараа Ромын хоёрдугаар эзэн хаан болсон байна.

бөгөөд ариун сүмийг шинэчлэх шаардлагатай гэж үзэж байв. Тэдний бодлоор Мессиагийн ирэлт ойрхон байлаа. Тэд Есүсийг төрөхөөс өмнөх 60-аад жилийн турш Палестиныг эзлэн түрэмгийлсэн Ромын харгис буулгыг авч хаяхад Есүс тэдэнтэй нэгдэнэ гэдэгт итгэдэг байв.

Сэргээлтийн өмнөх шинэчлэлтэй адил, гэрээ хоорондын эрин үе нь бас Есүс Христийн ирэлтэд дэлхийг бэлтгэсэн үйл явдлуудыг гэрчилдэг. Энэ үед еврей Библийн грек хэл дээрх орчуулга, Сөнөсөн тэнгисийн хуйлмал бичиг, Апокриф зэрэг бүтээлийн эхлэлийг оролцуулаад шашны уран зохиолын гайхалтай бүтээлүүд төрөн гарсан юм. Энэ үеэр тэнгэр элч, амилаалт, тэнгэр болон тамын талаарх ойлголтууд хөгжиж, сайжирсан байна.

Гэсэн хэдий ч тэднийг удирдах бошиглогч байгаагүй учраас иудейчүүд судруудын утга учрын талаар болон Мессиа хэн байх талаар мэтгэлцдэг байжээ. Ихэнх хүн Давидын Мессиаг (Давид хааны удам) хүлээж байхад бусад нь Аароны хүү байсан Мессиа тахилчийг хүлээж байв. Харин зарим нь ямар ч Мессиаг хүлээгээгүй байв.

Гэрээнүүд хоорондын эрин үед өөр өөр бүлэглэлүүдийн олон таамаглал байсан учир бүлэглэлүүд жинхэнэ Мессиаг ирэх үед Түүнийг хэрхэн танихаа мэдэхгүй байв.



ХЕРОД ХААН

ЦЕЗАРЬ АВГУСТ

ПОНТИ ПИЛАТ



Бүлэглэлүүд хуулийн багш нар, фарисайчууд, эссэнэсчүүд эсвэл садукайчуудын аль нь ч Иохан Баптистыг бошиглогч гэж, Есүсийг Мессиа хэмээн хүлээж аваагүй юм. Эдгээр бүлэглэлийн зарим гишүүн Иохан, Есүс нарыг номлолоо хийж байх үеэр гол дайснууд нь болсон билээ (Матай 21:23–46-г үзнэ үү).

Бүлэглэлүүдийн дунд Мессиагийн талаарх маргаан, мэтгэлцээн үргэлжилсээр байв. Шинэ эрин үеийн анхны бошиглогч Иохан Баптист жинхэнэ Мессиагийн ирэлтийг зарлаж, Түүний боломжтой болгох авралын мөн чанарыг тодорхой болгосон. Есүс Христийг тодорхойлж, Иохан: “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун” (Иохан 1:29) хэмээн хэлсэн юм. Иоханыг Христийн ирэлтэд хүмүүсийг бэлтгэж байхад олон иудей хүн түүнийг хүлээн авчээ.

Есүс тохинууллаа эхлэх үедээ “хуулийн багш нар шиг нь бус, эрх мэдэлтэй нэгэн шиг хүмүүст” зааж байв (Матай 7:29). Тэрээр гэрлэлтийн сургаалууд, амиалалт, Бурхан Тэргүүтэн болон Аврагчийн хувьд Өөрийнхөө үүргийг тодруулан, шашны удирдагчидтай олонтоо ярилцдаг байв. Шашны олон удирдагч Есүсийг эсэргүүцэж байсан учраас (Матай 26:4-ийг үзнэ үү) Тэрээр тэдэнд хандан: “Та нар

ЦЕЗАРЬ АВГУСТ БОЛОН ХЕРОД ХААНЫГ ЗАХИРЧ БАЙХ ҮЕЭР АВРАГЧ ЕСҮС ХРИСТ БЕТЛЕХЕМД МЭНДЭЛСЭН. ТЭРЭЭР ХААДЫН ХААН, ЭЗДИЙН ЭЗЭН БОЛОН МЭНДЭЛСЭН ЮМ (ИСАИА 44:6-г үзнэ үү).

Намайг ч, Эцгийг минь ч танихгүй: хэрэв та нар намайг таньсан бол Миний Эцгийг ч мөн таних байсан” хэмээн хариулсан юм. Тэр цааш нь “Хэрэв Бурхан та нарын Эцэг байсан бол, та нар Намайг хайрлах байсан” (Иохан 8:19, 42) гэжээ.

Учир нь тэд Мессиаг Есүсээс маш өөрөөр төсөөлж байсан болохоор тэд Түүнийг эсэргүүцсэн юм. Аз болоход, бид сайн мэдээний үнэнүүд нь бошиглогч болон төлөөлөгчдийн үндэс суурь болсон сургаалууд дээр тулгуурлагдсан эрин үед амьдарч байна (Ефес 2:20-ийг үзнэ үү). Бид бошиглогч, төлөөлөгчдийн удирдамж байхгүй үед бий болдог хоорондоо зөрчилтэй сүнсний нөлөөнүүдээс сонгох ёсгүй. Бид хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийг дагаж байгаа үед бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн Аврагч Есүс Христийн үнэн сургаалыг ойлгох болно:

“Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ.

Түүгээр, мөнхүү түүгээр дамжин, мөн түүнээс дэлхийнүүд бүтээгдсэн, бас бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн хөвгүүд, охид бөлгөө (С ба Г 76:23–24). ■



СӨНӨСӨН ТЭНГИСИЙН ХУЙЛМАЛ БИЧГҮҮД

ОРЧИН ҮЕИЙН БИБЛИЙН ЦОНХ

Доналд В. Парри

Бригам Янгийн Их Сургуулийн Еврей Библийн профессор

1947 оны эхэн үеэр Таамира Бидоун үндэстний гурван хоньчин ижлээсээ төөрсөн нэгэн хонийг хайж байлаа. Тэдний нэг нь агуй руу чулуу шидэхдээ вааран бортого хагарахыг сонсжээ. Тэд агуй руу ороод тэнд хэд хэдэн том шавар ваар байхыг олж харав. Эдгээр ваарны заримд нь хуйлмал бичээсүүд хийсэн байв.* Үүний дараахан Бидоун болон археологчид Сөнөсөн тэнгисийн баруун хойд эрэг дээрх 11 агуйгаас олон зуун хуйлмал бичиг олсон байна.

Олон эрдэмтэн Сөнөсөн тэнгисийн хуйлмал бичгүүдийг 20-р зууны хамгийн агуу археологийн нээлт гэж үздэг. Уг хуйлмал бичгүүдийн ихэнх хэсэг нь Хуучин Гэрээний еврей хэлээр бичигдсэн, 900 гаруй хуудас бүхий гар бичмэлтэй эртний номын сан болдог. Хуйлмал бичгүүдээс ойролцоогоор 225 нь Дундад зууны үед хэрэглэгдэж байснаас 1000 гаруй жилийн түүхтэй Хуучин Гэрээний хуучин хувиудыг агуулдаг (Естер номоос бусад нь). Зарим эх бичмэл нь МЭӨ 3-р зууныг хүртэл байсан ч ихэнх хуйлмал бичиг нь МЭӨ 150-аас МЭ 68 оныг хамарсан байв.

Уламжлалт Библийн эх бичвэрүүдээс гадна Сөнөсөн тэнгисийн хуйлмал бичгүүд нь Ариун сүмийн хуйлмал бичиг (Иерусалимд баригдах ариун сүмийг болон үлгэр жишээ гэрээт нийгмийг тодорхойлсон), Дайны хуйлмал бичиг (төгсгөлийн зөрчилдөөнүүдийг тодорхойлсон)

болон Библитэй төстэй гар бичмэлүүдийг (Енох, Ноа, Мелкизидекийн эдгээр ном болон Иаков, Иуда Левийн гэрээнүүд) түүнчлэн багтаадаг. Библи дээр Енохын талаар бага гардаг ч хуйлмал бичгүүд дээр Енох чухал дүр бөгөөд онцгой бэлгүүдтэй хүчирхэг бошиглогч байв.

Хуйлмал бичгүүдийн ихэнх нь олон зууны турш бараг устаж, үгүй болсон ч эрдэмтэд тэдгээрийн талаар их мэдээлэл олж авах боломжтой байв. Бичээч нар нэг үеэс дараагийн үед ариун бичгүүдийг хуулбарлан, шилжүүлэхэд тэдний чимхлүүр, нягт нямбай ажил нь мэргэжил, чадварын өндөр түвшинг харуулдаг. Ариун судруудыг хайрлаж, тэдний төлөө талархалтай байдаг бид бүгд бичээч нарын чимхлүүр нямбай ажлын төлөө тэдэнд асар их өртэй билээ.

Бид гар бичмэлүүдийг гараар дамжуулан шилжүүлэх эртний арга хэрэгслүүдийг бодож үзвэл Библи нь энэ эрин үе хүртэл хадгалагдаж ирэхийн тулд гайхалтай үйл явцыг даван туулсныг ойлгох болно. Сөнөсөн тэнгисийн хуйлмал бичгүүд нь Хуучин Гэрээг олон зууны турш нэлээд нарийн няхуур байдлаар дамжиж ирснийг гэрчилдэг. Үүний төлөө бид бошиглогч, бичээч, хувилагч болон Библийг үеэс үед дамжуулахад үүрэг хүлээж байсан хүн бүрд талархах ёстой. ■

**Хуйлмал бичгүүдийг олж нээсэн түүхүүд нь хоньчдын түүхэн он жилүүдийг хэрхэн санаж байгаагаас шалтгаалан өөр өөр байдаг.*





Бишоп Гари
И.Стивэнсон
Тэргүүлэх бишоп

Аврагч төрөөгүй,
Цагаатгал хийгдээгүй байсан бол бид Эцэгийн өмнө биднийг өмгөөлөх Зууч, Өмгөөлөгчгүй байх байсан бөгөөд Хайрт Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө эргэн очиж, мөнхийн гэр бүлээрээ хамтдаа амьдрах боломжийг бидэнд олгодог Зуучгүй байх байсан.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН БОДИТ БАЙДЛЫГ ТАНЬЖ МЭДЭХ НЬ

Аав маань бага байхдаа Юта нуурын ойролцоо, төв Юта дахь нэгэн жижигхэн тосгонд амьдардаг байв. Анхдагчдыг ирэхээс өмнө уугуул америкчууд тэр хэсэгт ан хийж, загасчилдаг байжээ. Нуурын ойролцоох тодорхой хэсгүүд сумны зэв хайж байсан хүмүүст танил болсон байв.

Аавыг таван настай байхад эцэг, хөвгүүдийн үйл ажиллагаагаар тойрог нь Юта нуур руу сумны зэв хайхаар явжээ. Тэд бүхэл өдрийн турш сумыг хайсны эцэст өвөө маань ааваас сумны зэв олсон эсэхийг нь асуусан байна.

“Үгүй ээ, би юу ч олсонгүй” гэж аав хариулжээ. Тэгээд тэр халаасаа тэмтэрч, “харин би гацуур модны хэлбэртэй энэ гоё чулууг олсон” гэжээ.

Аав маань үнэндээ сумны зэв олчихсон байв. Гэвч тэр үүнийгээ мэдээгүй байлаа. Тэр гартаа жинхэнэ сумны зэв барьчихсан зогсож байсан ч үүнийг таниагүй байв.

Гэтэлгэгчийг таних нь

Өнөөдөр олон хүний хувьд дэлхийн Аврагч Есүс Христийг харах бодитой бөгөөд хамгийн чухал хараа нь бодит бус зүйлүүдээр сарнин бүдгэрчээ.

Би саяхан Есүс Христ үнэхээр онгон Мариагаас төрсөн эсэхэд эргэлзээ төрүүлсэн Есүс Христийн талаарх телевизийн хөтөлбөр үзсэн. Нэр хүндтэй байгууллагуудаас уригдан ирсэн агуу профессорууд хүртэл энэ нь боломжтой эсэх талаар эргэлзэж байв.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) иймэрхүү эргэлзэгчдэд хариулан, хэлэхдээ: “Эрдэмтэд хэмээн нэрлэгддэг тэр хүмүүс нь Шинэ Гэрээнд тунхаглагдсан Христийн тэнгэрлэг төрөлт тэнгэрлэг төрөлт байгаагүй бөгөөд Есүсийг төрөх үед Мариа онгон байгаагүй гэдэгт биднийг итгүүлэхийг хичээдэг. Тэд Есүсийн хойд эцэг Иосеф нь Түүний маханбодын эцэг бөгөөд тиймээс Есүсийн бүх шинж чанар, хандлагууд нь хүнийх байсан гэдэгт итгүүлэхийг хүсдэг. Тэд Түүнийг ёс суртахууны хувьд агуу философич, бүр магадгүй хамгийн агуу нь байсан гэж хэлэхдээ Түүнийг магтаж байгаадаа их өгөөмөр харагддаг. Гэвч Христийн шашны бусад бүх эрх мэдэл нь оршин тогтнодог Есүс бол бурханлаг хүү хэмээх сургаалыг тэд үгүйсгэдэг юм”¹ гэжээ.

Би хиймэл цасан дээр цанаар гулгаж, Христийн мэндэлсний баярын дуураймал модыг дуураймал мөсөөр чимэглэсээр ирсэн. Заримдаа бодит зүйлийг,



АВРАГЧИЙГ ОЛОХ НЬ



“Заримдаа хамгийн үнэ цэнэтэй болон ариун нандин зүйлүүд нь бидний яг өмнө тод харагдаж байдаг, гэвч

бид тэднийг харж чаддаггүй эсвэл хардаггүй. . . .

“Хэрэв бид амьдралаа жаахан л эмх журамтай байлгаж, чин сэтгэлээсээ, даруухнаар цэвэр ариун, дөлгөөн Христийг зүрх сэтгэлээрээ эрэлхийлэх юм бол бид Түүнийг Христийн мэндэлсний баяраар жилийн турш харж мөн олох болно гэдгийг би амлаж байна.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Дийтр Ф.Угдорф, “How to See the Christ in Christmas,” *New Era*, 2013 оны 12-р сар, 48.

ялангуяа цахим ертөнц хөгжсөн өнөө үед бодит байдлыг ойлгоход хэцүү байж болно. Тиймээс бид бодит зүйлийг хэрхэн ойлгодог вэ? Бид Есүс Христийн бодит байдлын талаарх гэрчлэлийг хэрхэн олж авдаг вэ?

Бид эртний болон орчин үеийн судрууд дээрх Бурханы үгийг аль алиныг нь уншсанаар бодит зүйлийн талаарх гэрчлэлийг олж авдаг. Бид амьд бошиглогч, төлөөлөгчдийн гэрчлэлүүдийг сонсож, уншсанаар Аврагчийн бодит байдлын тухай мэддэг. Бид “Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр” (Моронай 10:4) залбирах үед үнэнүүдийг олж мэддэг. Бид “Христэд итгэж, түүнийг үгүйсгэхгүй байж,” “түүний өмнө доош бөхийж, мөн түүнийг [өөрсдийн] бүхий л хүчин чадал, оюун, мөн чадлаараа мөн [өөрийн] бүхэл бодгалиар бишрэн шүтсэнээр” (2 Нифай 25:29) “зөв замаа” олдог.

Христийн төрөлтийн тухай бошиглолууд

Судрууд нь Христийн төрөлт Христийн мэндэлсний анхны баярын бошиглолуудаар дүүрэн байдаг. Бид эдгээр судрын бошиглолуудыг зөвхөн *бошиглолууд* байсан мэтээр унших үед тэдгээрийг мартаж болно. Тэдгээр нь юу болох гэж байгаа талаар түүнчлэн юу хараахан болоогүй байгаа талаар гайхалтай тодорхой мэдээлэл өгдөг.

Христийг мэндлэхээс 800 жилийн өмнө Исаиа хэлэхдээ: “Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө. Засаглал Түүний мөрөн дээр байх болно. Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна” (Исаиа 9:6) гэжээ.

Аврагчийг мэндлэхээс 600 жилийн өмнө Нифай Бурханы Хүүгийн эхийг харсан нэгэн үзэгдлээ дүрслэхдээ:

“Мөн би Назар хотыг үзэв . . . бас Назар хот дахь онгон бүсгүйг би харав, мөн тэрбээр үлэмж хонгор мөн цагаан байлаа. . . .

Мөн [тэнгэр элч] надад хандан: Болгоогтун, таны харж буй тэр онгон бүсгүй бол Бурханы Хүүгийн махан бодийн биеийг төрүүлэгч эх нь бөлгөө хэмээв. . . .

“Мөн би сайхь онгон бүсгүйг харж, гар дээрээ хүүхэд тэвэрсэн байхыг болгоов.

“Мөн тэнгэр элч надад хандан: Бурханы Хургыг болгоогтун” (1 Нифай 11:13, 18, 20–21) гэжээ.

Аврагчийг мэндлэхээс 124 жилийн өмнө хаан Бенжамин:

“Учир нь болгоогтун, тэр цаг ирнэ, мөн энэ нь хол зайтай бус . . . Төгс Хүчит Их Эзэн хүмүүний үрсийн дунд тэнгэрээс хүчтэйгээр бууж ирэх болно, мөн махбодийн асарт орших болно . . . хүчит гайхамшгуудыг үйлдэн, хүмүүний дунд урагшлан явах болно. . . .

“Мөн тэрээр Есүс Христ, Бурханы Хүү, тэнгэр ба газрын Эцэг, эхлэлээс бүх зүйлийг Бүтээгч хэмээн нэрлэгдэх болно; мөн түүний эх Мариа гэгдэх болно” (Мозая 3:5, 8) хэмээн хэлсэн билээ.

Христийг төрөхөөс 83 жилийн өмнө Алма: “Мөн болгоогтун, [Бурханы Хүү] бидний эцэг өвгөдийн нутаг болох тэр Иерусалимд Мариагаас төрөх болно, тэр нь онгон бүсгүй, сонгогдсон мөн хонгорхон бүсгүй” (Алма 7:10) гэжээ.

Христийн мэндэлсний анхны баяраас зургаахан жилийн өмнө лемен үндэстэн Самуел зарлахдаа:

“Мөн болгоогтун, түүний ирэлтийн тэмдэг болгон би үүнийг та нарт өгөх болно; учир нь болгоогтун, тэнгэрт агуу гэрлүүд байх болно, үүний хэрээр түүнийг ирэхийн өмнөх шөнө харанхуй болохгүй, үүний хэрээр энэ нь хүмүүнд өдөр мэт үзэгдэх болно. . . .

“Мөн болгоогтун, та нарын хэзээ ч тийм нэгнийг болгоогүй тэрхүү нэгэн шинэ од гарах болно” (Хиламан 14:3, 5) гэжээ.

Иудейчүүд энэхүү агуу үйл явдлыг тэсэн ядан хүлээж байв. Тэд Мессиаг ирнэ гэдгийг мэдэж байсан ба Түүнийг алдар суундаа ирж,



тэднийг чөлөөлөн, дэлхийн хаант улсыг байгуулж, тэдний Хаан болно гэдэгт итгэж байлаа.

Мессиагийн төрөлтийн талаар хэн анх мэдсэн бэ? Энэ нь ямар нэгэн зөвлөлийнхөн эсвэл хүч, нөлөө бүхий албан тушаалтнууд байсан уу?

Тэнгэр элчүүдийн “үлэмж баярлуулах сайн мэдээг” (Лук 2:10) тунхагласан тэр хүмүүс нь газар унтгаж байсан эгэл даруу хоньчид байсныг, мөн “зүүнтэйд одыг хараад Түүнд мөргөхөөр [ирсэн]” (Матай 2:2) мэргэн хүмүүс байсныг Библи бидэнд өгүүлдэг билээ. Харах чадвар нь энэ дэлхийн гүн ухаанаар саармагтсан хүчирхэг, нөлөө бүхий хүмүүс Аврагчийн төрөлтөөр эсвэл Түүний тохинууллын турш Түүнтэй хамт байгаагүй юм. Тэдний өмнө бодит зүйл байсан хэдий ч тэд үүнийг мэдээгүй буюу хүлээн аваагүй ажээ.

Христэй илүү адил болох нь

Христийн мэндэлсний баярын үеийн хамгийн агуу зүйлүүдийн нэг нь Бурханы зүйлүүдэд хандах бидний мэдрэмжийг нэмэгдүүлэх

явдал гэж ерөнхийлөгч Бэнсон хэлжээ:

“Энэ нь бидэнд Эцэгтэйгээ харилцах харилцаагаа болон өөрсдийгөө Бурханд хэр зэрэг зориулж байгаагаа тунгаан бодоход тусалдаг.

“Энэ нь биднийг илүү хүлцэнгүй, өглөгч, бусдыг илүү ойлгодог, илүү өгөөмөр, илэн далангүй, найдвар, энэрэл, хайраар дүүрэн болж, Христийнхтэй адил бүх зан чанарыг олж авахад өдөөдөг. Христийн мэндэлсний баярын сүнс дэлхий даяар хүмүүсийн зүрх сэтгэлд хүрч байгаад гайхах зүйлгүй билээ. . . . Хэсэгхэн хугацаанд ч болов, Их Эзэн болон Аврагч, Есүс Христ рүү анхаарал хандуулан, бишрэн шүтэх нь нэмэгддэг байна.”²

Энэ Христийн мэндэлсний баяраар энэхүү улирлын сүнс зүрх сэтгэлд нэвтрэн ордог учраас Бет-лехемд мэндэлсэн бяцхан хүү нь жинхэнэ Гэтэлгэгч гэдгийг ойлгосноо харуулж, энэ мэдрэмжээ бодитоор илэрхийлэх ямар нэг зүйл хийцгээе. Ерөнхийлөгч Ховард В.Хантэр (1907–95) бидэнд үүнийг хийхэд туслах аргыг заахдаа:

“Маргадсан бол энэ Христийн мэндэлсний баяраар эвлэр. Мартагдсан найзаа эрж хай. Хардлага сэрдлэгээ итгэлээр соль. Захиа бич. Зөөлөн хариулт өг. Өсвөр үеийнхнийг урамшуулан дэмж. Үг, үйлдлээрээ үнэнч шударга байдлаа харуул. Амласандаа хүр. Хэн нэгэнд гомдсон бол март. Дайснаа уучил. Уучлалт гуй. Ойлгохыг хичээ. Бусдаас юу шаардаж байгаагаа ажигла. Өөр хэн нэгний талаар эхлээд бод. Эелдэг, зөөлөн байж, илүү их инээ. Талархлаа илэрхийл. Танихгүй хүнийг урь. Хүүхэд баярлуул. Байгалийн үзэсгэлэнт сайхан газруудаас таашаал ав. Хайраа дахин дахин илэрхийлж бай” гэсэн зөвлөгөөг өгсөн юм.³

Христгүйгээр Христийн мэндэлсний баяр байх боломжгүй юм. Христгүйгээр, бүрэн дүүрэн баяр хөөр байж чадахгүй. Аврагч төрөөгүй, Цагаатгал хийгдээгүй байсан бол бид Эцэгийн өмнө биднийг өмгөөлөх Зууч, Өмгөөлөгчгүй байх байсан ба Хайрт Тэнгэрлэг Эцгийнхээ өмнө эргэн очиж, мөнхийн гэр бүлээрээ хамтдаа амьдрах боломжийг бидэнд олгодог Зуучгүй байх байсан.

Би та бүхэнтэй хамт Бурханы Хүүгийн төрөлт ба тохинууллын сүр жавхлантай бөгөөд гайхамшигт бодит байдлыг тэмдэглэж байна. Мөн би Есүс Христ бол бидний Аврагч, амлагдсан Мессиа гэдгийг гэрчилж байна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. *The Teachings of Ezra Taft Benson* (1988), 128.
2. Эзра Тафт Бэнсон, Ларри С.Портэр, “Remembering Christmas Past: Presidents of the Church Celebrate the Birth of the Son of Man and Remember His Servant Joseph Smith,” *BYU Studies*, vol. 40, no 3. (2001), 108.
3. Ховард В.Хантэр, “The Gifts of Christmas,” *Ensign*, 2002 оны 12-р сар, 18–19.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРААР ЭЭЖДЭЭ ОЁЖ ӨГСӨН ХӨНЖИЛ

10 настай охиноо тархины хавдраар нас бараад удаагүй байхад амьдралын маань хамгийн хэцүү цаг мөчүүдийн нэг тохиолдсон юм. Нэгэн бямба гаргийн үдээс хойш биднийг түүний өрөөг харж зогсох үед “Та нар үүнийг өөрсөдтэйгөө хамт аваад явж чадахгүй” гэдэг үг маш тод сонсогдов.

Кларисса байхгүй болсон ч өрөөнд нь түүнийг байсныг илэрхийлэх зүйлүүд байсан хэвээр байв. Бидэнд одоо түүний хувийн эд зүйлүүдийг яах хэрэгтэйг шийдэх хүндхэн ажил оногдоод байлаа. Нэг ч гэсэн зүйлээс салах нь, ялангуяа эхнэрт маань хэцүү байх болно гэдгийг би мэдэж байв.

Эмнэлэг, химийн эмчилгээ, цацраг идэвхт эмчилгээтэй холбоотой олон зүйлээс болж бидэнд цэвэрлэж, эмхэлж цэгцлэх цаг маш бага үлдсэн байлаа.

Биднийг түүний орны толгой дээрх эсвэл номын шүүгээн дэх түүний тавьсан зүйлүүдийг боож баглах үед олон дурсамж санаанд орж байв. Түүний дуртай хөнжил, ном эсвэл чихмэл амьтдынх нь хүзүүний зүүлт, сургуулийн номнууд, хөл бөмбөг зэрэг нь бидний хувьд тун их утга учиртай байв. Тэдгээрийг яах хэрэгтэйг эхнэрээсээ асуухад тэр цурхиран уйлж билээ.

Бид Клариссагийн олон номыг цуглуулж, бусад хүүхдэд

хэрэглүүлэхээр түүний бага сургуульд аваачиж өгөв. Бид шүүгээг нь хөршийндөө, зарим хувцсыг үеэлүүдэд нь өгсөн. Бусдад анхаарлаа хандуулах нь түүний хэрэглэж байсан зүйлүүдээс салах хэцүү нөхцөл байдлыг арай амархан болгоход тусалсан юм.

Хэдэн долоо хоногийн дараа, Христийн мэндэлсний баяр ойртож байх тэр үеэр өсвөр насны 2 охин маань ээжээсээ Христийн мэндэлсний баярын онцгой бэлэг барихын тулд Клариссагийн зарим хувцсыг ашиглаж болох уу гэж асуув. Тэд гэр бүлийнхээ бодит дурсамжинд зориулан хувцасны дугаар бүрийг сонгож, түүний амьдралын үнэ

Эхнэр маань бэлгээ задалж, өөрт нь зориулан охидынхоо хийсэн зүйлийг хараад, сэтгэлээ хэрхэн илэрхийлснийг би үргэлж санах болно.



БИ ОДОО Л ТҮҮНД ҮЙЛЧЛЭХ ХЭРЭГТЭЙ

цэнэтэй мөчүүдийг төлөөлүүлэхээр дөрвөлжин нүднүүдийг болгоомжтой хайчлав.

Тэд Христийн мэндэлсний баяраас хэдхэн хоногийн өмнө, энэ санааг гаргахад нь тэдэнд тусалсан Залуу эмэгтэйчүүдийн удирдагчтайгаа хамт оёж байгаа хөнжлөө надад үзүүлсэн юм. Би Клариссагийн амьдрал дахь үйл явдлыг төлөөлж буй дөрвөлжин даавуу бүрийг, тухайлбал: түүний хөл бөмбөгийн дүрэмт хувцаснаас авсан дөрвөлжин, гэр бүлийн аялалд явж байхдаа түүнд худалдан авч өгч байсан цамцнаас авсан дөрвөлжин, эмнэлэгт байхдаа түүний өмсдөг байсан унтлагын өмднөөс авсан дөрвөлжин гэх мэтийг гайхан харж байв. Хэсэг бүр нь үнэ цэнэтэй, үзэсгэлэнтэй сайхан байсан учраас түүнтэй өнгөрүүлсэн цаг хугацаа бүрийг минь надад сануулж билээ. Би охиддоо үүнийг төгс болсон байна гэж хэлэв. Энэ зүйл ээжид нь таалагдах болно гэдгийг би мэдэж байлаа.

Тэр Христийн мэндэлсний баярын өглөө би чин сэтгэлээсээ өгсөн нэгэн бэлгийг олж харсан юм. Эхнэр маань бэлгээ задалж, өөрт нь зориулан охидынхоо хийсэн зүйлийг хараад, сэтгэлээ хэрхэн илэрхийлснийг би үргэлж санах болно. Үүнээс хойш тэр орой бүр дурсамжуудаа эргэн санаж, Есүс Христийн Цагаатгал болон амиалалтын ачаар гэр бүл нь дахин хамтдаа байх тэр өдрийг мөрөөдөн, Христийн мэндэлсний баяраар авсан хөнжлөөрөө өөрийгөө ороож суудаг болсон юм. ■

Жэд Пакэр, АНУ, Юта

Би оёдлын машин дээрээ сууж, ноосон даавуунуудыг давхарлан оёж байв. Зөөлөн өнгөтэй, хүүхдүүдэд зориулсан загварууд нь дээд хэсгийг чимж, хослуулах өнгөнүүд нь хүүхдүүдэд өгөхөөр миний оёж байгаа хөнжлүүдийн арын хэсгийг хэлбэртэй болгож байв.

Манай тойргийн Халамжийн Нийгэмлэг нь ядуу болон гамшиг тохиолдсон бүс нутгуудад зориулан нярай хүүхдийн иж бүрдэл цуглуулдаг. Би сонирхогчийн түвшний оёдолчин хэдий ч оролцоно гээд амлачихсан байв. Ноосон даавуугаа сонгож, хөнжлийн хэмжээтэй дөрвөлжлөн хайчлах нь надад сайхан санагдаж байлаа.

Би ноосон даавуунуудыг зөв талаар нь тавиад, ирмэгээр нь оёж, хөнжлийн зөв талыг гадагш эргүүлэхийн тулд онгорхой хэсэг үлдээдэг. Дараа нь би ирмэг дагуу хэрж, булангууд гарган, өнгөн хэсгийг нь ил гаргахын тулд хөнжлийг эргүүлж, онгорхой хэсгийг оёдог.

Оёдлоо бэхлэхийн тулд би ирмэгийн дээд хэсгийн дагуу оёдог. Мөн би ноосон даавуугаа оёдлын машин дээрээ болгоомжтой байрлуулснаа дараа хурдхан оёж эхэлдэг юм. Гэрийнхээ ажлыг үргэлжлүүлэн хийхийн тулд үйлээ дуусгахаар яаравчлах үед “Хэрэв би энэ хөнжлийг Есүс хүүд зориулан оёж байсан бол яах байсан бэ?” гэсэн бодол надад орж ирдэг юм.

Ингэж бодсоноор би удааширч, шулуун оёхын тулд илүү анхаардаг. Анхааралтай оёсон ч оёдол нь шулуун явдаггүй байв.

Дараа нь би ард, урд хэсгийг холбохын тулд голд нь 10 инч (25 см) талбайг оёдог. Би зузаан цаасаар хэв хийж, үүнийгээ хөнжил дээрээ голлуулж, тойруулаад хөнгөн зурж, тэмдэглэдэг. Би ноосон даавуугаа машиндаа болгоомжтой байрлуулаад, зүүтээ доошлуулан,

анхааралтай оёж эхэлдэг.

Би хийж дуусгаад, утаснуудаа хайчилж, дууссан хөнжлөө гаргаж ирдэг. Энэ нь дөрвөлжин хэлбэртэй биш трапец болон параллелограммын хэлбэртэй төстэй болсон байдаг.

Би хөнжлөө хойш нь тавьж, шинэ даавуу гаргаж ирээд, Бурхан Тэргүүтэнд энэхүү бэлэг нь зохистой байхын төлөө илүү их хүч чармайлт гарган дахин эхэлдэг. Илүү их хүч чармайлт гаргасан хэдий ч үр дүн нь яльгүй байх нь ч байдаг. Миний оёсон хөнжил бүр төгс биш байдаг.

Би ядаж энэ жилдээ аль ч хөнжлөө цуглуулгын газар руу явуулахгүй дээ гэж бодов. Би үргэлжлүүлэн дадлагажиж байгаад, хэзээ нэгэн өдөр хувь нэмрээ оруулна.

Гэтэл “Хэрэв чи төгс оёдог боллоо хүлээвэл бяцхан хүү Христ Египетэд байх болно” гэсэн өөр нэгэн бодол оюун бодолд минь орж ирэв.

Би ойлголоо. Үйлчлэх боломж өнгөрөн одно. Аврагч биднийг чадах бүхнээ хийхээр хичээх үед өргөлүүд маань нь төгс биш байсан ч тэдгээрийг хүлээн авна. Би зөөлөн, цэвэр хөнжилд өлгийдүүлсэн шинэ төрсөн хүүхэд булангууд нь төгс биш гээд унтахаас татгалзахгүй гэдгийг мэднэ.

Миний хичээл зүтгэл дэлхий даяарх хэрэгцээнд нэмэр болж чадах талаар тунгаан бодох үедээ би “Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” гэсэн Христийн зөвлөгөөг санадаг (Матай 25:40).

Тиймээс би хөнжлөө оёж, аль болох гоё болгохын тулд үргэлжлүүлэн ажиллаж байна. Энэ нь тэдгээрийг төгс оёж чаддаг болох ирээдүйн тодорхой бус цаг хугацаанд биш, харин одоо л хэрэгцээтэй байгаа гэдгийг би мэднэ. ■

Жийн Хэдэнгрэн Молтри,
АНУ, Вашингтон

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ХАМГИЙН АГУУ БЭЛЭГ

Христийн мэндэлсний баярын өмнөх орой манай гэрийнхэн уламжлал ёсоор цуглараад байв. Та нарт үзүүлэх зүйл байна гэж аав биднийг дуудах үед бараг шөнө дунд болох гэж байв.

Христийн мэндэлсний баярын уур амьсгалд дарагдаад, эгч нар, ээж, бид хэд баярт зориулан аав юу бэлтгэснийг анзаараагүй байв. Биднийг бүгдээрээ цугларсны дараа тэр бидэнд хэдэн слайд үзүүлж эхлэв.

Аврагчийн зураг, Христийн мэндэлсний баярын үйл явдлууд болон сайтар бэлтгэсэн үгстэй слайдуудаараа дамжуулан аав бидэнд хайраа илэрхийлсэн юм. Мөн түүний танилцуулга нь Христийн мэндэлсний баярын жинхэнэ утга учир болон Аврагчийн төрөлтөөр мэдэрвэл зохих аз жаргал болон талархлыг бидэнд сануулж өгсөн юм. Өнгөлөг зул сарын гацуур модны зурагтай нэг слайд дээр “Энэ Христийн мэндэлсний баяраар Есүс Христийн хайр надад шинэ амьдрал өгөх болно” гэсэн байв.

Бидэнд мэдээгээ хэлэхийн тулд аавын ашигласан танилцуулгын хамгийн онцгой хэсэг нь Аврагчийн зурагтай слайд дээр гарч ирэв. Энэ нь зүгээр нэг мэдээ биш байв. Аврагчийн дээр “Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртэхээр шийдлээ” гэсэн үгс байв.

Аав маань эцэстээ Сүмд нэгдэхээр шийджээ! Ийм шийдвэр нь зарим хүний хувьд амархан байж болох ч аавын маань хувьд хэцүү байсан юм. Тэр 25 жилийн турш сайн мэдээг судалж, Сүмийн талаар суралцсан. Бид чадахынхаа хэрээр хичээж мөн тэрээр олон номлогчтой ярилцаж байсан ч баптисм хүртэхгүй хэвээрээ л байв. Бид хэзээ ч яагаад гэдгийг нь ойлгодоггүй байсан ч түүнийг бэлэн биш байсныг мэдэж байлаа.

Аавыгаа хэзээ ч баптисм хүртэхгүй байх гэж боддог байснаа би хүлээн зөвшөөрч байна. Гэсэн ч сэтгэл дотроо би найдвараа хэзээ ч алдаагүй бөгөөд бид бүгд түүний

төлөө үргэлжлүүлэн залбирдаг байв. Христийн мэндэлсний баярын өмнөх орой Их Эзэн бидний залбиралд хариулсан юм.

Аавыг энэ талаар хэлэхэд бид баярласандаа уйлав. Бидэнд баяр хөөр, гайхширал болон хамгийн чухал нь үгээр илэрхийлэх аргагүй асар их аз жаргал зэрэг олон мэдэрмж зэрэг зэрэг мэдрэгдэж байв.

Аавын зарлал Христийн мэндэлсний баярын өмнөх оройг төдийгүй бүхэл бүтэн гэр бүлийн амьдралыг өөрчилсөн билээ. Бид хувь хүн болон гэр бүлээрээ өсөж хөгжих шаардлагатай хэвээр байгаа ч Сүмд хамтдаа байгаа болохоор урагшлахад илүү сайн байна гэдгийг би мэднэ.

Энэ адислалын төлөө би Их Эзэнд үнэхээр их талархаж байна. Хэдхэн сарын дараа бид ариун сүмд гэр бүлээрээ лацдан холбогдох болно. Аавын зарлал яах аргагүй Христийн мэндэлсний баярын хамгийн агуу бэлэг байсан юм. ■

Адриана Нава Наварро, Боливи



Бидэнд мэдээгээ хэлэхийн тулд аавын ашигласан танилцуулгын хамгийн онцгой хэсэг нь Аврагчийн зурагтай слайд дээр гарч ирэв.

МУШГИРАЛДСАН ТӨМӨР ДООРХ ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯР

Би дэлхийн 2-р дайны үеэр Филиппиний Манилад үйлчилж байхдаа ариун ёслолын цуглааныг зохион байгуулахаар цөөн хэдэн ХҮТ цэрэгтэй уулздаг байв. Нэгэн цуглааны үеэр бөмбөгт өртсөн, бидний байрлаж байсан барилгын арын хэсэгт, хаалга байсан онгорхойгоор хараад зогсож байсан нэгэн филиппин эмэгтэйг би ажигласан юм. Бидний дуулж байгааг сонирхсон байх гэж би бодов. Хаалтын залбирал хийхээр биднийг нүдээ аних үед тэр чимээгүй алга болсон байв.

Тэрээр дараа нь олон удаа ирсэн бөгөөд нэг цуглааны үеэр бид түүнийг өөрсөдтэйгөө нэгдэхэд урив. Түүний нэрийг Анисэта Фаяардо гэдэг байсан ба тэр бидний нөхөрлөлийг урам зоригтой хүлээн авав. Тэр бидний цуглаануудад үргэлжлүүлэн оролцож, Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар суралцсан юм.

Христийн мэндэлсний баяр ойртох үеэр бид Анисетад болон түүний гэр бүлд Христийн мэндэлсний баярын бэлэгнүүд өгөхөөр шийдэв. Бид лаазалсан сүү, мах, ногоо, хэдэн хөнжил болон Анисетагийн өвчтэй байгаа зээ хүүг эдгээхээр пенициллин болон бусад эмийг цуглуулав.

Христийн мэндэлсний баярын өмнөх орой бид бэлэгнүүдээ ачиж, Анисетагийн гэр рүү явлаа. Тэрээр бөмбөгт өртсөн барилгын үлдэгдэл тоосгон ханыг налуулан тавьсан мушгиралдсан нимгэн төмөрний дор охин, зээ хүү хоёртойгоо хамт амьдарч байсан. Бид тэднийг халуун орны хүчтэй борооны улиралд ийм муу халхавчтай хэрхэн амьдарч чаддагийг гайхаж байв.

Манай эрэгтэйчүүдийн нэг нь манго жимсний модны мөчрийг татаж, үүнийгээ газарт суулгав. Бид мөчир чимэглэх жаахан хог олов.

Анисэта болон түүний гэр бүл

баярлаж, гайхсан харцаар харцгааж байв. Бидний авчирсан бэлэгнүүдийг хараад тэдний баяр хөөр нь аз жаргал, талархлын нулимс болон хувирсан юм. Тэд ийм хоол хүнсийг удаан хугацаанд хараагүй буюу идээгүй байсан бөгөөд тэд ихэд уйлж байсан болохоор нэлээн удаан ярьж чадахгүй байж билээ.

Христийн мэндэлсний баярын өмнөх орой байсан учир бид гэр орныхоо тухай болон хайртай хүмүүсийнхээ талаар бодож эхлэв. Аав болсныг минь надад мэдэгдсэн нэгэн цахилгаан шууданг хоёрхон хоногийн өмнө хүлээн авсан талаараа бодлоо. Бид мэдрэмжүүдээ хуваалцаж, төгсгөлд нь Аврагчийн тухай болон сэргээгдсэн сайн мэдээний талаарх гэрчлэлүүдээ хуваалцав.

Бид тэдний төлөөх Аврагчийн хайрыг энэ гайхамшигтай гэр бүлд үзүүлсэн. Тэд бидний хэлсэн үгсээс тайвшралыг олж, амар амгалангийн

мэдрэмж шөнийн агаарыг дулаацуулсан билээ. Тэгээд бид эрхэм найз нартаа баяртай гэж хэлээд, тэдэнд Христийн мэндэлсний баярын мэнд хүргэв.

Удалгүй би шинэ хэсэг рүү шилжиж, Анисетаг буюу түүний гэр бүлийг хэзээ ч дахин хараагүй юм. Гэвч олон жилийн дараа би *Сүмийн түүхэн лавлах толь* дээрх Филиппиний хэсгийг нээж, Анисэта Пабилон Фаяарда нь арлууд дээрх Сүмд нэгдсэн хамгийн анхны филиппин хүн байсныг олж уншсан.¹ 1945 онд тэрхүү Христийн мэндэлсний баярын үеэр таригдсан тэдгээр үрийн талаар бодох нь хэчнээн гайхамшигтай адислал гээч. ■
Эрвин И.Воркис, АНУ, Айдахо

ЭШЛЭЛ

1. "Филиппин," *Deseret News* 1991–1992 *Church Almanac*, 157-г үзнэ үү; *Сүмийн лавлах толийн* сүүлийн үеийн хэвлэлтүүд дээр Фаяарда эгчийн өөрийн нэрийг Анэлэта гэж бичсэн байна.

Бид манго жимсний модны мөчрийг татаж, үүнийгээ газарт суулгав. Анисэта болон түүний гэр бүл баярлаж, гайхсан харцаар харж байв.



БҮХ ХЭЦҮҮ
асуултын
хариулт



Хэцүү асуултуудтай тулгарсан үед, зөвхөн нэг л асуулт хамгийн чухал байдаг.

Р.Вал Жонсон

Сүмийн сэтгүүлүүд

Амьдралын турш бидэнд тохиолддог асуултуудад хариулахад тэр бүр амархан байдаггүй. Бидэнд тохиолддог хувийн зарим сорилт бэрхшээл хүүхдийн үхэл, жишээ нь найзын урвалт, эсвэл санхүүгийн азгүй өөрчлөлтийг ойлгоход үргэлж амархан байдаггүй бөгөөд бидэнд эргэн тойрны хүмүүсийн маань нигүүлсэнгүй тусламж дэмжлэг хэрэгтэй байдаг. Заримдаа ийм үед соригдох шалтгаантай байсан ч, шалтгаанаа одоохондоо ойлгож чадаагүй байсан ч, Тэнгэрлэг Эцэг маань бидэнд хайртай бөгөөд биднийг шийтгээгүй гэдгийг ойлгох нь хамгийн хэцүү байдаг.

Бидний итгэдэг зүйлүүд нь соёлын чиг хандлагаар юм уу шинэ мэдээллээр, заримдаа биднийг эсэргүүцдэг Сүмийг шүүмжлэгчдийн ташаа мэдээллээр солигдож, соригдох үед хамгийн хэцүү зарим асуулт гарч ирдэг. Ийм үед бидний сургаалын эсвэл түүхийн үндэс суурь нь бидний бодсон шиг бат бөх

биш мэт санагдаж болно. Бид зөв гэдгийг нь баталсан үнэнүүдээ болон бидний итгэлийг бий болгосон сүнслэг туршлагууддаа эргэлзэн, уруу татагдаж ч магадгүй.

Зүрх сэтгэлд маань эргэлзээ бий болох үед бид юу хийдэг вэ? Эдгээр хэцүү асуултад хариултууд үнэхээр байдаг гэж үү?

Тийм ээ, байдаг. Үнэндээ бүх хариулт, бүх зөв хариулт нь: Би хэн нэгнээс илүү, Бурханд итгэдэг үү? гэсэн нэгхэн асуултын хариултаас шалтгаалдаг юм.

Энгийн боловч амархан биш

Энэ хандлага нь хэтэрхий энгийн үү? бас амархан уу?

Тийм ч байж магадгүй. Ялангуяа анхаарал татахуйц арга замаар гарч ирсэн хувилбаруудтай тэмцэх ёстой болсон үед үнэн үргэлж тодорхой байдаггүй. Суралцах ёстой бүхэл үнэн байхад бид үнэний зөвхөн хэсэгхэнийг л ойлгодог. Сурах явцаа бид төгс бус байдлаа ялан гарах тавгүй зүйлүүдтэй ч, бас тайвшруулагч ойлголтуудтай ч тулгардаг. Бурханд бүх хариулт байгаа. Тэр биднийг хайрладаг бөгөөд Тэр бидний бүх асуултад Өөрийн арга зам, цаг хугацаандаа хариулах болно гэдэгт итгэх нь бидний эрлийг хялбарчлах болно. Энэ нь үргэлж амар хялбар байдаггүй ч Бурханы зөвлөгөөнд энгийнээр итгэх нь бидэнд эргэлзээн ний мананг аюулгүй даван гарахад туслах болно.

2013 оны 10-р сарын Сүмийн Ерөнхий чуулганы үеэр Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Дийтр Ф.Угдорф энэхүү гярхай ажиглалтыг хийжээ:

“Асуулттай байна гэдэг нь хэвийн зүйл юм. Чин сэтгэлийн асуултын жижиг үр ихэнхдээ соёолж, ойлголтын агуу том мод болон ургадаг. Ноцтой эсвэл эмзэг асуултуудын талаар хэзээ нэгэн цагт эргэлзэж байгаагүй сүмийн гишүүд цөөхөн байдаг. Сүмийн зорилгуудын нэг бол зарим үед итгэлийн үрийг бүр эргэлзээ бүхий болон итгэлгүй байдлын элсэрхэг хөрсөнд тарьж, арчилж ургуулах явдал ч байдаг. Итгэл бол үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах нь юм.

“Тиймийн тул, хайрт ах эгч найз нөхөд минь итгэлдээ эргэлзэхээсээ өмнө эргэлзээндээ эргэлз. Эргэлзээ биднийг олзлон, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин ирдэг хайр, амар амгалан, бэлэгнүүдээс маань холдуулахыг бид хэзээ ч зөвшөөрч болохгүй.”¹

Тус болох зарим зарчим

Тиймээс бид эргэлзээндээ чин сэтгэлээсээ эргэлзэхийн тулд юу хийдэг вэ? Бид хэрхэн өөрсдийнхөө итгэлийг хувирч өөрчлөгддөг хүмүүний ойлголтын элсэрхэг суурин дээр биш, харин итгэлийн бат бөх суурин дээр барьж байгуулж чадах вэ? Энэ нь биднийг дараах зарчмуудыг санахад тусалж болох юм.

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ: Бурхан бидний мэддэгээс хязгааргүй ихийг мэддэг. Бид асуултуудтай тулгарах үед хувийн, нийгмийн эсвэл сургаалын аль нь ч бай, дэлхий ертөнцийн Бүтээгч биднээс хамаагүй ихийг мэддэг гэсэн бодит байдалд найдаж болно. Хэрэв Тэр ямар нэг зүйлийг онцлон хэлсэн бол (эсвэл хэлээгүй байсан ч) Түүний



ЗАРЧИМДАА ҮНЭНЧ БАЙХ ЗОРИГ

“Хэн нэгэн олон нийтийн үзэл бодол, сайшаалын хувирч өөрчлөгддөг элсэн дээр үндсээ суулгах үед дээшээ цэх зогсох боломжгүй байдаг. Бид бүгд айдас, доог тохуу, эсэргүүцэлтэй тулгарах болно. Бүгдээрээ нийтээр зөвшөөрөгдсөн зүйлийг сөрж, зөв зарчмын төлөө зогсох зоригтой байцгаая.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Хүчтэй бөгөөд зоригтой бай,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 86.

ХАРИУЛТУУДАА ОЛ

Хэцүү асуултуудынхаа талаар дэлгэрэнгүй судлахаар бол бусад дэмжих онлайн эх сурвалжуудын нэг хэсэг болох [lds.org/topics](https://www.lds.org/topics) болон [history.lds.org](https://www.history.lds.org) хаягаар орж үзнэ үү.

ойлголтууд биднийхээс илүү тодорхой гэдэгт бид итгэж болно.

“Учир нь миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж Эзэн айлдаж байна.

“Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ” (Исаиа 55:8–9).

ХОЁРДУГААР ЗАРЧИМ: Бурхан мэддэгийнхээ зарим хэсгийг хуваалцдаг. Нэгдүгээр зарчмын үр дүн бол биднийг хүлээн авахад бэлэн байгаа үед, мөн Бурхан Өөрөө өгөхөд бэлэн байгаа үедээ Тэрээр мэддэгийнхээ хэрээр бидэнтэй хуваалцдаг явдал юм. Бид зөвхөн үүнийг хүлээж авч мөн эрэлхийлэхэд өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй. Судрууд нь олон асуултад хариулдаг. Энэ амьдралын агуу зүйлүүдийн нэг нь биднийг хичээнгүйлэн судлах үед Тэрээр хариулахдаа судруудыг ашиглан “шат шатаар, дүрэм дүрмээр энд бяцханыг тэнд бяцханыг” (2 Нифай 28:30) илчилж, Ариун Сүнсээр заадаг явдал юм.

Зарим асуулт, ялангуяа түүхэн үйл явдлуудын талаарх асуултууд нь үндэслэлтэй тайлбаруудтай байдаг ба илүү их мэдээлэл судлахын хэрээр бидний ойлголтууд илүү тодорхой болдог.

Бид тэнгэрийн удирдамж дор бидэнд заах амьд бошиглогч, төлөөлөгчидтэй байхаар адислагдсан билээ. Бид сургаалын салхи бүрд “нааш, цааш шидэгдэн, туугдах шаардлагагүй” юм. Тэдний хамтын удирдамж нь “бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл” бидэнд туслах



болно гэдэгт бид итгэж болно” (Ефес 4:11–15.)

ГУРАВДУГААР ЗАРЧИМ: Бид Бурханы хайранд итгэж болно. Бурхан биднийг бидний төсөөлж чадахаас ч илүү хайрладаг. Бид Түүний хүүхдүүд бөгөөд Тэр биднийг нас биенд хүрэн, Түүнтэй адил болох чадавхтай болж, алдар суунд Түүний өмнө эргэн ирээсэй хэмээн хүсдэг (Моисе 1:39-ийг үзнэ үү). Түүний бидэнд өгдөг бүхий л зөвлөгөө нь биднийг мөнхөд адислахын тулд чин сэтгэлийн хайраар өгөгддөг билээ. Бид тэрхүү хайранд бүрэн дүүрэн итгэж болно.

“Бурхан аа! Таны энэрэл хайр хичнээн үнэтэй вэ! Хүмүүн таны жигүүрийн сүүдэр дор хоргоддог” (Дуулал 36:7).

ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ: Бид сүнслэг баталгаануудыг эрэлхийлэх шаардлагагүй. Хэрэв дэлхийн мэргэн ухааны ийм их хэсэг нь Бурханы мэргэн ухааны эсрэг байвал

бид гайхах хэрэггүй. Тэнгэрлэг арга замаар илчлэгдсэн төлөвлөгөөний дагуу бид Бурханы дэргэдээс болон оюун ухаанаас тусгаарлагдсан, унасан дэлхийд амьдарч байна. Ийм нөхцөл байдал нь Бурханы зүйлүүдийг ойлгох ойлголтыг хэцүү болгодог, “учир нь хүний дотор буй сүнснээс нь өөр хүний бодол санааг хэн мэддэг билээ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй. . . .

“Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнснээс үзэгддэг” (1 Коринт 2:11, 14).

Хэрэв бид Бурханы зүйлүүдийг ойлгох гэж байгаа бол хариултуудыг авахдаа дан ганц хүмүүний мэргэн ухаанд найдаж болохгүй. “. . . Сүнсээр сургадаг; сүнснээс үзлэлийг сүнснээс тайлбарладаг Бурхан бидэнд үнэгүй өгсөн юмсыг мэдэхийн тулд” бид Бурханы Сүнснээс байх хэрэгтэй (1 Коринт 2:12–13).

Бид баптисм хүртэж, Христийн сүмийн гишүүнээр батлагдах үед бидэнд Ариун Сүнсний бэлэг өгөгддөг. Энэхүү бэлгээр дамжуулан бид Сүнснээс суралцаж, Түүний үнэний талаарх тайвшруулах баталгааг хүлээн авах болно. Ийм сүнснээс баталгаануудыг хүлээн авах нь хамгийн үндэслэлтэй логикоос илүү, эргэлзээнүүдийг үгүй болгодог бөгөөд энэ нь чин сэтгэлээсээ залбирч, хичээнгүйлэн судалж, Их Эзэний тушаалуудад дуулгавартай байснаар үнэнийг эрэлхийлдэг тэдгээр бүх хүнд боломжтой юм.

“Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ (Матай 7:7).

ТАВДУГААР ЗАРЧИМ: Бид Их Эзэнд найдан хүлээх хэрэгтэй байж болох юм. Өөрсдөдөө тохиолдсон зовлон бэрхшээл, асуултуудыг ойлгохоор хичээх үедээ бид заримдаа амжилттай байдаггүй. Хамгийн сайнаараа хичээсэн ч бид ойлгох боломжгүй

байдаг. Тэнгэр хаалттай юм шиг санагддаг. Ийм үед Бурханд итгэх итгэл маань биднийг Түүнд найдан хүлээх тэвчээртэй болгодог. Бүх асуулт тэр дороо эсвэл энэ амьдралд ч хариулагдахгүй байж болно. Биднийг үхэхээс өмнө бүх сорилт бэрхшээл авагдахгүй. Гэвч бид бүх зүйлээс илүүгээр Бурханыг хайрлаж, биднийг гэсэн Түүний хайранд итгэх юм бол хөшиг өргөгдөж, бүх зүйл тодорхой болох тэр өдөр ирэх хүртэл бид итгэлтэйгээр тэвчих боломжтой байх болно.

“Өөрийн замыг Эзэнд даатга; мөн Түүнд итгэж найд; Тэгвэл Тэр биелүүлж өгнө.

“Тэр чиний зөв шударгыг гэрэл мэт, чиний шударга хэргийг үд дундын гэрэл мэт илэрхий болгоно.

“Эзэн дотор дуугүй байж, Түүнийг тэвчээртэйгээр хүлээ” (Дуулал 37:5–7). ■

ЭШЛЭЛ

1. Дийтр Ф. Угдорф, “Ирж, бидэнтэй нэгдэгтүн,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 23.





Дэвид Л.Бэк

Залуу эрэгтэй-
чүүдийн ерөнхий
ерөнхийлөгч

АВРАГЧ БА АРИУН ЁСЛОЛ

АРИУН ЁСЛОЛЫН ТАЛААРХ МИНИЙ ТҮРШЛАГА

Миний санаж байгаа-
гаар, ариун ёслолын
турш Есүс Христийн талаар
бодохыг надад хэлдэг байв.
Өнгөрсөн арванхоёрду-
гаар сард анх ариун ёслол
түгээх үед амар амгалан,
ариун мэдрэмж надад мэд-
рэгдсэн. Христэд ирэхэд
бусад хүнд тусалж байгааг
Сүнс надад хэлэхийг би мэд-
эрсэн. Би Тэнгэрлэг Эцэг-
тээ Түүнд үйлчилж, бусдад
туслах боломжийг олгодогт,
мөн надад хангалттай итгэ-
дэгт нь талархаж байна.

**Иаков Р., 12 настай,
АНУ, Айдахо**

*Та нар ариун
ёслолоос хүртсэ-
нээрээ Аврагчийг
үргэлж дурсан
санах гэрээгээ
шинэчилдэг.*



Та нар ариун ёслолын талхнаас идэж, уснаас уухдаа эсвэл ариун ёслолыг бэлдэж, адисалж эсвэл түгээж байхдаа юуны талаар боддог вэ? Бидний ихэнх нь гэрээнүүдээ болон хэрхэн амьдарч байгаагаа тунгаан боддог. Бид нүглүүдийнхээ талаар бодож, өршөөл хүсэн залбирч, илүү сайн байх арга замуудыг гаргадаг.

Эдгээр нь ариун ёслолын чухал хүчин зүйлүүд болдог юм. Үүнээс гадна тунгаан бодох гүн гүнзгий, тодорхой зүйл байдаг учир энэ нь ариун ёслолын залбирлуудын нэг хэсэг болдог. Энэ бол Бурханы Хүү, дэлхийн Аврагч, Есүс Христийг санах явдал юм. Талхыг идэж буй тэдгээр нь “Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж, мөн үүнийг идэж” мөн “үргэлж түүнийг санах” болно хэмээн амладаг (С ба Г 20:77). Үүнтэй адил, уснаас ууж буй тэдгээр нь “Хүүгийн цусыг төлөөлөн дурсаж, тэд үүнийг үйлдэж болохын тулд” мөн “тэд үргэлж түүнийг санана” (С ба Г 20:79) хэмээн амладаг.


Аврагч болон Түүний Цагаатгал, золиослолыг дурсан санах сонголт нь ариун ёслолын үндсэн хэсэг юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Ариун ёслолын залбирлуудын энгийн хийгээд гайхамшигтай хэллэгэнд бидний сонсдог чухал үг нь *санах* юм

шиг санагддаг. . . . Хоёр залбиралд аль алинд нь *оницлон хэлсэн* зүйл нь Христийг дурсан санаснаар бүтэхийгддэг. Ингэж оролцсоноор бид түүний Сүнс бидэнтэй үргэлж хамт байж болохын тулд Түүнийг үргэлж санах болно гэдгээ гэрчилдэг” гэж заажээ.¹

Аврагч мөнх бус тохинууллынхоо сүүлийн орой загалмай дээр дахин зовохоосоо өмнө Гетсеманий цэцэрлэгт бидний төлөө зовж шаналсан тэр шөнө, Иерусалимд болсон Дээгүүр өнгөрөх баярын үеэр төлөөлөгчдөдөө ариун ёслолыг танилцуулж байхдаа эдгээр төстэй санааг оницлон тэмдэглэсэн юм. Жишээ нь, Тэрээр тэдэнд талх идүүлэхээр өгснийхөө дараа “Энэ бол та нарын төлөө өгөх Миний бие мөн: Намайг дурсаж үүнийг үйлд” (Лук 22:19–20; мөн Матай 26:26–28) гэжээ.

Аврагч Америк дахь нифайчуудын дунд айлчлан ирсэн эхний өдрөө ариун ёслолын талаар тэдэнд бас заасан юм. Тэрээр Түүний биеийг болон цусыг төлөөлөн дурсаж хүртэхийг тэдэнд дахин зааварлаж, үүнийг хийснээр “энэ нь Эцэгт та нар намайг үргэлж дурсан санаж байгаагийн гэрчлэл байх болно” (3 Нифай 18:7) гэж хэлсэн. Тэрээр дараа нь тэдэнд “Хэрэв та нар намайг үргэлж санах аваас миний Сүнс та нартай хамт байх болно” (3 Нифай 18:7, 11) гэж амлажээ.

Ямар гайхамшигтай адислал вэ! Биднийг замаас маань төөрүүлж, будлиулахаар байнгын арга замаар хичээж буй сорилт бэрхшээл, үймээн самуун, уруу таталтуудаар дүүрэн дэлхий дээр бидэнд үүнээс илүү чухал бэлэг байж чадна гэж үү? Бид Ариун Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаснаар “бүх зүйлийн үнэнийг мэдэж” (Моронай 10:5) чадна. Энэ нь Их Эзэний хүссэн



АВРАГЧИЙГ САНАХ НЬ

Өөртөө болон гэр бүлийнхээ гишүүдэд Аврагчийг санахад нь туслахын тулд lds.org/go/491214 хаяг дээрх Ирээд, Намайг дага суралцах материалын “Би ариун ёслолын утга учиртай туршлагатай болоход нь бусдад хэрхэн тусалж чадах вэ?” хичээлийн тоймыг судлах талаар бодож үзнэ үү. Энэ хуудсан дээрх “Түүнийг үргэлж санах нь” видео бичлэг нь гэр бүлийн үдшээр ашиглаж болох хүчирхэг эх сурвалж байж болох юм.

арга замаар амьдрах, зөв сонголтууд хийх, итгэлтэй үйлчлэх, Түүнтэй адилхан болоход бидэнд хүч чадал, мэргэн ухааныг өгөх болно.

Та долоо хоног бүр ариун ёслолд оролцохдоо үүнийг санахын тулд юу хийж болох вэ? Та долоо хоногийн турш, мөн амьдралынхаа турш Түүнийг *үргэлж* санаж байхын тулд юу хийж болох вэ?

Би эдгээр асуултыг тунгаан бодож, Аврагчийг үргэлж дурсан санах амлаат авахад та нарыг урьж байна. Энэ нь амьдралыг тань өөрчлөхийг хараад, та нар гайхах болно. ■

ЭШЛЭЛ

1. Jeffrey R. Holland, “This Do in Remembrance of Me,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 68.





ЦОО ШИНЭХЭН ХӨРВӨГЧ БАЙХ НЬ ЯМАР БАЙДАГ ВЭ?

Та шинэ гишүүдэд тулгамдаж байгаа зүйлийг нь ойлгосноор тэдэнд тусалж чадна.

Хэрэв та Сүмд өссөн бол Сүмийн зүйлүүд ерөнхийдөө хэвийн болсон байдаг. Та хурлуудын хуваарь, хамрагддаг цуглааныхаа байр болон хүмүүсийн Сүм дээр өмсдөг хувцсыг мэддэг болсон. Ариун ёслолын цуглаан дээр үг хэлэх, аравны нэг болон мацгийн өргөлөө төлөх, сард нэг удаа мацаг барих зэрэг нь амьдралын тань нэг хэсэг нь болсон байдаг. Мэргэн ухааны үгээр амьдрах, үйлчлэх дуудлага хүлээн авах болон ариун явдлын хуулиар амьдрах нь таны хийж сурах бүх зүйл байдаг.

Харин хөрвөгчдийн хувьд бүх зүйлд дасан зохицоход том өөрчлөлт хэрэгтэй байж болох юм. Мэдээж хэрэг, сайн мэдээ үнэний талаарх гэрчлэл олж авах нь Христийн Сүмийн гишүүн болох анхны алхам юм. Гэвч гэрчлэлтэй байснаар Сүмийн гишүүний амьдралаар амьдрах шилжилт нь амархан зүйл гэсэн үг биш юм.

Сүм үнэхээр өөр санагдаж болно

Би бол үүний нэгэн жишээ юм. Би 13-тай байхаасаа л ХҮТ найзуудтай байсан. Тэгээд 19 настайдаа Сүмд нэгдсэн билээ. Энэ олон жилийн хугацаанд Сүмийн соёлын талаар олон зүйл сурсан хэдий ч би өөртөө томхон өөрчлөлт хийх хэрэгтэй байв. Миний хувьд Сүмийн соёл, туршлагауд нь үнэхээр өөр байсан учраас тэдгээр нь хачин санагдаж байв.

Би өөр сүмд өссөн учраас олон зүйл таны мэддэг эсвэл мэдэх зүйлүүдээс тэс өөр байдаг. Сүмийн тохинуулагч болон найрал дуучид ахлах сургуулийн төгсөлтийн нөмрөгтэй адил нөмрөг өмсдөг байв. Ариун ёслолын цуглаантай дүйцэхүйц мөргөлийн үйлчлэлийн үеэр тохинуулагчид номлолоо хийж, бүхий л хэлэх үгийг тэд хэлдэг байв. Ням гараг бүр бид Эзэний залбирлаа хамт нэгэн дуугаар давтаж, үргэлж "Praise God from Whom All Blessings Flow" дуулыг дуулдаг байсан. Нялх хүүхдүүдэд толгой дээр нь ус дусаан баптисм хүртээж, 14 орчим настай байхад нь гишүүнээр баталдаг байв.



Бид ариун ёслолдоо усны оронд усан үзмийн шүүс хэрэглэдэг байлаа. Ахлах сургуулийн хүүхдүүд ням гаргийн хичээлдээ насанд хүрэгчидтэй хамт оролцож, ангидаа нийгэмд тулгамдаж буй асуудлуудын талаар ярилцдаг байв.

Бидний барилгууд хүртэл миний зочилж байсан ХҮТ барилгуудаас өөр байв. Бид өндөр, шовх дээвэр болон өндөр өнгөт шилэн цонхнуудтай Европ дахь Христийн сүмүүдтэй адил загвараар баригдсан том цуглааны байртай байсан. Найрал дуучдын зогсдог хэсэгт загалмай байрлуулж, нэгэн үзэсгэлэнтэй, өндөр хонхтой цамхаг урд хэсэгт байрладаг байв. Сүмийн үйл ажиллагаа өндөрлөсний дараа би тэр хонхыг дуугаргах дуртай байлаа. Энэ нь хангалттай хүнд байсан учир олс нааш цааш хөдлөх үед бага насны хүүхдийг газраас өргөдөг байж билээ.

Бидний зан заншил, нийгмийн итгэл үнэмшил бас өөр байв. Бидэнд согтууруулах ундаа уух эсвэл тамхи татах нь зүгээр гэж заадаг байв. Өсвөр насандаа найз хөвгүүн юм уу найз охинтой байх нь бас байж болох зүйл байв. Үнэндээ, бидэнд хэрэв чи хайртай гэж үздэг бол гэрлэхээсээ өмнө бэлгийн харьцаанд орсон ч болно гэж заадаг байсан. Бид хэзээ ч гэрчлэлтэй байх талаар ярилцдаггүй байсан. Мацгийн болон гэрчлэлийн цуглааныг би анх хараад гайхаж билээ. Сонин санагдсан тэр зүйлд би итгэж чадахгүй байв. Манай Сүмд явдаг ямар ч хүн ийм байдлаар итгэл үнэмшлээ хуваалцдаггүй байсан юм.

МИНИЙ БАПТИСМЫН ДАРААХ ЭХНИЙ ЗУРГААН САР ҮНЭХЭЭР ХЭЦҮҮ БАЙСАН. БИ СҮМДЭЭ БАРАГ Л ИДЭВХГҮЙ БАЙЛАА. БҮХ ЗҮЙЛ ӨӨР БАЙВ ...

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд ирэх нь зөвхөн мөнх бус байдлын өмнөх амьдрал ба нас барагсдын төлөөх баптисм гэх мэт шинэ сургаалд суралцах явдал биш юм. Энэ бол соёл, амьдралын хэв маяг болон хүсэн хүлээдэг зүйлсийн өөрчлөлт байв. Эдгээр ялгааг шийдвэрлэх нь их хэцүү байсан.

Миний баптисмын дараах эхний зургаан сар үнэхээр хэцүү байсан. Би Сүмдээ бараг л идэвхгүй байлаа. Ялангуяа ганцаараа сүмд явж байсан учраас бүх зүйл өөр байв. Би тодорхой сургаалын зарчмууд дээр болон өнгөрснөөсөө салах мэдрэмжтэйгээ тэмцэлдсээр байлаа.

Аз болоход Сүмийн найзууд маань тэвчээртэй, сайхан сэтгэлтэй, хувирдаггүй байсан юм. Тэд үйл ажиллагаануудад намайг авчирч, оройн хоол болон гэр бүлийн үдшээр гэртээ урьж, надтай хамт залбирдаг байв. Энэ нь намайг зөвхөн Сүмд ороход төдийгүй бас идэвхтэй үлдэж, гэрчлэл маань гуйвах үед хүч чадлыг олох том ялгааг бий болгосон. Эдгээр зүйлийг ойлгоход надад тусалсан тэдэнд би маш их өртэй хүн.

Дараах түүхүүдэд хоёр залуу гишүүн Сүмд орсон өөрсдийн туршлагыг болон Сүмд идэвхтэй үлдэхийн тулд хэрхэн хүч чадал олсон тухайгаа хуваалцжээ. Эдгээр туршлагыг уншаад шинэ хөрвөгчид эсвэл буцаад идэвхтэй болж буй хэн нэгэнд нийгэм, соёлын хувьд дасан зохицож, сүнслэгээр өсөж хөгжих хүч чадал олоход нь туслахын тулд та юу хийж чадахаа бодоорой.

Баптисм хүртэхээр хүлээсэн он жилүүд

Би ахлах сургуульд байхдаа англи хэлний хичээл дээр номлогчидтой уулзаж, тэдэнтэй хамт суралцсаныхаа дараа Сүмд орох шийдвэрээ гаргасан юм. Эцэг эхдээ баптисм хүртэхийг хүсэж байгаагаа хэлэхэд тэд таагүй хариу үзүүлэв. Тэд Сүмийн талаар бүхэлд нь ихийг мэдэхгүй байснаас гадна намайг аюултай ямар нэгэн зүйлд орооцолдох вий гэж айж байв. Тэд намайг боловсролтой болоход Сүм саад болж, бүх дүрэм журмаас болоод намайг амьдралын сайхныг мэдрэхгүй



**БИ ЗАЛБИРЧ, СУДРААС УНШСАНААРАА
БОЛОН ӨНӨӨ ҮЕИЙН БОШИГЛОГЧДЫН
ҮГСЭЭР ДАМЖУУЛАН
ИТГЭЛ БА ГЭРЧЛЭЛЭЭ
ӨӨРӨӨ
ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ БАЙВ.**

ХӨРВӨГЧДӨД ТУЛГАРДАГ ЗҮЙЛҮҮД

Шинэ хөрвөгчдөд тулгардаг сорилт бэрхшээлүүдээс заримыг нь дор бичив. Таны нөхөрлөл сорилт бэрхшээлүүдээ даван туулахад нь тэдэнд хэрхэн тусалж болох вэ?

1. Шинэ сургаалыг ойлгохоор хичээх
2. Төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, дуу хөгжим, кино, ном зохиолыг сонгох
3. Судрын үг хэллэгийг ойлгох
4. ХҮГ бус гэр бүл болон найз нөхдийн хүлээн зөвшөөрөхгүй байдлыг даван туулах
5. Өөр хувцас өмсөх тухайд
6. Сүмд болон семинарт оролцохын тулд цаг заваа зориулах талаар
7. Бишрэн шүтэх үйл явц дахь шинэ туршлага, зан заншлыг сурах
8. Зуршил, үг яриа болон юмсын талаар бодох арга замуудаа өөрчлөх
9. ХҮГ нийгмийн соёлд дасан зохицох
10. *Сайн мэдээ, урвалт* болон *сэргээлт* гэх мэт ХҮГ тусгай үг хэллэгүүдийг сурах

байх вий гэж бодож байлаа. Аав, ээж хоёр намайг бүтэн хоёр жил зургаан сарын турш баптисм хүртэхийг зөвшөөрөөгүй юм.

Эхнээсээ л би соригдож байв. Баптисм хүртэхийн өмнөх хэдэн жилд би итгэлээ хадгалан үлдэх хүч чадал, шаардлагатай итгэлийн төлөө дахин дахин залбирсан. Би Сүмд явж, эсвэл гишүүд, номлогчидтой холбоо тогтоож ч чаддаггүй байлаа. Би итгэл, гэрчлэлээ залбирал, судрын уншлага болон өнөө үеийн бошиглогчдын үгсээр дамжуулан өөрөө хөгжүүлэх хэрэгтэй байв. Би олон сонирхолтой хөтөлбөр, хөгжилтэй үйл ажиллагаануудад оролцоогүй.

Намайг Ром руу шилжихэд бишоп маань манай эцэг, эхийг үнэхээр уурласан үед намайг дэмждэг жинхэнэ найз минь болсон юм. Тэр надад ямар ч байсан эцэг эхээ хайрлах нь чухал гэж заадаг байв.

Намайг баптисм хүртэх үед тойргийн олон гишүүн ирж, намайг дэмжсэн. Би найрал дуунд орж, тэнд олон найзтай болсон. Тэдний нөхөрлөл болон сайхан сэтгэл нь надад гэртээ байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг байлаа.

Бид Есүс Христийн сургаалуудад үнэнч байж, бусдыг хайрлаж, анхаарал халамж тавихдаа Түүний жишээг дагаснаар шинэ хөрвөгч, сонирхогчид биднийг заасан зүйлийнхээ дагуу амьдардгийг олж харах болно.

Оттавио Карусо Италийн гишүүн бөгөөд одоо бүрэн цагийн номлолд үйлчилж байна.

Дасан зохицохгүй байх нь

Би 13 настай байхдаа Сүмд нэгдэн орсон. Надад сайн мэдээний гэрчлэл байсан ч Сүмд тийм ч их дасан зохицохгүй байгаа юм шиг санагдаж байв. Хүн бүр дуу болон судрын түүхүүдийг мэддэг байхад би мэддэггүй байв. Хүн бүр Хүүхдийн хэсгийн үйл ажиллагаа эсвэл гэр бүлийн үдшээр заагддаг байсан хичээлүүдийг санадаг байхад би эдгээр зүйлийн алийг нь ч санадаггүй байв.

**“ТА НАР САЙХАН ХҮМҮҮС,
БИ САЙХАН ХҮН.
ГЭВЧ БИД ДЭНДҮҮ
ИХ ЯЛГААТАЙ
БАЙНА.
БИ ЭНДХИЙНХ БИШ”
ГЭЖ БОДДОГ БАЙВ.**

Үүнээс гадна, хүн бүр кино, улс төр, тодорхой судруудыг тайлбарлах зэрэг бүх зүйлийн талаар ижил сонирхол, санаа бодолтой заримдаа бүр минийхээс шал эсрэг санаа бодолтой юм шиг санагддаг байв. Би эргэн тойрныхоо бүх хүн рүү толгой дохин харж, “Та нар сайхан хүмүүс, би сайхан хүн. Гэвч бид дэндүү их ялгаатай байна. Би эндхийнх биш” гэж боддог байлаа.

Би ийм мэдрэмжтэйгээ нэлээд хэдэн жилийн турш тэмцэлдсэн. Тэгээд би Лук 19-р бүлгийн Закхайн талаарх нэгэн түүхийг санаж, дахин уншив. Тэрээр татвар хураагч байсан учир үзэн ядагдаж, нүгэлтэн хэмээн тооцогддог байв. Гэвч Есүс хотыг дайран өнгөрөхөд Закхай цугласан олны дээгүүр нь харахаар модон дээр авиран гарав. Бусад хүн түүний талаар юу гэж бодох бол гэж тэр санаа зовоогүй. Модон дээр авирч өөрийгөө цугласан

олноос салгасан энэ үйлдэл нь Түүнд Аврагчтай маш сайхан, хувийн харилцаа үүсгэх боломжийг олгосон байна. Би уншиж байхдаа би эндхийнх биш гэсэн мэдрэмж нь Христээс ирээгүйг ойлгосон юм. Есүс ойлголтоор дүүрэн бөгөөд өршөөнгүй байв. Өөрсдийгөө шүүгдсэн мөн хаягдсан юм шиг боддог хүмүүсийг Тэр идэвхтэй эрж хайдаг байв.

Би эдгээр зүйлийг дахин мэдрээгүй гэж хэлж чадахгүй. Би мэдэрсээр байсан. Гэсэн ч би намайг өөр болгосон зүйлүүдийг өөрийнхөө хардаг хандлага, намайг хардаг бусад хүний хандлага, миний хүсэн хүлээдэг зүйлүүд, дэлхийн талаар боддог хандлага зэрэг нь унах шалтгаан биш гэдгийг мэдэж авсан юм. Эдгээр нь бид бүгд өөрсдийн авьяас чадвар, хүч чадал болон ойлголттойгоо Сүмд хэрэгтэй байдгийн шалтгаан юм. ■

Элэйн Викэрс АНУ-ын Ютад амьдардаг.



Христийг хотоор дайран өнгөрөх үед Закхай цугласан олны дээрээс нь харахаар модон дээр авиран гарав.

ХАМТДАА ЯРИЛЦ**Тунгаан бодох зүйлс**

- Ямар ямар төрлийн өөрчлөлт зарим хүнийг Сүмд нэгдэхэд хэцүү болгодог вэ?
- Таны нөхөрлөл хэн нэгэнд Сүмдээ эргэн ирэх эсвэл хүчтэй байхад нь хэрхэн тусалж болох вэ?

Таны хийж болох зүйлс

- Хөрвөгчдөд тулгардаг сорилт бэрхшээлүүдийн жагсаалт гарга, тэгээд тэдэнд хэрхэн тусалж болох талаар зорилго тавь.
- Ангийнхаа эсвэл чуулгынхаа үйл ажиллагааг зохион байгуулахдаа шинэ хөрвөгчийг юм уу идэвх султай найзаа өөртөө туслахад урь.
- Сүм дээр, гэр орондоо эсвэл онлайнаар өөрийн туршлагыг хуваалц.

“Би Сүмийн жишгүүдийг дагаснаасаа болж сургууль дээрээ шоолуулах үедээ би юу хийх хэрэгтэй вэ?”

Хэрэв чи Сүмийн жишгүүдийг дагаснаасаа болж шоолуулж байгаа бол үүнийг Есүс Христийг төлөөлөх боломж болгон ашиглах хэрэгтэй. Хүндэтгэлтэй, энэрэнгүй байгтун. Хэрэв Сүнсээр өдөөгдвөл, чи яагаад ийм амьдралаар амьдардгаа тайлбарлаж болно. Жишгүүдийнхээ талаар ярилцахдаа өөрт тань туслах *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг ашиглах талаар бодож үз. Сүнс үе тэнгийнхний чинь зүрх сэтгэлд хүрч болохын тулд Сүнсийг амьдралдаа урь. Сүнс чамд юу хэлэхээ мэдэхэд чинь тусалж чадна.

Мөн чи эцэг эх, Сүмийн удирдагчдаас эсвэл бүрэн цагийн номлогчдоос зөвлөгөө авч болно. Тэднийг төстэй нөхцөл байдалд юу хийдгийг асуугаарай.

Зарим үед чи итгэл үнэмшлийнхээ талаар бусадтай маргалдахаар уруу татагдаж болох юм. Гэвч “зөрчилдөөний Сүнсгүй тэр нь [Христээс] бус гэдгийг санагтун” (3 Нифай 11:29).

Харин бусад үед чи бууж өгч, Сүмийн жишгүүдийг дагахаа болих дарамт шахалтыг мэдэрч болно. Хүчтэй бай. Тууштай зогсох нь таны амьдралыг амар амгалангаар адислаад зогсохгүй бас үе тэнгийнхний тань амьдралыг адисалж болно. Үлгэр жишээ тань зөв шударга шийдвэр гаргахад тэднийг урамшуулан дэмжиж чадна.

Хүч чадалтай байхын тулд Аврагчийн жишээг харагтун. Аврагч үнэний төлөө зогссоноосоо болж шоолуулав (Исаиа 53-ыг үзнэ үү). Чиний мэдэрч буй зүйлсийг Тэр маш сайн мэддэг. Тэрээр *чиний* төлөө Цагаатгал хийсэн бөгөөд чамд тулгарч буй сорилт бэрхшээлүүдтэй адил зүйлийг даван туулсан юм. Тэр чамтай хамт байгаа. Ийм нөхцөл байдлуудад Түүнтэй адил болж болохын тулд Түүний амьдралын талаар илүү ихийг судал.



Төмөр бариулаас зууран барь

Сургууль дээр хүмүүс намайг шоолох үед би агуу хийгээд нүсэр барилгын талаар

Лихайн үзсэн үзэгдлийн тухай боддог: “Мөн энэ нь өтөл болоод залуу, эрэгтэй болоод эмэгтэй хүмүүсээр дүүрэн байв; мөн тэдний хувцасласан маяг нь үлэмж тансаг; мөн тэд, ирж бас жимснээс хүртсэн тэднийг хуруугаараа занган басхүү элэглэх байдалтай байх ажээ” (1 Нифай 8:27). Би Лихайтай адил байх болно. Мөнх амьдрал руу удирддаг энэхүү төмөр бариулаас би хэзээ ч тавихгүй.

Пиэрр С., 18 настай, Гайти

Гэрчлэлээ хуваалц

Чи нэгэнтээ жишгүүдийн дагуу амьдарснаар ирдэг адислалуудыг мэддэг болсон учир шоолуулах үедээ ичих хэрэггүй. Чи жишгүүдийг зааж, тэдгээрийн дагуу амьдарсан гэрчлэлээ хуваалцаж болно. Чи сайн мэдээний гэрчлэлээ хуваалцаж байгаа учир үе тэнгийнхэн чинь суралцаж мөн Сүнсээр дүүргэгдэж болно.

Эммануэл А., 16 настай, Гана



Сайн мэдээг хуваалц

Би нэг найзтайгаа Хувийн хөгжил дэвшил номны эрхэмлэх чанарыг хөгжүүлэх төслөө хийж байхдаа

сургууль дээрээ завсарлагаанаар Мормоны Ном уншдаг байв. Багш, ангийнхан маань биднийг шоолж эхэлдэг байлаа. Надад заримдаа уншихаа болимоор санагддаг үе байсан ч би зүгээр л судруудаа гэртээ орхидоггүй байв. Бид сургууль дээрээ үргэлжлүүлэн уншихад яваандаа биднийг шоолохоо

больсон. Манай найзуудын нэг нь сайн мэдээ болон Хувийн хөгжил дэвшил номыг сонирхож байв. Бид түүнд сайн мэдээний талаар хэлж байсан ч товхимлыг болон гурамсан судрыг өгсөн юм. Түүний ах бас сайн мэдээг сонирхож байгаа бөгөөд тэд хоёулаа Мормоны Номыг уншиж байгаа.

Кимбэрли А., 16 настай, Бразил



Үлгэр жишээ бол
Манай сургуулийн сурагчдын ихэнх нь сайн мэдээний талаар мэддэггүй. Миний бодлоор чиний хийж чадах хамгийн сайн зүйл бол сайн мэдээгээр амьдрах нь чамд хэрхэн эергээр нөлөөлж байгааг хүмүүст харуулах явдал юм. Тэд чамд юу хэлж байгаагаас үл хамааран эелдэг, хүндэтгэлтэй байснаар чи гайхалтай үлгэр жишээг үзүүлдэг бөгөөд тэд чамайг болон чиний итгэлийг агуу ихээр хүндэтгэх болно. Чиний үлгэр дуурайлыг санаснаар энэ хүмүүс хожим нь сайн мэдээний талаар илүү их суралцахдаа нээлттэй байж болно.

Кэли П., 14 настай, АНУ, Флорида



Өөрийгөө хэн билээ гэдгийг сана
Сургуулийн үйл ажиллагаануудад оролцоход ангийнхан эсвэл найзууд маань хүртэл Бурханы хувьд зохисгүй хувцас өмсөхийг надад санал болгодог. Тэд “Чи хөөрхөн харагдах ёстой. Чи өөр харагдах ёстой” гэж хэлдэг. Заримдаа тэд энэ дэлхийд нийцүүлэхийн тулд намайг итгэл бишрэлээ мартах ёстой гэж хэлдэг. Харин миний хариулт үргэлж үгүй байдаг. Өөрөөрөө байх нь үнэнч

байж, дэлхийгээс өөр байх явдал юм гэдгийг би мэднэ. Хэрэв өөрөөрөө байснаас болж тэдэнд таалагдахгүй байгаа бол энэ нь асуудал биш. Энэ нь бусад хүний хэлж байгааг бус; Тэнгэрлэг Эцэгийн замыг дагаж буй хэрэг юм.

Жаззи С., 19 настай, Филиппин



Номлогч бай
Надад сургууль дээрээ сайн мэдээний жишгүүдийн дагуу амьдарсантай холбоотой олон туршлага байдаг. Энэ бол бидэнд зориулсан гэрчлэлээ хүчирхэгжүүлэх, номлолын ажилд оролцох гайхалтай мөч гэдгийг би мэдэж авсан юм. Би өөрийгөө үүнтэй адил нөхцөл байдалд байгаагаа мэдэж, жишгүүдээ өндөрт сахих бүрдээ Бурханы надаар хийлгэхийг хүссэн тэр зүйлийг хийсэндээ өөртөө сэтгэл хангалуун байдаг. Хэн болох, юунд итгэдэг талаараа эргэлзэх шалтгааныг хэнд ч олгодоггүй.

Хирам Д., 18 настай, Бразил



ГЭРЧЛЭЛЭЭ ТЭЖЭЭН ТЭТГЭ

“Үнэн болон зөв шударгын төлөө тууштай зогсох

зоригтой байцгаая. Өнөөгийн нийгмийн чиг хандлага нь Их Эзэний бидэнд өгсөн эрхэмлэх зүйлс болон зарчмуудаас холдсон учир та нар итгэдэг зүйлсээ хамгаалахаар дуудагдах нь бараг тодорхой билээ. Та нарын гэрчлэлийн үндэс бат бөх суулгагдахгүй аваас таны итгэлийг сорих тэдгээрийн тохуурхлыг сөрөн зогсох нь танд хэцүү байх болно. ... Та нарын гэрчлэл байнга тэжээгдэн тэтгэгдэж байгаа үед л та нарыг аюулгүй байлгах болно.”

Томас С. Монсон, “Зоригтой бай,” Лиахона, 2009 оны 5-р сар, 99.

ДАРААГИЙН АСУУЛТ

Би Миа Мэйд ангийн ерөнхийлөгч болоход өөрийгөө хангалтгүй байна гэж санагддаг. Би хэрхэн илүү сайн удирдагч болж чадах вэ?

Та хариултаа, хэрвээ хүсвэл өндөр нягтралтай зургаа 2015 оны 1-р сарын 15-ны дотор liahona.lds.org хаягаар (“Submit Your Work” гэсэн товчийг дарж), цахим шуудангаар бол liahona@ldschurch.org хаягаар, шуудангаар бол (3-р хуудсан дээрх хаягийг үзнэ үү) хаягаар ирүүлнэ үү.

Э-мэйл эсвэл захидалдаа дараах мэдээлэл, зөвшөөрлийг хавсаргана уу: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр хийсэн өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

ЯМАР Ч ТЭНГЭР ЭЛЧ ХЭРЭГГҮЙ БАЙВ

Христийн мэндэлсний баярын тэр өглөө Гватемалын нэгэн эмнэлэгт бид дуулахын тулд тэнгэр элчүүдийг дуудаж чадаагүй. Харин бид өөрсдийгөө дуудаж чадсан.

Жэнианн Жэнсэн Нийлсэн

Салют болон цацардаг хуар пуужин, Христийн төрөлтийн эргэн тойрны үйл явдлуудын дүрслэл болон чихмэл тамайлтай баярын ширээ зэрэг нь Гватемал дахь Христийн мэндэлсний баяр байв. Бүрэн цагийн номлогчийн хувьд би Нэгдсэн Улс дахь манай уламжлалуудаас шал өөр уламжлалуудыг олж харсан юм. Би гэрээ санаж байсан бөгөөд Христийн мэндэлсний баяр уйтгартай болох байх гэж бодож байлаа.

Манай хамтрагч Анаяа, бид бусдад үйлчилснээр Христийн мэндэлсний баяраар баяр баясгаланг олох болно гэж хэлэв. Тэр өглөөг эмнэлэг дээр очиж, дуулж өнгөрөөхийг тэрээр бидэнд санал болгоод, дараа нь бусад номлогчийг бидэнтэй нэгдэхэд урив.

Бид орох хаалган дээр дөхөж очоод, хайртай хүмүүсээ харахаар нэг эгнээнд зогсон, хүлээж буй тэр хүмүүсийг олж харав. Тэдний нүүр нь гунигтай, утлааштай хөл нь тоостой, хувцас нь гандсан байлаа. Бид тэдэнтэй хамт хүлээв. Сүүлд биднийг байшин руу орохыг зөвшөөрөхөд бид ховхорсон ногоон будагтай, цементэн шалтай нарийн өрөөгөөр алхсан. Эм тариа болон өвчний үнэр намайг цочроов.

Агааржуулалт болон тусгаарлалт муутай нэгэн том өрөөнд орнууд дээр буй өвчтөнүүдийг би бүдэгхэн гэрэлд олж харав. Тэнд зарим нь боолттой, зарим нь дусал залгуулсан, зарим нь амьсгалын аппараттай хэвтэж байлаа. Зарим нь чимээгүй ёолж байв. Бусад нь унтаж байлаа. Бид яагаад энд ирсэн нь надад сонин санагдав. Бидний хэсэг номлогчид ихэнх нь юу хийхээ мэдэхгүй хаалган дээр зогсож байлаа.

Гэвч систер Анаяа тэгсэнгүй. Тэр өвчтэй байсан хүмүүстэй мэндлэн, тэдний бие ямар байгааг асуун, Христийн мэндэлсний баярын мэнд хүргэж, ор болгон дээр очиж байв. Түүний зориг бидэнд яагаад ирснийг маань сануулсан бөгөөд бид Христийн мэндэлсний баярын дуулуудыг дуулахдаа зөөлхөн эхэлсэн ч яваандаа илүү итгэлтэй дуулж байв. Зарим өвчтөн инээж, зарим нь тэндээ зүтээр л анзаараагүй юм шиг хэвтэж, харин зарим нь амандаа аялж байв.

Гартаа дууллын ном бариад дуулж байсан систер Анаяа боолттой байсан нэгэн эмэгтэй рүү дөхөж очив. Эмэгтэй чимээгүйхэн уйлж эхэлсэн ба хамтрагч маань түүний үсийг зөөлхөн илж байв. Нүдэндээ нулимстайгаар тэрээр “Та нар тэнгэр элчүүд,” “Та нар тэнгэр элчүүд” хэмээн хэлж байлаа.

Би систер Анаяагийн хариултыг хэзээ ч мартахгүй. “Үгүй ээ, та тэнгэр элчүүдийг сонсоогүй, та хожмын үеийн гэгээнтнүүдийг сонсож байна” гэж тэр хариулсан юм.

Есүс Христийг мэндлэх үед, тэнгэр элч Түүний төрөлтийг зарлаж, олон тооны тэнгэрлэг дайчид үзэгдэн, Бурханыг магтаж байв (Лук 2:8–14). Би Христийн мэндэлсний баяраар эдгээр тэнгэр элчийн талаар боддог.

Би бас систер Анаяагийн талаар боддог. Биднийг эмнэлэг дээр дуулахад тэр биднийг урамшуулан дэмжиж байсныг, мөн баяр хөөрийг түгээснээр бид хэрхэн баяр баясгалантай болж байсныг би санадаг юм. Би түүний өвчтэй эмэгтэйн үсийг илж байсныг бас санадаг. Мөн бусдад үйлчлэхийн тулд тэнгэр элч байх шаардлагагүй байсныг би санаж байна. Би тэдэнд хожмын үеийн гэгээнтний хувьд үйлчилж чадна. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.





ӨРӨӨ ГАРГА

“Бидний хүн нэг бүр нь Есүст зориулан өрөө гаргах эсэхээ шийддэг дэн буудлын эзэн юм!”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл А.Максвэлл (1926–2004)

“Settle This in Your Hearts,” *Ensign*, 1992 оны 11-р сар, 66.



Ахлагч
Мэрвин Б.рнолд
Далын

“Би хаана байна вэ?”

Сүнслэг бэлэг, авьяас чадваруудаа хэрхэн нээн илрүүлж, хөгжүүлэх вэ?

Тэнгэрлэг Эцэг таныг болоосой гэж хүсэж байгаа тийм хүн болоход тань туслахын тулд танд сүнслэг бэлэг болон авьяасуудыг өгсөн.

Биднийг амьдралынхаа талаар бодоход хүргэдэг олон асуултыг бид судруудаас олдог билээ. Библи дээр асуудаг хамгийн анхны асуултуудын нэг нь Адамыг хориглогдсон жимсийг хүртсэний дараа түүнд хандсан байдаг. Би та бүхнийг энэ асуултыг өөрсдийн амьдралд хэрхэн хэрэгжүүлж болох талаар тунгаан бодоход урьж байна:

“Адам эхнэртэйгээ хоёул Эзэн Бурханы оршихуйгаас цэцэрлэгийн модон дотор нуугджээ.

“Мөн Эзэн Бурхан, Адамыг дуудаж, мөн түүнд хэлэв: *Чи хаана байна вэ?*” (Эхлэл 3:8–9; тодотгол нэмэгдсэн).

Их Эзэн бүгдийг мэддэг, тэгвэл Адам, Ева хоёрын хаана нуугдаж байсныг Тэр мэдэж байсан нь бидэнд тодорхой байна. Хэрэв Тэр тэдний хаана нуугдаж байсныг мэдэж байсан юм бол Их Эзэн үнэхээр юу асуусан бэ?

Адам, Ева хоёрыг амьдралд нь юу болж байгаа талаар бодоход энэ асуулт хамгийн их нөлөөлсөн юм. Бид өөрсдөөсөө үүнтэй төстэй асуултуудыг асууж болно. Жишээ нь: Бид мөнх амьдралд хүргэх гэрээт замынхаа аль хэсэгт байна вэ? Энэ замаар явахад маань туслахын тулд Тэнгэрлэг Эцэг мөнх бус амьдралын турш бидэнд ямар бэлэг болон авьяасуудыг өгсөн бэ? Биднийг болоосой гэж хүсэн хүлээж байгаа тийм хүмүүс болохоор хичээх үед бид өөр ямар бэлэг болон авьяасуудыг олж авах хэрэгтэй байна вэ?

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918) “Хүмүүн нь дэлхий дээр мөнх бус [бие] махбодтой ирэхээсээ өмнө сүнслэг байдлын хувьд тэнгэрлэг эцэг эхээс төрж, Эцэгийн мөнхийн харшид төлөвшин өсөж хүмүүжсэн”¹ *хэмээн мэдэгдэл хийжээ. Сайн мэдээний зарчмууд* гарын авлага нь бидэнд “Тэнгэр дэх Эцэг биднийг хэн гэдгийг мөн энд ирэхээсээ өмнө юу хийдэг байсныг мэддэг. Тэр хүн бүрийн төрөх цаг, газрыг нь сонгосон байдаг. Тиймээс хүн өөрсдийн сурах ёстой сургамжуудаас суралцаж, *авьяас, хувийн зан чанараа ашиглан хамгийн сайныг хийх ёстой*” гэж заадаг билээ.²


Тэнгэрлэг Эцэг таны сүнслэг бэлгүүдийг ашиглаж, авьяасуудыг тань

хөгжүүлэхээр хамгийн сайн газарт илгээсэн. Таны хаана амьдардаг эсвэл амьдралын нөхцөл байдлаас тань үл хамааран сорилт бэрхшээлүүдтэй байсан ч та амжилттай байх сонголт хийж чадна. Хэзээ ч бүү бууж өг. Үргэлж хичээн чармай. Бүү шантар. Та өөрт байгаа зүйлүүдээ ашиглан ямар болохыг хүсэж байгаа тийм болж чадна гэдгийг сана.

Адам, Ева хоёрын үлгэр жишээ бидэнд их итгэл найдвар өгч чадна. Хориглогдсон жимснээс идэж болохгүй гэсэн зарлигийг зөрчсөнийхөө дараа тэд үзэсгэлэнт цэцэрлэгээс хөөгдөж, мөн газар хараагдан, өргөст халгай бий болсон бөгөөд тэд талхаа олж идэхийн тулд ажиллаж, газар боловсруулах ёстой байлаа. Тэд бууж өгөөгүй. Их Эзэнийг тэдэнд зарлиглах үед тэд ажиллахаар явсан юм (Мосе 5:1-ийг үзнэ үү). Тэдний хүү Каин маш муу сонголт хийсэн ч тэд үргэлжлүүлэн зөв шударга амьдарч, хүүхдүүддээ заасан хэвээрээ байлаа.

Авга ах Бэнийн нээлт

Авга ах маань Тэнгэрлэг Эцэгээс хүлээн авсан бэлэг, авьяасуудаа хөгжүүлж, өсгөхөөр үргэлж хичээдэг байсан юм. Сүнслэг бэлэг, авьяас хэрхэн хөгжиж, өсөж томорч



ТАНД ЯМАР ЯМАР БЭЛЭГ БАЙГАА ВЭ?

Ямар ямар бэлэгтэйгээ тодорхойлох арга замууд:

- Тэдгээр нь юу болохыг Тэнгэрлэг Эцэгээс асуу, мөн өөр бэлгүүдээр адислахыг Түүнээс гуй.
- Өөрийг тань сайн мэддэг хүмүүсээс асуу. Заримдаа бусад хүн танд байгаа бэлгийг танаас илүү харж чаддаг.
- Авьяас болон сүнслэг бэлгүүдийг нээж олохын тулд шинэ үйл ажиллагаануудад оролцох юм уу шинэ чадваруудаас суралц.
- Хэрэв та патриархын адислалаа авсан бол тодорхой хэсгүүдэд дурдсан бэлгүүдийг эсвэл чадавх чадамжаа олж мэдэхийн тулд патриархын адислалаа судлаарай.

болдгийг харахад надад тусалсан түүний амьдралын нэгэн түүхээс би хуваалцъя.

Нэгэн өдөр авга ах Бэн зэсийн уурхай дахь ажил дээрээ байхдаа төмөр замын хажууд хэвтэж байсан нугалсан төмрийн хуучин хэсгийг ажиглажээ. Тэр даргаасаа үүнийг авч болох эсэхийг асуув. Дарга нь “Бэн, төмрийн хуучин хэсэг ямар ч хэрэггүй. Чи авах гэж цагаа гарзана” гэжээ.

Авга ах Бэн инээмсэглээд, “хуучин төмөр үнэхээр их байгааг би ойлгож байна аа” гэжээ.

Даргынхаа зөвшөөрлөөр тэрээр төмрийг гэртээ авчирчээ. Тэр төмрийг цехдээ авчран, улайстал халаав. Дараа нь тэрээр маш их хөдөлмөр гарган байж үүнийгээ шулуун хэв загварт оруулж, нугалах боломжтой болгов.

Тэр үүнийгээ хөргөөд, дээр нь том хутганы хэв зуржээ. Халуун гагнуураар төмрийг хутган хэлбэртэй болгож зүссэний дараа авга ах Бэн арзгар ирмэгийг нь давтаж, төмрийн хуучин хэсгийг зүсэж, нүдэн, өнгөлж, боловсронгуй болгохоор олон цагаар ажиллаж эхэлдэг байв.

Ямар ч ашиггүй төмрийн хэсэг гэж даргынхаа хэлсэн тэр зүйл дээр тэрээр өдрөөс өдөрт

ажилласаар байв. Яваандаа ир нь хурцлагдан, үзэмжтэй сайхан болж, урлагийн гайхамшигт бүтээл болон гялалзсан юм.

Одоо ганцхан бариул л дутуу байлаа. Авга ах Бэн ойд очиж, бугын эвэр олжээ. Тэрээр цехдээ буцаж очоод, эврээ цэвэрлэж, зүсэж, өнгөлөөд дуусахад энэ нь жигд, үзэмжтэй болов. Тэр бариулаа хутгандаа маш болгоомжтой бэхэлжээ. Нэгэн үе хуучин, зэвтэй, нугаларсан байсан төмрийн хэсэг ийнхүү үзэмжтэй сайхан хутга болж, хэд хэдэн шагнал хүртсэн юм.



ЭДГЭЭР БЭЛГЭЭС АЛЬ НЭГ НЬ ТАНД БАЙГАА ЮУ?

“Үргэлж ил тод, анхаарал татахуйц байдаггүй ч маш чухал хэдэн бэлгийг би нэрлэе. Эдгээр бэлэгт ил тод биш ч жинхэнэ бөгөөд үнэ

цэнэ бүхий танд байдаг бэлгүүд байж болно.

“Төдийлөн ил харагддаггүй зарим бэлэг болох асуух; сонсох; намуун, зөөлхөн дуу хоолойг анхааран сонсож, ашиглах; уйлах чадвартай байх; зөрчил сөргөлдөөнөөс зайлсхийх; бусадтай эв нийцтэй байх; хоосон давталтаас зайлсхийх; зөв шударга зүйлсийг эрэлхийлэх; бусдыг шүүхгүй байх; Бурханаас удирдамж хүсэх; шавь байх; бусдад анхаарал халамж тавих; тунгаан бодох чадвартай байх; залбирал хэлэх; хүчирхэг гэрчлэл үлдээх; Ариун Сүнснийг хүлээн авах зэрэг бэлгүүдийн талаар ярилцъя.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Марвин Ж.Аштон (1915-94), “There Are Many Gifts,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 20.

Та бид тэр төмрийн хуучин хэсэгтэй адилхан. Өөрсдийнхөө бүрэн чадавхад хүрэхэд бидэнд загвар, боловсруулалт болон өнгөлгөө хэрэгтэй. Энэхүү үйл явцын нэг хэсэг нь нээж олох, хүчирхэгжүүлэх мөн авьяас, бэлэгнүүдээ өсгөн нэмэгдүүлэх явдал билээ.

Авга ах Бэн бидний чадавхын ихэнх хэсэг нь ил харагдах боломжгүй байдаг бөгөөд үүнийг нээж олж, хөгжүүлэх ёстойг ойлгодог байв. Их Эзэн “хүн болгон авьяас билгээ сайжруулж болохын тулд хүн бүр өөр авьяасыг, тийм ээ бүр зуу дахин ихийг олж авч болохын тулд” (С ба Г 82:18) “хамгийн шилдэг бэлэгнүүдийг хичээнгүйлэн эрэлхийл” (С ба Г 46:8) хэмээн бидэнд заадаг. Бид яагаад үүнийг хийх ёстой вэ? Дараах шүлэгт тайлбарласнаар, бид өөрсдийн авьяас, бэлгүүдийг бусдад



үйлчлэхдээ ашиглаж болно. “Хүн болгон хөршийнхөө анхаарал тусламжийг эрэлхийлж мөн бүх зүйлийг Бурханы алдар суутгийн төлөө бүхнээ зориулан хийх ёстой” (С ба Г 82:19). Үйлчлэл хийх нь биднийг Христтэй илүү адил амьдрах загварт оруулдаг.

Авьяасаа олох нь

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт сорилтууд нь биднийг сайжруулдаг талаар: “Бүх зүйл зөв санагдах үед сорилтууд заримдаа нэгэн зэрэг маш ихээр ирдэг. Тэрхүү сорилтууд таны дуулгаваргүй байдлын үр дагавар биш л бол Их Эзэн таныг улам их өсөж хөгжихөд бэлтгэж байгаагийн нотолгоо мөн (Сургаалт Үгс 3:11–12-ыг үзнэ үү). Тиймээс Тэрээр таныг өсөж хөгжихөд нөлөөлдөг туршлагуудыг, *мөнхийн ач ивээлийг авахад таныг өнгөлдөг ойлголт болон энэрэл* [маш чухал хоёр бэлэг]-ийг танд өгдөг юм. Тэрбээр таныг байгаа түвшингээс чинь Өөрийнхөө хүсдэг түвшинд хүртэл өсгөн хатуужуулахын тулд шаардлагатай бүхнийг хийдэг эсвээс сэтгэл санааны зовлон, эмзэглэлийг чинь арилгадаг” гэж заасан.³

Авьяасаа хөгжүүлэх нь

Авьяасаа хөгжүүлэхэд хөдөлмөр шаарддаг. Хэдхэн жилийн өмнө ахлагч Скотт эхнэрт маань хандан “Дэвонна, чи зураг зурах хэрэгтэй” гэж билээ.

Арнолд эгч амьдралдаа хэзээ ч зураг зурж үзээгүй байв. Тэр үүн дээр ажиллах шаардлагатай байлаа. Тэр хэд хэдэн хичээл авч, өдөр бүр зураг зурж байсан ба маш их цаг, хичээл зүтгэл гаргасны эцэст маш сайн зурж сурсан юм. Түүний голын дүр төрхийг гаргасан гоёмсог

зургуудын нэг нь миний ажлын өрөөний хананд өлгөөтэй байдаг.

Тийм ээ, авьяас олж авах нь хөдөлмөр шаарддаг ч “Сайн байна. Та хичээнгүй байсан учир таны бэлэг болон авьяас олон дахин үржих болно” (Матай 25:14–30) хэмээн Их Эзэний бидэнд хэлэхийг сонсох үед бидний баяр баясгалан хэчнээн их байх бол оо?

Таны сүнслэг бэлгүүд

Эхнэр маань зураг зурах авьяасаа нээж илрүүлсэн. Та ямар авьяас, бэлгүүдтэй вэ? Тэнгэрлэг Эцэг маань танд бас зарим авьяас, чадварыг өгсөн гэдгийг би мэднэ. Би тэдгээрийг хэрхэн мэдэх вэ? “Олон бэлэг байдаг, мөн хүн болгонд Бурханы Сүнсээр бэлэг өгөгддөг болой” (С ба Г 46:11). Бурханы бэлэг, хүч чадал нь бид бүхэнд боломжтой юм. Сүнслэг бэлгүүдийг хүлээн авч, авьяасуудаа өсгөн нэмэгдүүлж, тэдгээрийг хуваалцах нь бидний эрх бөгөөд үүрэг хариуцлага юм.

Судрууд дээр бидний эрэлхийлж болох цөөн бэлэг байдаг (жишээ нь, С ба Г 46), гэвч үнэн хэрэгтээ олон зуун бэлэг, авьяас байдаг. Мормоны Номыг, ялангуяа 3 Нифай 11–26-г судал. Мөн та бидний хүн нэг бүрд боломжтой олон бэлэг, авьяасыг нээж олох болно. Жишээ нь 3 Нифай 11 дээр бид Тэнгэрлэг Эцэгийн дуу хоолойг сонссон боловч эхэндээ ойлгохгүй байсан хүмүүсийн талаар:

“Мөн гурав дахь удаагаа тэд уг дуу хоолойг дахин сонсож, мөн үүнийг сонсохоор сонороо дэлгэв; мөн тэдний харц дуу гарсан зүгт чиглэв. . . .

“Мөнхүү улиран тохиох дор, тэд ойлгоод тэнгэрийн зүг хараа чиглүүлэв; мөн болгоогтун, тэд тэнгэрээс бууж ирж буй Хүнийг [Есүс

Христийг] үзэв” гэж уншдаг (5, 8-р шүлгүүд).

Тодорхой сонсож, тодорхой харах нь хэрэв та тэдгээрийг *эрэлхийлж мөн ажиллах* хүсэлтэй байх юм бол таны олж авч, өсгөн нэмэгдүүлж болох сүнслэг авьяас, бэлгүүдийн зөвхөн хоёр жишээ юм.

Би та нарын хүн нэг бүрийг авга ах Бэний хийсэн шиг зүйлийг хийхэд буюу сүнслэг авьяас, бэлгүүдийг эрэлхийлж, эргэн тойрондоо байгаа хүмүүсийг адислахын тулд тэдгээрийг ашиглахдаа бүх зүйлийн хамгийн сайныг нь олж харахад урьж байна. Тэнгэрлэг Эцэгт бидэнд өгөхийг хүсдэг маш олон авьяас, бэлгүүд байгааг би мэднэ. Гэвч тэдгээр нь гуйсан үед л бидэнд өгөгдөх болно. Адислалууд нь өөрт оногдсоноо хийж, хөдөлмөрлөж, хичээл зүтгэл гаргасан үед л ирдэг (Судруудын удирдамж “Залбирал”). Бид Бурханы өгсөн бэлгүүдийг болон төрөлхийн авьяас чадваруудаа олж нээн, үүний төлөө ажиллаж, өсгөн нэмэгдүүлж, мөн өөр бэлгүүдийг олж авах болтугай гэж би даруухнаар залбирч байна. ■

Эшлэлүүд

1. *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 335.
2. *Сайн мэдээний зарчмууд* (2009), 10; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
3. Ричард Г.Скотт, “Trust in the Lord,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 16–17; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.



**Ахлагч
Даллин Х.Өүкс**

Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

ХОЁР ДАХЬ ИРЭЛТЭД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ

“Энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар бэлтгэх үе” (Алма 34:32). Бид бэлтгэж байна уу?

Түүний ирэлтийн өдөр маргааш байвал яах вэ? Хэрэв бид маргааш зуурдын үхлээр эсвэл Түүний гэнэтийн ирэлтээр Их Эзэнтэй уулзана гэдгээ мэдэж байгаа бол бид өнөөдөр юу хийх байсан бэ? Бид юуны төлөө наманчлах байсан бэ? Бид ямар зуршлуудаа хаях байсан бэ? Бид мөн ямар асуудлуудаа шийдэх байсан бэ? Бид хэр зэрэг өршөөл үзүүлэх байсан бол? Бид ямар гэрчлэл хуваалцах байсан бэ?

“Хэрэв бид эдгээр зүйлийг хийх л байсан юм бол яагаад одоо хийж болохгүй гэж? Амар амгаланг олох боломжтой үедээ яагаад үүнийг эрэлхийлж болохгүй гэж?

Идээ батга мэт дэлгэрэхийг нь

хязгаарлаж, нуун далдалдаг байсан хилэнцэт зүйлүүд одоо хуульчлагдан, сурталчилгаа шиг нийтэд дэлгэгддэг болжээ. Соёл иргэншлийн үндэс суурь болон хамгаалаалууд (хамгаалаалтын хананууд) нь эргэлзээнд эсвэл дайралтад өртөж байна. Үндэстэн ястнууд шашны өвөө үгүйсгэж байна. Гэрлэлт болон гэр бүлийн үүрэг хариуцлагыг хувийн сэтгэл ханамждаа саад болж буй мэт үзэн, орхигдуулж байна. Бидний хандлагыг төлөвшүүлдэг кино, сэтгүүл, телевиз нь Бурханы хүүхдүүдийг махчин амьтан, эсвэл хамгийн сайндаа өөрсдийнхөө зугаацаж болох зугаа цэнгэлээс тун бага хэсгийг нь эрэлхийлдэг өчүүхэн бүтээлүүд хэмээн үзүүлдэг түүх эсвэл дүр зургаар дүүрэн болжээ. Харин биднээс дэндүү олон нь үүнийг үзвэр үйлчилгээ мэтээр хүлээн авч байна.

Сайн сайхан, үнэнч шударга, үзэсгэлэнтэй сайхан байдлыг сайн биш, “ямар ч хамаагүй” болон хувийн, үнэ цэнэгүй, адайр зан орлож байна.

Порнограф, биеийн хэсгээ цоолох, хувийн жаргалаа хөөж өөртөө үйлчлэх, шударга бус зан үйл, ил гарсан хувцас, бохир үг хэллэг болон бэлгийн харьцааны доройтол зэрэгт олон хүн боолчлогдож байгаад гайхах зүйлгүй юм.

Энэ бүхэн нь бүх хүүхдэдээ хайртай бөгөөд Өөрийнхөө өмнө эргэн ирэхэд саад болох юуг ч болов хориглодог Тэнгэрлэг Эцэгийн нүдэнд жигшүүртэй байдаг.

Мөнх амьдралд бэлтгэх бидний хувийн бэлтгэл нь юу вэ? Бурханы хүмүүс бол баптисмын усанд орох, ариун санваар хүлээн авах зэрэгт болон Бурханы ариун сүм дотор хийсэн ариун нандин амлалтууд бүхий гэрээт хүмүүс билээ. Бид амласандаа хүрдэггүй амлагчид,

үйлдэл хийдэггүй итгэгчид гэж үү?

“Ариун газруудад зогсогтун та нар, мөн Их Эзэний өдөр ирэх хүртэл бүү шилжин нүүлгэгд; учрыг болгоогтун, энэ нь гэнэт ирэх болой” (С ба Г 107:8) хэмээх Их Эзэний зарлигийг бид дагаж байна уу?

Биднийг бүх талын сорилтууд хүрээлж байдаг (2 Коринт 4:8–9-ийг үзнэ үү). Гэвч Бурханд итгэлтэй байж, Түүний зарлигуудыг дагадаг хүмүүст амласан адислалуудад бид итгэдэг. Бид ирээдүйдээ итгэж, тэрхүү ирээдүйдээ бэлдэж байна.

“Иймийн тул, та нар Хүргэн Хүүгийн ирэлтэнд бэлэн байж болохын тулд, ямагт залбиран, дэнлүүтээ бэлтгэж мөн асаан бас тосоо авч яван итгэлтэй байгтун.

“Учрыг болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, бибээр гэнэт ирнэ” (С ба Г 33:17–18). ■

2004 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс эш татав.



ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРААР ӨГӨХ МИНИЙ БЭЛЭГ

Энэ жил би Аврагчид юу өгөх вэ?

Дастин Воорд

9 дүгээр ангийн семинарын үеэр миний ихэнх цагаа өнгөрөөдөг байсан газар бол найз нартайгаа дэмий ярин, зугаацаж болох арын эгнээ байлаа. Энэ семинарын ангийг сонгосон шалтгаан нь хуваарь дээр минь хоосон зай байсан учраас тэр юм. Амьдарч байсан газарт маань семинар хичээлийн үеэр явагддаг байсан бөгөөд намайг хожмын үеийн гэгээнтэн учраас сургуулийн зөвлөх энэ ангийг санал болгоод байсан юм. Би багшийнхаа нэрийг мэддэг байсан ч тэр анги дээр юу сурсан минь илүү чухал байлаа.

Нэг удаа найз минь хаашаа явсан нь мэдэгдэхгүй алга болоход би хэнтэй ч зугаацаж чадахгүй болов. Цагийг яаж өнгөрөөнө өө? Би юу хийхээ мэдэхгүй тулгамдахад, надад нөгөө нэг ганц сонсох л боломж үлдсэн байв. Ингэж би анх удаа багшийнхаа зааж буй зүйлд анхаарлаа хандууллаа.

Эргээд бодоход, тэр өдөр түүний хэлснээс нэг ч үг тогтоогоогүй ч, ямар нэгэн зүйл намайг соронзон мэт татаж байсныг л би тодхон санаж байна. Маргааш найз маань эргэж ирсэн ч би түүнтэй зугаацхын оронд хичээлээ сонссоор л, ямар нэг зүйл намайг чангаасаар л байв.

Яваандаа би ангийнхаа арын эгнээнээс илүү анхаарал тавьж болох урд эгнээнд шилжин суулаа. Миний онцгой анхаарлыг татаагүй нэг ч хичээл эсвэл анхаарлыг минь татахааргүй гэрчлэлээ хуваалцсан нэг ч суралцагч байгаагүй юм.

Семинар надад үнэхээр сайхан санагдсан бөгөөд дараа жил нь би суралцахаар бүртгүүлсэн билээ. Би наймтайдаа баптисм хүртсэн ч үнэндээ сүмд явдаггүй байсан. Гэтэл 12-р сарын тэр нэгэн өдөр Христийн мэндэлсний баярын өмнөхөн энэ байдал өөрчлөгдөж билээ.

Би ч дотроо “Хэн ч үүнийг хийхгүй дээ” гэж бодож байтал суралцагчид бүгд л нэг нэгээрээ ангийн өмнө гарч ирэв. Тэдний зарим нь нулимс дуслуулж байхад, зарим

нь өмнөө тавьсан зорилгынхоо талаар хуваалцан, бусад нь түүх ярьж байлаа. Би энэ бүх зүйлд итгэж ч чадахгүй байв.

Цаг чаг чаг дуугарч байв. Би л ганцаараа үлдсэн байлаа. Нэг мэдэхэд би суудлаасаа боссон байв. Юу хэлэх гэж байгаагаа огт мэдэхгүй байсан ч “Би энэ жил Христийн төрсөн өдрөөр сүмдээ явж эхлэх гэж байгаа” гэж би чичирхийлсэн хоолойгоор хэлсэн юм.

Тэр өдрөөс хойш Аврагчид өгөх бэлэг болгож би сүмдээ явж эхэлсэн билээ. Чухамдаа бэлэг хүлээн авсан хүн нь би шүү дээ. Сүмдээ явдаг болсон нь миний амьдралыг өөрчилсөн бөгөөд энэ бүх зүйл дэмий ярихаа болин, сонсдог болсноор мөн миний зүрх сэтгэлд хүрэх боломжийг Сүнсэнд олгосноор эхэлсэн юм.

Сүнс одоо ч гэсэн надтай ярьсаар л байна. Миний хийх зүйл гэвэл ердөө л сонсох тэгээд дагах явдал юм. ■

*Зохиогч нь АНУ-ын
Ютад амьдардаг.*



У Р А Г Ш

Т Э М Ү Ү Л Э Х Э Д Б Э Л Э Н




НОДОКА Т.



ЖОШ В.



ГРЭЙС С.



БРАЙН Р.



АЙОЛА БА ИВАЛИН В.



ЖОН С.



Хүүхдийн хэсгээс Залуу эрэгтэйчүүдийн эсвэл Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт дэвшиж байна уу? Энэ шилжилтийг хийж байгаа 12 настай долоон хүүхдийн санал бодлыг сонсоцгооё.

Ричард М.Ромни, Сүмийн сэтгүүлүүд мөн Микий Шимомияа, Япон, Токио

Та нар бараг 12 нас хүрлээ. Амьдрал өөрчлөлтөөр дүүрэн байдаг. Сүм дээр та нар Хүүхдийн хэсгээс Залуу эрэгтэйчүүдийн эсвэл Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт дэвшиж байна. Энэ нь чи зорилгууд тавьж, үйлчлэл хийн, ариун сүмд ороход бэлтгэж, сайн мэдээний талаар илүү их суралцана гэсэн үг. Сандрах хэрэггүй! Тэр замыг туулж буй хүмүүс энэ нь үнэхээр гайхамшигтай гэж хэлдэг.

Хоёул хамтдаа

Францын Айола В. бол 12 настай бийхайв юм. Түүний эгч Ивалин сарын дараа 13 хүрэх гэж байгаа. “Эгч минь намайг Хүүхдийн хэсгээс Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт дэвшихэд туслахаар энд байгаад би их баяртай байна” гэж Айола хэлэв.

Хувийн хөгжил дэвшил хөтөлбөр бол тэдний хийх дуртай зүйлсийн нэг бөгөөд тэд нэг зорилгын талаар уншаад, инээлдэцгээв. Энэ нь “хөгжим тоглож сурах” гэсэн зорилго байжээ.

“Бид олон жил хөгжим тоглож байна” гэж Эвалин хэллээ. Тэд ээжтэй нь энэ тухай ярилцахад ээж нь тэдэнд хөгжмийг өөр нэг зорилго болох үйлчлэл хийхэд ашиглаж болохыг мэдэж авахад нь тусалжээ.

Айола, Ивалин хоёр одоо ариун ёслолын цуглаан, авьяас үдэш, хүүхэд, хөгшдөд зориулсан концерт зэрэгт болон номлогчдыг дуулах үеэр хамтрах гэх мэтээр хөгжмийн үзүүлбэр үзүүлэхээр бэлдэж байна.

“Хувийн хөгжил дэвшил үнэхээр сайхан зүйл” гэж Эвалин хэлээд, “Энэ нь чамд дуртай зүйлээ болон шинэ зүйл хийх боломжийг ч бас олгодог” гэжээ.



Асуултууд асуух

АНУ-ын Аризона мужийн 12 настай Брайн Р. анх удаа ариун ёслол түгээхээр бэлтгэж байна. Тэрээр алдаа гаргахыг хүсэхгүй байгаа учраас тойргийнхоо Аароны санваартан нэгнээс зарим зүйлийг тайлбарлаж өгөхийг хүсжээ.

“Тэд үнэхээр гайхалтай байсан.” “Тэд надад хаана зогсож, хаашаа явах; талх, усны тавиурыг хэрхэн дамжуулахыг хэлж өгсөн” гэж тэр хэлэв.

Бас тэд бүр ч илүү чухал зүйлийг хэлсэн нь бишрэл хүндэтгэлтэй байх явдал байлаа. “Бид ариун ёслолыг түгээж байхдаа Аврагчийг дурсан санаж байх хэрэгтэй. Хэрэв бид бишрэл хүндэтгэлтэй байвал бусдад Түүнийг дурсан санахад нь бас тусалдаг” гэж Брайн хэлэв.

Брайн хүлээсэн үүргээ ойлгож, биелүүлэхэд нь бусдад туслахдаа тэднийг аз жаргалтай байгааг мэдэж авчээ. “Зүгээр л асуу”. “Хүүхдийн хэсгээс Залуу эрэгтэйчүүдийн бүлэгт шилжихэд бодсоноос чинь ч илүү амархан” гэж тэр хэлэв.



Шинэ найзуудтай бол

“Зөвлөх маань надаас гадасны Залуу эмэгтэйчүүдийн зугаалганд анх удаагаа явахыг хүсэхэд нь би маш их сандарсан.” “Би залбирахаар шийдэв. Залбирсныхаа дараа би амар тайван мэдрэмжийг мэдэрсэн учраас явахаар шийдсэн.

“Эхний өдрөөс эхлээд л би шинэ найзуудтай болж эхэлсэн юм. Залуу эмэгтэйчүүд үнэхээр эелдэг, сайхан байсан ба миний айдас ч удалгүй алга болсон. Би ус цэвэршүүлэх, уяа зангидах, боолт хийж, хиймэл амьсгаа хийх, хүнсний ургамлуудыг ялгах зэргийг сурсан” гэж Японы Окинавагийн Нодока Т. хэллээ.

Дотно байдлыг мэдэр

“Намайг анх Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт орох өдөр миний төрсөн өдөр байлаа”. “Тэд энэ талаар шуугисхийгээд л өнгөрөв. Гэхдээ тэд түүнээс хойш надтай эелдэг харьцаар байсан. Тэд надад сайхан санагдуулах жижиг зүйлсийг бас хийж байв” гэж АНУ-ын Аризона мужийн Грэйс С. хэллээ.

Зөвлөх нь бас түүнийг тавтай морилно уу гэж урьжээ. “Тэрээр Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт байхдаа хийдэг байсан зүйлсийнхээ тухай бас бидэнд ярьж өгдөг” гээд, “Тэр Хувийн хөгжил дэвшил - ийг бидэнтэй нэг бүрчлэн хамт уншиж, ойлгож байгаа эсэхэд анхаарч байсан” гэж Грэйс хэлэв.



Суралц, заа, тэгээд хуваалц

АНУ-ын Юта мужийн Жош В. нь шинэхэн дикон бөгөөд түүнээс Христийн шавь байх талаар хичээл заахыг хүсжээ. “Петр хэсэг хүмүүсийн хамт загасчилж байсан үеийн тухай судруудыг би олж уншсан. Тэд завины нэг талаас загас барих гэж хичээгээд, юу ч барьж чадаагүй.” “Тэгээд Аврагч тэдэнд завиныхаа нөгөө талаас загас барь гэж хэлэхэд, тэд маш олон загас барьсан (Лук 5:5–11 мөн Иохан 21:6–11-ийг үзнэ үү). Бид ингэж хичээл дээрээ уншсан юм. Тэгээд энэ нь бидний хувьд ямар байж болох талаар ярилцав. Бид өөрсдийнхөөрөө байхад асуудал тулгардаг. Харин Их Эзэнийг сонсох үед Тэр бидэнд тусалдаг” гээд,

Суралцах, заах, хуваалцах нь Залуу эрэгтэйчүүдийн хувьд чухал болохыг Жош хэлэв. “Бид Хүүхдийн хэсэгт их зүйл сурч, маш их үйл ажиллагаанд оролцдог байсан”

гэж тэр хэлжээ. “Бид одоо маш их зүйлийг суралцаж *мөн* хуваалцаж байна. Энэ нь сурсан зүйлсээ *хэрэгжүүлж* байгаа хэрэг юм” гэж тэр хэллээ. Жишээлбэл, санваарын хичээлийн дараа Жош сүмд удаан хугацаанд ирээгүй нэгэн найзындаа очжээ. “Түүний эцэг, эх ням гарагт ажилладаг учраас сүмд ирдэггүй.

Тэгээд би түүнийг надтай хамт явж болно гэж хэлсэн” гэж Жош хэллээ. Жош Залуу эрэгтэйчүүд болон Залуу эмэгтэйчүүдийн зорилгын талаар судалж байна. “Энэ нь бидэнд Аврагчтай хэрхэн илүү адилхан болохыг харуулдаг” гэж тэр хэлэв. Тэр “Христ рүү ирэх” урилга нь баптисм, гишүүний баталгаагаар эхлээд, ариун сүм рүү үргэлжлэн, улмаар мөнх амьдрал руу хөтлөх замаар явах гэсэн утгатай гэдгийг мэддэг.

“Би урагш тэмүүлэхэд бэлэн байна” гэж тэр хэллээ. ■



“БУРХАНЫ ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ НЬ” ХӨТӨЛБӨР ДЭЭР ХАМТ АЖИЛЛАХ НЬ

Арванхоёр настай Жон К. аавтайгаа хамт үе үе төслүүд дээр ажилладаг. Тухайлбал, одоо тэд зугаалгаар явахдаа хэрэглэх хөнжил дээрээ янз бүрийн зүйдэл хийн зүйж оёж байгаа. Тэд зүйдлүүдээ Канад, Британийн Колумб зэрэг очиж байсан газрууддаа аялал, зугаалга зэрэг янз бүрийн үйл ажиллагаанд оролцохдоо цуглуулжээ.

“Аав надад маш их тусалдаг. Би түүнгүйгээр Сүмийн төслүүдийг хийнэ гэж төсөөлж чадахгүй байна” гэж Жон хэллээ.

Жоныг 12 нас хүрэхэд, тэд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь товхимлыг хамтдаа судалж эхэлсэн юм. Тэд удалгүй Диконы хэсэг дэх “Сургаалыг ойлго” хэсэг дээр иржээ. “Аав надад санваарын түлхүүрүүд болон эрх мэдлийн тухай тайлбарласан” гэж Жон хэллээ. Энэ нь Жонд уг шаардлагуудынхаа нэгийг биелүүлэхэд тусалжээ.

“Бурханы өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхдаа аавыгаа оролцуул. Аав маань надад маш их тусалсан” гэж Жон хэллээ.



ОНЦГОЙ ГЭРЧ




**Ахлагч Д.Тодд
Кристоффэрсон**

Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

*Арванхоёр Төлөө-
лөгчийн Чуулгын
 гишүүд бол Есүс
Христийн онцгой
гэрчүүд юм.*

Есүс үнэхээр үхээд, амилсан уу?



Тийм ээ.

Би Назарын Есүс бол
амилсан Цагаатгагч
гэдгийг мэдэх гэрч
болон зогсдог.



Тэрээр
дэлхийн Бүтээгч
билээ.



Түүний гайхамшгууд
үнэн бодитой юм.



Тэрээр дахин
ирэх болно.



Бүх хүнд наманчлан,
цэвэр болох
боломжийг олгодог
Түүний ач ивээл
бодитой юм.



Бүх хүнд
амилуулалт
байгаа.

“Есүс Христийн амилалт,” Лиахона, 2014 оны 5-р сар, 132-35.

Бид өөрсдийн Аврагч Есүс Христийг дурсан санаж, бишрэн шүтдэг

Эрин Сандэрсон, Жин Бингам нар

Олон жилийн өмнө Тэнгэрлэг Эцэг Өөрийн бошиглогчдоо дэлхий рүү илгээх гэж буй гайхалтай бэлгийнхээ тухай хэлжээ. Тэрхүү бэлэг нь бидний Аврагч болохоор дэлхий рүү ирэх Түүний Хүү Есүс Христ байсан юм. Есүс биднийг Тэнгэрлэг Эцэг рүү буцаж очиж болохын тулд амьдрах замыг зааж өгөх байлаа. Бошиглогчид Есүсийг төрөх цагийг баяр хөөртэй тэсэн ядан хүлээсэн юм.

Бетлехемийн ойролцоо байсан хоньчдоо тэнгэр элчүүдийг Бурханы Хүү болох онцгой нэгэн хүү төрлөө хэмээн мэдэгдэхэд тэд баярлажээ.

Америкт нифайчууд нар жаргасан ч шөнөжин тэнгэр гэгээтэй хэвээр байсанд Түүнийг төрсөн гэдгийг мэджээ.

Өнөө үед бид Христийн мэндэлсний баяраар Есүс Христийн мэндэлснийг дурсан санаж тэмдэглэдэг. Бид Аврагчийн бусдад хайраа өгдөг үлгэр жишээг дагаснаараа Түүний бидэнд өгсөн бэлгийн төлөөх талархал, баяр хөөрөө харуулдаг. ■

Зохиогчид нь АНУ-ын Ютад амьдардаг.



СУДАР





• Иохан 14:6

ГЭР БҮЛЭЭРЭЭ ЯРИЛЦАХ САНААНУУД

Есүс Христийн хайраа харуулсан олон арга замын тухай ярилц. Гэр бүлээрээ 12-р сарын туршид бусдад хайраа харуулах арга замуудаас сонгон, Есүс Христийн үлгэр жишээг дурсан санаж, мөн уг жишээг дагаарай.

ХАЙРЫН БЭЛЭГ

Бүдүүн зураасын дагуу бэлэгний хайрцгийг хайчилж ав. Хоосон зайд өөрийнхөө бэлэгний үйл ажиллагааг бич. Тасархай зураасын дагуу нугалаад, тагийг доош наа. Бэлэгний хайрцаг бүрийн дээд хэсэгт нүх гарган, тууз тогтоо. Та нар бэлэгнүүдээ ил харагдах газар өлгөөрэй. Хэд хоног тутамд “бэлгээ” нээж, ямар нэг үйл ажиллагаа дотор нь хий. Эдгээр бэлгийг жилийн туршид өгч болно гэдгийг бүү мартаарай.



liahona.lds.org дээрх энэ үйл ажиллагааг олируулан хувилж болно.



Ахлагч
Брент Х.Нийлсон
Далын

Яанси



“Мөн эдүгээ би та нарыг даруухан, мөн хүлцэнгүй бас эелдэг байгаасай хэмээнэ” (Алма 7:23).

Ах, эгч, бид хэд морьтой болохыг үргэлж хүсдэг байлаа. Намайг ес юм уу арав орчим настай байхад аав маань маш гоё хар гүү худалдаж авсан юм. Бид түүнд Яанси гэдэг нэр өгөв. Бид морьтой болсондоо маш их сэтгэл догдлон баярлаж билээ. Гэтэл түүнийг унаж сургаагүй байжээ. Бид морь сургах хэцүү ажлыг хийж мэдэхгүй тун жаахан байсан учраас аав маань морь сайн мэддэг нэг найзаасаа Яансиг сургаж өгөөч гэж хүсэв.

Бид Яансиг харахаар байн байн талбай руу очдог байв. Морио унах өдрийг бид тэсч ядан хүлээж байлаа. Гэтэл Яансиг сургах гэж хэчнээн их чармайж оролдоод, хэн ч чадсангүй. Тэр гүү тун зөрүүд ажээ. Бидэнд түүнийг унах боломж огт гарсангүй.

Нэг өдөр аавын найз түүнийг баярын жагсаалд унаж үзүүлэх гэж оролдов. Тэрээр Яансиг унаад, замаар явах гэж байтал Яанси аавын найзыг булгиж унагачихаад, хотоор давхиж гарав. Яанси галзуу юм шиг давхиж байгаад гал түймрийн үеэр

хэрэглэдэг усны цоргонд хөлөө гэмтээчихэж. Би гүүнийхээ араас нэхэн хөөсөөр очтол тэр өвдөж шаналан, гудамжинд хэвтэж байв.

Надад тун гунигтай байлаа. Бид Яансид их хайртай байв. Хэрэв тэр сургагчдаа дуулгавартай байсан бол сайхан амьдралтай, жаргалтай гүү байх байлаа. Гэтэл тэр сургагчийгаа сонсохгүй, түүнийг дагахгүй байсан юм. Харин одоо тэр бэртчихсэн, гудамжинд хэвтэж байна.

Яансид тохиолдсон явдал бидний Багш, Аврагч Есүс Христийг дагах үед ирдэг адислалуудын тухай надад ойлгуулсан билээ. ■

БИДНИЙ ХУУДАС

Өнгөрсөн жил манай гэр бүл
тойргийнхонтойгоо Швейцарийн
ариун сүм рүү дөрөв хоногоор явсан
юм. Бямба гаргийн өглөө биднийг
Итали руу буцахаас өмнө
солонго татав.

Сариа К., нас 10, Итали



Бид Хүүхдийн нэг
үйл ажиллагаанд
зориулан гэр
бүлийн мод хийв.
Лас Хэгас тойрог,
Аргентин

Энэ бол миний
анх уншсан
Мормоны Ном.
Одоо би зарим
үгийг бас судрыг
ч уншиж чадна.

Анна Л., нас 5,
Бразил



Өнгөрсөн жил бид анх удаагаа Хүүхдийн
хэсгийн ариун ёслолын танилцуулга хийсэн.
Үүнээс долоо хоногийн өмнө биднийг бэлдэж
байх үеэр цахилгаан тасарсан ч бид дуулж,
хэлэх үгсээ давтацгаасан.

Валэнтин Брэнч, Лаос





ДЭЛХИЙ ДАЯАР НАЙЗУУДАЙ БОЛОХ НЬ

Би Шведийн Минна байна

Hallå,
Vänner!*

*Шведээр "Сайн уу, найзууд аа!"

Эми Жэйн Лэвитийн
хийсэн ярилцлагаас

Энэ бол ногооны
талбайгаасаа
миний хурааж
авсан нэгэн том
хурган хулуу.

Сургуулийн байранд амьдрахад чамд ямар санагддаг вэ? Минна гэр бүлтэйгээ Шведийн өмнөд хэсэгт хөдөө амьдардаг. Тэдний байшин олон жилийн өмнө сургуулийн байр байжээ. Хамгийн сайхан нь энэ байшин олон хүн орж болох өрөөтэй байгаа явдал байлаа. 12-р сард Миннагийн гэрийнхэн хөрш, найз нөхөд, гэр бүлүүдийг "дуулах" онцгой үйл ажиллагаанд урьдаг. Бараг л ная орчим хүн хамтдаа Христийн мэндэлсний баярын дуу дуулахаар цуглардаг аж. Тэгээд Скандинавын хүйтэн өвлөөр гадагш гарахаасаа өмнө тэд зоог барьдаг. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.





Би трамплинаас үсрэх дуртай. Бас төгөлдөр хуур, лимбэ тоглох дуртай.

Би сургууль дээрээ ганцаараа Сүмийн гишүүн учраас найз нартайгаа сайн мэдээнээс хуваалцахыг хичээдэг. Заримдаа би тэднийг Хүүхдийн хэсгийн үйл ажиллагаатай өдрүүдэд сургуулиасаа урьж авчирдаг юм. Энэ нь би яг одоо эгч нар шигээ номлогч байна гэсэн утгатай юм.

Би арван настай бөгөөд гэрийнхээ 9 хүүхдийн отгон нь юм. Хоёр эгч маань номлолд үйлчилж байгаа нэг нь Францад, нөгөө нь Ютагийн Ариун сүмийн талбайн номлолд үйлчилж байна.




Хойд зүгт Шведийн нийслэл Стокгольм руу автомашинаар явах нь гэрийнхэнтэйгээ миний хийх дуртай зүйлсийн нэг юм. Манай эмээ, өвөө болон бусад хамаатан тэнд амьдардаг бөгөөд би тэднийд зочилж очих дуртай.

Гэрийнхэн маань усанд сэлэх дуртай. Бид зун болохоор гэрийнхээ ойролцоох нуур руу очдог. Өвөл нь олон усан сан, усан гулсууртай цогцолбор руу явдаг.



БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

Шведийн Стокгольмын ариун сүм манай эмээ, өвөөгийнхтэй ойрхон байдаг. Энэ ариун сүм миний зүрх сэтгэлд онцгой байр эзэлдэг. Нэг өдөр аав, бид хоёр тэр хавиар алхаж байлаа. Бид ариун сүмийн талаар бас би хэрхэн тэнд орж болох тухай ярилцав.



ЯВАХАД БЭЛЭН БОЛЛОО!

Миннагийн цүнхэнд түүний дуртай зүйлүүд байна. Эдгээрээс алийг нь чи цүнхэндээ хийх вэ?

Христийн мэндэлсний анхны баяр

Жэн Вилкс

Та нар энэ жүжиг-
чилсэн тоглолтыг
гэр бүлийнхэн, найз
нөхөдтэйгөө эсвэл
Хүүхдийн хэсгийн-
хэнтэйгээ хийж
болно. Бэлтгэхдээ
Лук 2:1-16-г
уншина уу.

.....

ДҮРҮҮД:

Мариа

Иосеф

Дэн буудлын эзэн

1 дэх хоньчин

2 дахь хоньчин

Тэнгэр элч

.....

ХУВЦАС ӨМСГӨЛ

Иосефын
нөмрөг, Мариа-
гийн ороолт,
хоньчдын модон
таяг зэрэг хувцас
өмсгөлийг энгийн
байдлаар хий.



..... ТУСЛАХ ХЭРЭГСЛҮҮД:

Малын хашааг дүрслэхийн

тулд хоёр сандал

дээгүүр тавих

орны бүтээлэг

хонийг төлөө-

лүүлэх жи-

жиг дэрнүүд

Есүс хүүг төлөөлүү-

лэх хүүхэлдэй

эсвэл манцуйл-

сан хөнжил



Дуу: “When Joseph Went to Bethlehem,” 1-р бадаг, (*Children’s Songbook*, 38).

Мариа: Бид удахгүй хоноглох газар олно гэж найдаж байна. Бид их удаан аяллаа.

Иосеф: Тэнд өмнө маань дэн буудал байна. Тэнд бидэнд өрөө байна уу, үгүй юу, мэдээд ирье. Эндээ хүлээж байгаарай.

[Иосеф Мариаг суухад нь тусалж, дараа нь “хаалга” тогино. Дэн буудлын эзэн хариулна.]

Дэн буудлын эзэн: Та юу хүсээ вэ?

Иосеф: Би хоноглох газар хайж байна. Эхнэр бид хоёр урт зам тууллаа. Тиймээс бидэнд унтах газар хэрэгтэй байна.

Дэн буудлын эзэн: Өршөөгөөрэй. Манай буудал дүүрэн хүнтэй байгаа.

Иосеф: Та бидэнд туслаач. Эхнэр минь хөл хүндтэй, нярайлах дөхчихсөн байгаа.

Дэн буудлын эзэн: Та нар малын саравчинд хоноглож болох юм байна. Ийм л газар бидэнд байна даа.

Иосеф: Их баярлалаа. Та их сайхан сэтгэл гаргалаа.

[Иосеф Мариа дээр эргэж ирэн, түүнийг босоход тусална.]

Иосеф: Буудалд өрөө байхгүй байна. Гэхдээ буудлын эзэн биднийг малын саравчинд хоноглож болно гэлээ.

Мариа: Ашгүй дээ, бид хоноглох газартай болсонд би их баяртай байна.

[Тэд малын саравч руу очно. Мариа, Иосеф хоёр сууж, тайзны үзэгдэл төгсөнө.]

Дуу: “When Joseph Went to Bethlehem,” 2, 3-р бадаг (*Children’s Songbook*, 38).

[Хоньчид хонио хариулж явна. Тэнгэр элчийг ирэхэд тэд өвдөг сөгдөн сууна.]

1 дэх хоньчин: Та хэн бэ?

2 дахь хоньчин: Биднийг битгий өвтгөөч.

Тэнгэр элч: Бүү айгтун, харагтун, би сайн мэдээ авчирлаа! Урд шөнө Бурханы Хүү Бетлехемд мэндэллээ. Тэжээлийн тэвшинд нялх хүүхдийг та нар олж харна.

1 дэх хоньчин: Одоо явж, хүүхдийг үзье.

Тэнгэр элч: Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор

газарт амар тайван нь хүмүүст байх болтугай.

Дуу: “Stars Were Gleaming” (*Children’s Songbook*, 37).

[Хоньчид буудал руу очин, буудлын “хаалгыг” тогино. Буудлын эзэн хариулна.]

2 дахь хоньчин: Бид Христ хүүг харахаар ирлээ.

1 дэх хоньчин: Тэнгэр элч бидэнд Түүнийг малын тэвшинд байгаа гэж хэллээ.

2 дахь хоньчин: Та Түүнийг хаана байгааг мэдэх үү?

Дэн буудлын эзэн: Нэг хүү манай малын саравчинд төрсөн. Би та нарт хаана байгааг зааж өгье.

[Хоньчид буудлын эзнийг даган, малын саравч руу очно. Тэнд Мариа, Иосеф хоёр тэвшинд

байгаа Есүс хүүгийн хажууд сууж байна.]

1 дэх хоньчин: Энэ үнэн байна шүү! Тэнгэр элчийн яг хэлсэнчлэн,

үнэхээр тэнд тэвшинд хүү байна.

2 дахь хоньчин: Энэ бол Аврагч, Эзэн Христ.

[Хоньчид болон дэн буудлын эзэн бүгд тэвшийг тойрон өвдөглөн сууна.]

Дуу: “Амгалан шөнө” (*Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, 53. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



САНАА:

Үзэгчдийг дүрд жүжиглэсэн хүүхдүүдтэй хамт дуулуул.



САНАА:

Савааны үзүүрт том цаасан од хатган, малын хашаан дээр барина.

Доторхыг нь хар даа!



София С., нас 9, Бразил

Христийн мэндэлсний баярын Хөмнө аав, ээж хоёр хайрцаг дүүрэн Мормоны Ном хүмүүст өгөхөөр худалдаж авсан юм. Тэгээд би сургууль руугаа хэдийг авч яваад, гурван багшдаа бэлэг болгон өгье гэж бодлоо.

Би хөгжмийн өрөө рүү явж байтал хөгжмийн багштайгаа тааралдав. Гэтэл “За, София. Түүнд нэгийг өг” гэж бодогдлоо. Тэгээд багш руугаа аажуухан алхав. Тэгсэн ч би түүнд номоо өгөх зориг хүрсэнгүй.

Би өрөөний булан руу очоод, “Тэнгэрлэг Эцэг минь, энэ номыг багшдаа өгөхөд минь туслаач” гэж чимээгүйхэн залбирав. Дөнгөж залбирч дуустал, номоо түүнд өгөх хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж төрөв.

Би багш руугаа дөхөж очив. Түүнийг над руу харахад нь би Мормоны Номоо өгөөд, “Багш аа, би танд зүрх сэтгэлийнхээ угаас хайртай, тэгээд би танд энэ номыг өгөхийг хүссэн юм” гэж хэллээ.

Багш номыг аваад, хавтас руу нь харав. “Доторхыг нь хар даа” гэж би хэллээ. Намайг дотор талд нь хэдэн үг бичсэнийг тэр олж харав.

Багш маань намайг тэврээд, “София, надад ийм ном өгсөнд баярлалаа!” гэлээ.

Намайг суухад багш ангийнханд “София надад юу өгснийг хар даа. Би үүнийг амралтынхаа үеэр уншина” гэж хэлэв.

Би гэртээ ирж, ээж рүүгээ гүйж очоод, “Юу болсныг таа даа! Би багшдаа Мормоны Ном өгсөн” гэж хэллээ.

Ээж инээмсэглээд, “Гайхалтай! София, чи надад маш гайхалтай үлгэр жишээ үзүүлээ” гэж хэлжээ.

Ээж, бид хоёр багшдаа Мормоны Ном өгөх зориг өгсөнд нь Тэнгэрлэг Эцэгт талархахаар шийдлээ. ■


Давид ба Голиат

1 Самуел 17

Энэ хуудсыг хатуу цаасан дээр эсвэл картонон цаасан дээр наа. Тэгээд дүрсүүдийг хайчилж аваад, хийсэн саваан дээр эсвэл цаасан уутан дээр тогтоо. Та эдгээрийг Хуучин Гэрээний дуртай түүхүүдээс жүжигчлэн тоглохдоо ашиглаж болно. ■



Голиат



Давид



Давид

Христийн мэндэлсний баярын уур

*Бүх бэлгийг боож, гацуур модны дэргэд
байрлуулсан байдаг. Тийм үү?*

Кэйт Стронгин

Бодит түүхээс сэдэвлэв

*"Have a very merry Christmas!
Scatter gladness ev'rywhere!"
(Children's Songbook, 51).*

Христийн мэндэлсний баяр дөхлөө. Амалигийн сэтгэл тун догдолжээ. Тэр бэлэгнүүдээ баглан, гацуур модны дэргэд тавина!

Гэр бүлийн үдшээр ээжийн хичээл заах ээлж болов.

"Христийн мэндэлсний баяраар бид яагаад бэлэг өгдөг вэ?" гэж ээж асуув.

"Яагаад гэвэл, энэ бол Есүсийн төрсөн өдөр" гэж Амалийг хэлэхэд,

"Тэгвэл бид Түүнд бэлэг өгөх хэрэгтэй биш үү?" гэж ээж нь хэллээ.

Аав нь Амалигийн дүү Ноад судар уншихад нь тусалжээ. Энд бид бусдад үйлчилж байгаа нь Бурхандаа үйлчилж байгаа хэрэг гэж бичсэн байна (Мозая 2:17-г үзнэ үү).

"Бусдад үйлчлэх нь Есүст өгөх бэлэг үү?" гэж ээж нь хэлэхэд

Ноа толгой дохив.

"Өөр юу байдаг билээ?"

"Зарлигуудыг сахих" гэж Амалийг хэлэхэд.

"Сайн хүүхэд байх" гэж Ноа хэллээ.

"Сайхан санаанууд байна!" гэж ээж хэлэв. "За, одоо тоглоом тоглоцгооё. Есүст хэн нэгний өгсөн бэлгийг би одоо хэлнэ. Та нар надад хэн гэдгийг нь хэлээрэй. За, эхэлье. Энэ хүн Халамжийн төв дээр Христийн мэндэлсний баярын ил захидлыг тараан өгсөн."

Ноа гараа өргөн, "Амали үүнийг хийсэн" гэж хэлэв.

"Тэр хүн гэрийн багшаар явсан."



амьсгалыг өдөр бүр мэдрэх нь

“Энэ бол аав” гэж Амали хэлэв.

Аврагчид тэдний аль хэдийн өгсөн олон бэлгийг нэрлэж дуусав.

“Бид өдөр бүр бэлэг өгч болно” гэж ээж хэллээ.

Маргааш өглөө нь гэрээ цэвэрлэх болов. “Өө, яршиг” гэж Амали гонгинолоо. Гэтэл тэр гэнэт нэг зүйлийг санав. Бусдад үйлчлэх нь бэлэг шүү дээ! Хэрэв Амали ээждээ тусалбал Есүст тусалсантай адил хэрэг болно. Тэрээр даавуу олоод, өрөөний

буланг гялалзтал арчив.

Маргааш нь Амали ажил хийж, бага зэрэг мөнгө олжээ.

“Чиний аравны нэг чинь найман цент болно” гэж ээж нь хэлэв.

Амали дахиад нэг зүйлийг санав. Аравны нэгээ төлөх нь зарлиг. Тиймээс аравны нэгийг төлөх нь бэлэг болно. Тэгээд тэрээр найман центээ аравны нэгээ хадгалдаг савандаа хийв.

Тэр долоо хоногийнхоо сүүлээр ч Амали дэр хураахад тусалжээ. Жаахан дүү нь

тэр дэрнүүдийг буйдангаас буулгачихсан байж. “Есүст өгөх бас нэгэн бэлэг” гэж тэр хэлэв.

Христийн мэндэлсний баярын өмнөх орой аав, ээж хоёр нь Амалид өөрөөр нь бахархаж байгаагаа хэлжээ. “Чи долоо хоногийн турш Есүст бэлэг өгч байна. Энэ чинь Христийн мэндэлсний баярын уур амьсгалыг өдөр бүр мэдрч байгаа гэсэн үг” гэж аав нь хэлэв. ■

Энэ өгүүллийг зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.





**Ахлагч Мэлвин
Ж.Баллард
(1873–1939)**

Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын


ТЭР АМЬДЫГ БИ МЭДНЭ

*Би ямар байгаа, ямар байхаар найдаж
байгаа, юу мэдэрснээ мэдэхийг хүсэж
байгаа зэрэг өөртөө байгаа бүхнийг
өгөх болно.*

Тэнгэр дэх Эцэг маань Хайрт Хүүгээ бидэнд бэлэг болгон өгөхдөө хийсэн золиослолыг болон дэлхийг гэтэлгэж, биднийг аврахын төлөө; биднийг энэ амьдралынхаа замаар алхаж байхад биднийг сүнсэлэг байдлын хувьд тэтгэхийн тулд; бид явж очин, мөнхийн дэлхийнүүдэд Түүнтэй хамт оршиж болохын төлөө Өөрийн амийг өгч, биднийг хайрласан, бидний Эцэгийн тэрхүү зохист Хүүгийн тухай би бясалган бодох дуртай. . . .

Би [Аврагчийн] үхэл, Түүний цовдлолт мөн амилаат үнэн бодитойг өөрийн бодгальд гэрчилсэн туршлагаа . . . эргэн санаж, үүнийг хэзээ ч мартахгүй. . . .

. . . Би нэг шөнө зүүдэндээ өөрийгөө тэрхүү ариун барилга болох ариун сүмд байна гэж харав. Намайг залбирч, зүрх сэтгэлдээ баяр баяслыг мэдэрсний дараа эдгээр өрөөний нэгэнд орох завшаан олдож байна гэж надад хэлэв. Сүр жавхлант нэгэнтэй



уулзахын тулд хаалгаар ороход өндөрсгөсөн тавцан дээр суусан, миний нүдээрээ болгоож байсан буюу төсөөлж байснаас ч илүү, хамгийн сүр жавхлантай нэгнийг мөнхийн дэлхийнүүд дээр оршиж байхыг харсан билээ.

Намайг өөрийгөө танилцуулахаар дөхөж очтол Тэр босч, гараа дэлгээд, над руу чиглэн ирэв. Тэр инээмсэглэн, миний нэрийг аяархан хэлэв. Би сая жил насалсан ч тэр инээмсэглэлийг хэзээ ч мартахгүй. Тэрээр намайг гартаа өргөн үнсээд, цээжиндээ чанга тэврэн адислахад бүх биеэр минь халуу оргин төөнөх шиг боллоо! Түүнийг ийнхүү дуусгахад би хөлд нь унан, хөлийг нь нулимсаараа угааж, дахин дахин

үнсэх үедээ дэлхийн Гэтэлгэгчийн хөлөн дэх хадаасны сорвийг харлаа. Бүх зүйлийг мутартаа атгадаг Түүний дэргэд байж, Түүний хайр энэрэл, анхаарал халамж, адислалыг хүлээж авахын тулд би өмнө нь өөртөө байсан бүхнийг, одоо байгаа бүхнээ, ямар хүн байхаар найддаг тэр бүхнээ, энд мэдэрсэн зүйлээ үргэлж мэдэрч байхын төлөө бүгдийг нь өгөхсөн!

. . . Би Есүсийг тэр үед загалмай дээр байхгүй байгааг харсан. Түүний духыг өргөс хатгасныг эсвэл Түүний гарыг хадаас цоо хатгасныг би хараагүй ч Түүний гараа алдлан инээмсэглэж, “Над уруу ир!” хэмээн бид бүгдэд хэлж байхыг харсан. ■

Тол, жишгийг үсгээр бичих дүрмийг стандартад оруулав.

Брайнт С.Хинкли, Sermons and Missionary Services of Melvin Joseph Ballard (1949), 147–57, “Classic Discourses from the General Authorities: The Sacramental Covenant”-д хэвлэгдсэнээр, New Era, 1976 оны 1-р сар, 7–11.

ОЙЛГОЛТ



Есүс Христ ямар арга замаар дэлхийн гэрэл болдог вэ?

“Есүс Христ бол мөнх бус Мариа эх болон Бүхнийг Чадагч Бурхан Эцэгээс төрсөн Бетлехемийн Гэрэл юм. . . . Тэрээр бүх хүн төрөлхтөн мөнх авралыг олж авч болохын тулд дэлхийн нүглүүдийг Өөр дээрээ аван Гетсеманийн цэцэрлэг болон Голгат дээр гүйцэлдсэн Цагаатгалын Гэрэл билээ. Тэр бол алдар суут яс махан биеэр амилж, үхлийн хүлээсийг тасдан үхлийг ялан мөнхийн ялалтыг олж авсан хоосон булшны Гэрэл юм. . . . Тэр миний Гэрэл, миний Гэтэлгэгч, миний аврагч-бас таных.”

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Бүх хэцүү асуултын **ХАРИУЛТ**

Ерөнхийлөгч Угдорф бидэнд зөвлөхдөө итгэлдээ эргэлзэхээс өмнө эргэлзээндээ эргэлзэхийг зөвлөсөн юм. Тиймээс та хэрхэн өөрийнхөө эргэлзэж байгаадаа эргэлзэж, итгэлээр урагш тэмүүлж чадах вэ?



44

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

АВРАГЧ БА АРИУН ЁСЛОЛ

Та нар ариун ёслолыг бэлтгэж, адисалж, түгээхдээ эсвэл үүнээс хүртэж байхдаа юуны тухай бодох хэрэгтэй вэ?



48

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Христийн мэндэлсний анхны баяр

Христийн төрөлтийн тухай жүжиг тоглож, Христийн мэндэлсний баярын түүхийг амилуулаарай!



74

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ